

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

/2017 ОНЫ 08 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР/

УЛААНБААТАР ХОТ
2017 ОН

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

2017.08.31

| № | Агуулга | Зорилтын тоо | Хэрэгжилтийн явц | | | | | Хувь % |
|-----|---|--------------|------------------|-----------|-----------|-----------|---------------------|--------------|
| | | | 100 | 90 | 70 | 50 | Үнэлэх боломжгүй | |
| 1 | ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ - НИЙГМИЙН ХӨГЖИЛ | 31 | 1 | 7 | 19 | 3 | 1 | 73,6 |
| 2 | ЖАРГАЛТАЙ ИРЭЭДҮЙ - ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ | 36 | - | 4 | 27 | 5 | - | 69,4 |
| 3 | ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ - ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ | 14 | 1 | 2 | 8 | 3 | - | 70,7 |
| 4 | ЖАРГАЛТАЙ ОРЧИН - НОГООН ХӨГЖИЛ | 12 | - | 7 | 5 | - | - | 81,6 |
| 5 | ЖАРГАЛТАЙ ИРГЭН - НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ | 28 | 3 | - | 22 | 3 | - | 71,0 |
| Дүн | | 121 | 5 | 20 | 81 | 14 | 1 | 72,25 |

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| № | Дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Зорилтод түвшин, үр дүн | 2017 онд санхүүжигдэх төсөв | Хүрсэн түвшин хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|--|---|-------------------------|------------------------------|---|-------------------|
| 1. ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ-НИЙГМИЙН ХӨГЖИЛ | | | | | | | |
| 1.1 ЭРҮҮЛ МЭНД, СПОРТ | | | | | | | |
| 1 | 1.1.1 Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулах, иргэний бүртгэл мэдээллийн технологийг боловсронгуй болгох “Эрүүл мэнд 2020” | 1. "Эрүүл мэнд 2020" хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллана. | Боловсруулах баримт бичгийн явц, хувиар | 30% | Дүүргийн төсөв 200.0 | Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Эрүүл мэнд 2020” хөтөлбөрийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, нийгмийн ажилтан, сайн дурын идэвхтэн нийт 74 хүнээс хөтөлбөрт тусгах саналыг авч тусган, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлуулсан ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх 41 үйл ажиллагааг хяналтанд авч, хэрэгжилтийг ханган ажиллалаа. | 70 |
| 2 | хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлнэ. | 2. Эрүүл мэнд 2020 хөтөлбөрийн хүрээнд дүүргийн иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг шинэчилж, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хийж | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 50% | Дүүргийн төсөв, гүйцэтгэлээр | Иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг шинэчилж, цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Ehealth програм хангамжийг Эрүүл мэндийн төвийн 23 кабинетэд нэвтрүүлсэн. Өрхийн эрүүл мэндийн төвийг Эрүүл мэндийн төвтэй шилэн кабельд холбохоор тендер зарлагдсан. Цахим эрүүл мэнд” төслийн “E-Health” програм хангамжийг Эрүүл мэндийн сайдын 2016 оны 1а/3366 тоот албан даалгаварт заасан хугацаанд багтаан суурьлуулсан бөгөөд Төв, Бага тойруу, Хайлааст салбарууд, Хүүхдийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|--|------------------------------------|-----|----------------------------|--|----|
| | | хэрэгжүүлнэ. | | | | амбулаториудын хэмжээнд ашиглаж байна. Тус програмд нийт 371 эмч, мэргэжилтнүүд хандан ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 49106 үйлчлүүлэгчийн бүртгэлийн сан үүсгэсэн. Ehealth програмыг ашигласнаар иргэний эрүүл мэндийн даатгалыг цахим бүртгэлээс шууд онлайн хэлбэрээр шалгадаг болсон ба эрчимт эмчилгээний өрөөг сахиурын өрөөтэй холбож, 5 минут тутамд үйлчлүүлэгчийн биеийн байдлыг ар гэрийнхэнд нь автоматаар мэдээлж, шууд холбогдох боломжийг бүрдүүлсэн. Бага тойруу салбарт мэс заслын тасаг шинээр нээх ажлын хүрээнд зарлан мэдээллэх систем, мэдээллийн ил тод байдлыг илтгэх дэлгэц, хяналтын IP Camer, дотоод холбооны IP Phone зэрэг дэд системүүдийг шинээр суурилуулан, дотоод сүлжээний шинэчлэлийг хийсэн. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан төсвийн хүрээнд 5 ширхэг компьютер, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн тойрогт хуваарилагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар 7-11, 13-14, 16-19 дүгээр хороодын Өрхийн эрүүл мэндийн төвд 11 ширхэг компьютер, 11 ширхэг принтер олгосон. | |
| 3 | 1.1.2 Дүүргийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан хүүхдийн эмнэлэг, яаралтай түргэн тусламжийн төв, Амбулатори-2-ийн барилгыг барихад хамтран ажиллана. | 1. Дүүргийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан хүүхдийн эмнэлэг, яаралтай түргэн тусламжийн төв, Амбулатори-2-ийн барилгыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангана. | Барилгын бэлтгэл ажлын явц, хувиар | 30% | Батлагдсан төсвийн хүрээнд | Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дүүргийн 15 дугаар хороонд Хүүхдийн нэгдсэн эмнэлгийг барих шийдвэр гарснаар Архитектур төлөвлөлтийн даалгавар гарч, “Онцгой байдлын газар, Барилгын хөгжлийн төвөөр зургийг хянуулсан боловч гадна инженерийн шугам сүлжээ, гадна тохижилтын зургийг хамт хийхээр болж дахин ажлын зураг хийж байна. 14 дүгээр хороонд Яаралтай түргэн тусламжийн төв барих 3 байршилд 6 нэгж талбарын газар чөлөөлөх ажил хийгдэхээс 2 нэгж талбарын үнэлгээ хийгдэж, Нийслэлийн Засаг Даргын захирамжаар нөхөн олговор олгогдохоор хүлээгдэж байна. 1 айлын газрыг дүүргийн 16 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|------|--------------------|--|----|
| | | | | | | дугаар хороонд байршил заан шилжүүлсэн. Амбулатори-2 буюу Хайлааст салбарын барилгын зургийн ажил хийгдэхээр худалдан авах ажиллагааны тендер зарлагдсан. | |
| 4 | 1.1.3 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулна. | 1. Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн хүүхдүүдийн дунд хорт зуршлаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулна. | Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан сурагчийн тоо | 100% | Дүүргийн төсөв 5.0 | Дүүргийн 25 жилийн ой хүрээнд өсвөр насны охид, хөвгүүдийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 11 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж давхардсан тоогоор 13865 хүүхэд өсвөр үеийнхэн хамруулсан нь өмнөх оны мөн үеийн түвшингээс 5,2 хувиар ахисан үзүүлэлттэй байна. “Бидний Ирээдүй хүчирхэг охид” сэдэвт охидын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх өдөрлөг зохион байгуулж нийт 180 охидыг хамруулсан. 57, 37, 49-р сургуулийн төгсөх ангийн 236 хүүхдэд “Архи тамхи мансууруулах бодисоос хэрхэн сэргийлэх, түүний хор уршиг” сэдвээр тус бүр 2 цагийн мэдээлэл, харилцан ярилцлага хийсэн бол 5, 50, 24, 23, 57, 61, 37, 39, 49-р сургуулийн ахлах ангийн сурагчдад “Эрүүл амьдралын зөв зан үйлд хандуулах бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд” сургалтыг зохион байгуулж нийт 1294 өсвөр үеийнхэнийг хамрууллаа. Мөн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг олгох нь” аяны хүрээнд Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Хайлааст болон Чингэлтэй ОНХХ-тэй хамтран 200 гаруй хүүхдээс санамсаргүй түүврийн аргаар асуумж авч, танин мэдэхүйн “АХА” тэмцээн зохион байгууллаа. Дэлхийн тамхины эсрэг өдрийг угтан “Өсвөр үеийнхний эрсдэлт зан үйл” сэдэвт сургалтыг дүүргийн ерөнхий боловсролын 37, 17, 49, 117, 72-р сургуулийн “Эмч бүлгэм”-ийн 30 сурагчдад зохион байгуулж сургагч багшаар бэлтгэлээ. Сургагч багш, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэйгээ хамтран “Дэлхийн тамхигүй өдөр”, “Тамхинд үгүй гэж хэлье” уриатайгаар өдөрлөг зохион байгуулж | 70 |

| | | | | | | | |
|---|--|--|--|------|---------------------|---|----|
| | | | | | | 700 гаруй сурагчдыг хамруулсан байна. Мөн 117, 17, 37, 49, 72-р сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Бэлгийн болон Нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрт жирэмслэлтээс сэргийлэх нь” сэдэвт 1 сарын аяны хүрээнд сургалт зохион байгуулж нийт 1044 сурагчдыг хамруулсан. | |
| 5 | | 2. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна. | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо | 100% | Дүүргийн төсөв 5.0 | Дүүргийн хэмжээнд 2017 оны эхний 8 сарын байдлаар 824 удаагийн сургалт, сурталчилгааны ажилд давхардсан тоогоор 28840 хүнийг хамруулж, 341 төрлийн давхардсан тоогоор 72.941 ширхэг сурталчилгааны материал тараасан. Тайлант хугацаанд эрүүл мэндийн өдөрлөгийг 70 удаа зохион байгуулж нийт 34166 хүнийг хамруулж, 38 удаагийн аянд давхардсан тоогоор 19398 хүнийг хамруулан иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлсэн байна. | 70 |
| 6 | 1.1.4 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх олон төрөлт уралдаан тэмцээн зохион байгуулна. | 1. Хүүхэд, залуучууд, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтан албан хаагчид, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын олон төрөлт уралдаан тэмцээн зохион байгуулна. | Зохион байгуулагдсан тэмцээн, хамрагдсан хүний тоо | 100% | Дүүргийн төсөв 50.0 | Дүүргийн аварга шалгаруулах өсвөр үеийн тэмцээнийг спортын 14 төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 130 байгууллагын 2250 тамирчин оролцсон. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлын хүрээнд Ахмадын 6 төрөлт тэмцээнд 95 байгууллагын 948 тамирчин, Залуучуудын 6 төрөлт тэмцээнд 59 байгууллагын 529 тамирчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 3 төрөлт тэмцээнд 11 байгууллагын 37 тамирчин, төрийн болон төрийн бус аж ахуй нэгж байгууллагын дунд 10 удаагийн арга хэмжээ зохион байгуулж 79 байгууллагын 1500 тамирчин оролцлоо. Нийт 32 арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 390 байгууллагын 20549 иргэд оролцсон. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Улаанбаатар марафон 2017 олон улсын гүйлтэнд зориулсан үйл ажиллагааг дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулж 82 | 90 |

| | | | | | | | |
|---|--|--|--|------|-------------------------|--|----|
| | | | | | | байгууллагын 5704 иргэнийг хамрууллаа. Монгол Улсын ерөнхийлөгчийн 53 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах хүрээнд 83 байгууллагын 11631 албан хаагчийг бие бялдарын сорил авах үйл ажиллагаанд хамруулаад байна. | |
| 7 | | 2. Үндэсний, Монголын, Хүүхдийн, Оюутны бүх ард түмний спортын их наадмуудыг зохион байгуулна. | Спортын тэмцээн уралдаанд хамрагдсан хүний тоо | 100% | Дүүргийн төсөв 20.0 | Монголын оюутны спортын IV их наадмын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг их дээд сургуулийн оюутан залуучуудын дунд дүүргийн аварга шалгаруулах 4 төрөлт тэмцээнийг зохион байгууллахаар бэлтгэл ажлыг ханган ажиллалаа. Мөн дүүргийн иргэдийн спортын VI их наадмыг зохион байгуулах ажлын хүрээнд тэмцээн зохион байгуулах хуваарь төрлийг тусгасан плакат хийж хороодуудад тарааж, хэсэг болон хорооны аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулж байна. | 50 |
| 8 | 1.1.5 Дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлж, бэлтгэл сургуулилтыг тогтмолжуулан, Залуучуудын шигшээ багийг хөгжүүлнэ. | 1. Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тоог нэмэгдүүлж, гадаад дотоодын уралдаан тэмцээнд тогтмол хамруулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | Дүүргийн төсөв 130.0 | Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 13 төрлөөр хичээллүүлж, шигшээ багуудын дасгалжуулагч нартай гэрээ байгуулан, шигшээ багуудын тамирчдын бэлтгэл сургуулилт хийх нөхцөл бололцоогоор бүрэн хангаж ажилласны үр дүнд тайлант хугацаанд нийт 65 удаагийн тэмцээнд оролцож Нэрэмжит тэмцээнээс 26 алт 24 мөнгө 26 хүрэл медаль Хотын аварга шалгаруулах тэмцээнээс 16 алт 13 мөнгө 120 хүрэл медаль, улсын аварга шалгаруулах тэмцээнээс 11 алт 8 мөнгө 19 хүрэл медаль, олон улсын тэмцээнээс 24 алт 17 мөнгө 19 хүрэл медаль, ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 1 алт 3 мөнгө 2 хүрэл медаль, нийт 249 медаль хүртсэн амжилттай байна | 90 |
| 9 | 1.1.6 Дүүрэгт баригдаж буй 1000 хүний суудалтай спорт | 1. Дүүргийн 61 дүгээр сургуулийн спорт заалны барилга, | Барилгын ажлын явц, хувиар | 60% | Нийслэлийн төсөв 1430.0 | Дүүргийн усан бассейн мөсөн гулгуурын талбай бүхий 1000 хүний суудалтай спорт цогцолборын барилгын ажил 45 хувийн гүйцэтгэлтэй байгаа ба 2017 оны улсын төсөвт | 50 |

| | | | | | | | |
|--|--|--|--|--|--|---|--|
| | цогцолбор, 61 дүгээр сургуулийн спорт заалны ажлыг дуусгаж ашиглалтад оруулна. | 1000 хүний суудалтай спорт цогцолборын барилгыг үргэлжлүүлэн барина. | | | | 1 тэрбум төгрөг батлагдаж, барилгын гүйцэтгэгч компанийн дансанд шилжин орсноор барилгын техникийн нөхцөлүүдийг шинэчлэн гаргуулж байна. 61 дүгээр сургуулийн биеийн тамирын заалны барилгын одоогийн ажлын гүйцэтгэлд яамны ажлын хэсэг ажиллаж үнэлгээ хийж, барилга угсралтын ажилд технологийн алдаа, дутагдал гарсаныг тогтоон энэ онд засварлуулахаар болсон. | |
|--|--|--|--|--|--|---|--|

1.2 БОЛОВСРОЛ, СОЁЛ

| | | | | | | | |
|----|---|---|-----------------------------|-----|---|--|----|
| 10 | 1.2.1 Шинээр сургууль, цэцэрлэг барих, өргөтгөх замаар цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургуулийн анги дүүргэлтийг стандарт түвшинд хүргэх "Жаргалтай үрс" төслийг хэрэгжүүлнэ. | 1. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, анги дүүргэлтийг стандарт түвшинд ойртуулах "Жаргалтай үрс" төслийг боловсруулан батлуулна. | Төслийн хэрэгжилтийн хувиар | 30% | - | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8 дугаар хороонд баригдсан 245 дугаар цэцэрлэг, 16 дугаар хороонд баригдсан 246 дугаар цэцэрлэг, 18 дугаар хороонд баригдсан 247 дугаар цэцэрлэг, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 16 дугаар хороонд баригдсан 139 дүгээр бага сургууль, 221 дүгээр цэцэрлэг, 17 дугаар хороонд баригдсан 140 дүгээр бага сургууль, 222 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулан хүүхдээ хүлээн авлаа. 246 дугаар цэцэрлэгт 166, 246 дугаар цэцэрлэгт 151, 247 дугаар цэцэрлэгт 180, 221 дүгээр цэцэрлэгт 145, 222 дугаар цэцэрлэгт 191 хүүхэд багачууд тус тус суралцсанаар цэцэрлэгийн хамран сургалт 5,3 хувиар өссөн байна. Дүүргийн төсвийн 1,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18 дугаар цэцэрлэгийг 240 хүүхдийн ортойгоор шинэчлэн барих, нийслэлийн төсвийн 2,05 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 11 дүгээр хороонд цэцэрлэг барих ажлын тендер тус тус зарлагдсан бол нийслэлийн төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 19 дүгээр цэцэрлэгийн 150 хүүхдийн ортой өргөтгөлийн барилгын цутгалтын ажил, 2,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 102 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн | 70 |
|----|---|---|-----------------------------|-----|---|--|----|

| | | | | | | | |
|----|--------------------------|---|--------------------------------|------|---|--|-----|
| | | | | | | барилгын дотор заслын ажил хийгдэж байна. | |
| 11 | | 2. Төрийн өмчийн болон нийслэлийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтад зарим цэцэрлэг, сургуулийг өргөтгөх, шинээр барих ажлыг тусгуулан хэрэгжүүлнэ. | Барилгын ажлын явц, хувиар | 30% | Төрийн өмчийн болон нийслэлийн өмчийн концессын гэрээгээр | Төрийн өмчийн болон нийслэлийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтад Дүүргийн 5, 23, 24, 50 дугаар сургуулийн өргөтгөлийн барилга, 33, 39 дүгээр цэцэрлэгийн барилгыг буулгаж шинэчлэхээр саналаа тусган батлуулж, нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, нийслэлийн Боловсролын газраас албаны хүмүүс ирж судалгаа шинжилгээний ажил хийсэн. Концессоор он дамжин хэрэгжсэн 83 дугаар цэцэрлэгийн 240 хүүхдийн ортой өргөтгөлийн ажлыг бүрэн дуусган хүүхдээ хүлээн авахад бэлэн болсон бөгөөд тус өргөтгөлийн хэв шинжийг 24 цагийн үйл ажиллагаатай болгож 70 дугаар цэцэрлэгийн хүүхдүүдийг шилжүүлээд байна. | 70 |
| 12 | | 3. Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд цэцэрлэгийн салбар бүлэг байгуулах үйл ажиллагааг дэмжиж, сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Цэцэрлэгт хамрагдалтын тоогоор | 30% | - | Тагнуулын ерөнхий газрын санаачлагаар 4 дүгээр цэцэрлэгийн 2 салбар бүлгийг тус байгууллагын харьяанд ажиллуулж 70 гаруй хүүхдийг хамруулж байна. Мөн 37 дугаар цэцэрлэгийн 2 бүлгийг Хөдөлмөрийн яамны дэргэд ажиллуулахаар улсын төсвийн 70,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засвар, тохижилтын ажил хийгдэж байна. | 70 |
| 13 | | 4. Шаардлагатай цэцэрлэгүүдэд нэмэлт бүлгийн байр барина. | Барилгын ажлын явц, хувиар | 100% | Дүүргийн төсөв 150.0 | Дүүргийн төсвийн 150,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 70 дугаар цэцэрлэгт 2 нэмэлт бүлгийн байрыг “Рэжэнтрийл Эстейт” ХХК, 278,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 126 дугаар цэцэрлэгт 4 нэмэлт бүлгийн байрыг барих ажлыг “Их даян бүүвэй” ХХК тус тус хийж гүйцэтгэсэн. | 100 |
| 14 | 1.2.2 Төрөөс боловсролын | 1. Хүүхдийн хөгжлийг бүх | Үйл ажиллагааны | 100% | - | Дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Би монгол хүүхэд” уралдааныг зохион | 70 |

| | | | | | | | |
|--|---|---|--------------------------|--|--|---|--|
| | <p>талаар баримтлах бодлого чиглэлийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх "Чингэлтэйн боловсрол" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ.</p> | <p>талаар дэмжин "Өв тэгш-бүтээгч Монгол хүүхэд" төлөвшүүлнэ.</p> | <p>хэрэгжилт, хувиар</p> | | | <p>байгуулж дүүргийн төрийн өмчийн 12 сургуулийн 60 сурагч хамрагдсан. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 96 жилийн ой, Чингэлтэй дүүрэг байгуулагдсаны 25 жил, “Эрүүл мэндийг дэмжих” жилийн хүрээнд дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэг спортын "Дөл" тэмцээнийг зохион байгуулж төрийн өмчийн 12 сургуулийн 300 гаруй сурагч оролцож 24 дүгээр сургууль шилдгээр тодорсон бөгөөд нийслэлийн тэмцээнд амжилттай оролцон 3 дугаар байр эзэлсэн. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын 6-9-р ангийн сурагчдын дунд “Ирээдүйн эзэн-Оюунлаг Чингэлтэйчүүд” математикийн уралдааныг зохион байгуулж, төрийн өмчийн 12 сургуулийн 218 бүлгийн 7535 сурагч хамрагдсан бөгөөд сар бүрийн төгсгөлийн шалгаруулалтад 192 бүлгийн 6120 сурагч оролцсон байна. Мөн тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны ойд зориулсан “Тусгаар тогтнол” математикийн улсын хэмжээний олимпиадыг Олонлог сургуультай хамтран 3 дахь жилдээ зохион байгуулсан. “Сургуулийн өмнөх боловсролын шинэчлэл” ТББ-тай хамтран хүүхдийн бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх зорилгоор “Цэгээр наадъя” төслийг хэрэгжүүлж дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн 25 цэцэрлэгийн 84 багш, 7000 гаруй хүүхэд хамрагдсан. “Замын хөдөлгөөний цагаан толгой-2017” тэмцээнийг зохион байгуулж 18 цэцэрлэгийн 216 хүүхэд, 36 багш оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорьсноос тэргүүн байранд 33 дугаар цэцэрлэг шалгарч нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож 1 дүгээр байр эзэлсэн. “Математикийн сорил-2017” уралдааныг 24 дүгээр сургуультай хамтран 12 дугаар ангиа төгсөж элсэлтийн ерөнхий шалгалт өгөх сурагчдын дунд зохион</p> | |
|--|---|---|--------------------------|--|--|---|--|

| | | | | | | | |
|----|--|---|-----------------------------------|------|----------------------|--|----|
| | | | | | | байгуулж, 12 дугаар ангийн 1181 хүүхэд хамрагдаж шилдгүүдээ тодруулсан. “Монгол хүн” хүмүүжлийн аяны хүрээнд “Мэргэжил бүхэн сайхан” сэдвийн дагуу УИХ-ын залуу гишүүдийн лекц, уулзалтад дүүргийн 12 дугаар ангийн 1500 гаруй сурагчдыг хамруулсан. 2016-2017 оны хичээлийн жилд цэцэрлэгүүдийн дунд “Бид бүгдээрээ хөгжимчин” төсөлт ажлыг 2 үе шаттайгаар амжилттай зохион байгууллаа. Тус төсөлт ажил амжилттай оролцсон 9 цэцэрлэгийн тоглолтыг нийслэлийн хэмжээнд үзүүлэх ажил байдлаар олны хүртээл болголоо. | |
| 15 | | 2. "Чингэлтэйн боловсрол-2020" хөтөлбөрийг боловсруулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана. | Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар | 30% | Дүүргийн төсөв 150.0 | Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Чингэлтэйн боловсрол-2020” хөтөлбөрийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 29 дүгээр тогтоолоор батлуулсан ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх 20 үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллалаа. | 70 |
| 16 | | 3. Багшийн ажиллах нөхцлийг сайжруулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагаа зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | Багшийн ажиллах нөхцөл, сургалтын орчинг сайжруулах хүрээнд дүүргийн төсвийн 48,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 72 дугаар сургуулийн урлаг заалны засварын ажлыг хийж гүйцэтгэсэн ба 280,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5, 17, 37, 39, 49, 57, 61 дүгээр сургуулиудын технологийн кабинетийг “Юнимат” брэндийн тоног төхөөрөмжөөр хангасан. Боловсролын байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх, сургуулийн өмнөх боловсролын багш нарын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, харилцан туршлага судлуулах зорилгоор “Түншлэл” зорилтот | 70 |

| | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|
| | | | | | <p>төслийг хэрэгжүүлсэн. Бага ангийн багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх хүрээнд “Залуу багш-Манлайлал” ур чадварын тэмцээнийг амжилттай зохион байгуулж төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 15 сургуулийн шилдэг залуу багш нар “Эссэ бичлэг”, “Эх унших”, Хамтын бүтээл”, “Самбарын менежмент”, “Урлагийн авьяас” зэрэг 5 төрлөөр өрсөлдсөн нь улс, нийслэлийн хэмжээнд анхдагч ажил болсон. Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт үеийн илрүүлэлт, оролцоо” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан, цэцэрлэгийн эмч, бүлгийн багш, эрүүл мэндийн Нийгмийн ажилтнууд нийт 60 гаруй хүн хамруулж сертификат олголоо. Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Хайлааст ОНХХ-тэй хамтран цэцэрлэгийн багш, эцэг эхчүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Хамтдаа хөгжье-2” сэдэвт тоглоомын төслийг амжилттай хэрэгжүүлж нийслэлийн хэмжээнд тайлан үзэсгэлэн гарган олон нийтийн хүртээл болголоо. Боловсролын салбартаа хийж хэрэгжүүлсэн ажлаа танилцуулах “Хамтын хүч-Амжилтын үндэс” үзүүлэх ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгууллаа. “Гүүд нэйборс” ОУБ-тай хамтран сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж буй туслах багш нарыг чадавхжуулах сургалтыг нийт 30 цэцэрлэгийн 57 туслах багш хамруулан зохион байгуулсан. Бага ангийн боловсролын шинэчлэлийн хүрээнд бага ангийн багш нарт “STEM” боловсролын сургалтыг БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, МУБИС-тай хамтран 2017.06.05-2017.06.08-ны хооронд зохион байгуулж 110 багш хамрагдсан. Бага ангийн багш нарын өгүүлбэртэй бодлого бодох арга</p> | |
|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | | | |
|----|-------|------|---|-----------------------------------|------|--|---|----|
| | | | | | | зүйг дээшлүүлэх зорилгоор “Олонлог Төв” сургууль, 5 дугаар сургуультай хамтран 200 бодлого бодох уралдааныг 2 үе шаттайгаар зохион байгуулсан ба бага ангийн 60 гаруй багшид “Өгүүлбэртэй бодлого бодох арга зүй” сургалтыг зохион байгуулсан. | | |
| 17 | | | 4. Албан бус насан туршийн боловсрол төвийн үйл ажиллагааг дэмжин ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | 2016-2017 оны хичээлийн жилд бага, дунд ангид 52 хүүхэд, суурь боловсролд 60 хүүхэд, бүрэн дунд боловсролд 72 хүүхдийг хамруулан сургасан бөгөөд суурь боловсролыг 28 сурагч, бүрэн дунд боловсролыг 39 сурагч дүүргэн гэрчилгээ, үнэмлэхээ гардан авсан. Багш нар дүйцсэн хөтөлбөрийн дагуу сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулахаас гадна сурагчдын өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж нийгмийн оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Хүмүүнлэг ирээдүй”, “Мазаалай”, “Ирээдүй” хөгжлийн клубуудыг тус тус ажиллуулж байна. Амьдрах ухааны боловсрол олгох сургалтын хүрээнд “Өөртөө итгэх итгэл”, “Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх нь”, “Стресс түүнээс гарах арга замууд”, “Үе тэнгийнхний дарамт шахалт”, “Цахим орчинд зөв боловсон харилцааг бий болгоё” зэрэг сэдвүүдийн хүрээнд нийт 620 иргэн, Гутлын мэргэжлийн сургалтыг 3 удаа явуулсан ба хороодын 16 иргэн, Сувдан урлал, шүрэн урлалын чиглэлээр тус бүр 5 удаа насанд хүрэгчдэд сургалт явуулж өөрсдийн хэрэгцээт бүтээлийг урлуулах үйл ажиллагаанд нийт 25 иргэнийг тус тус хамруулсан байна. Мөн 12-р хорооны ажлын алба болон ахмадын хороотой хамтран “Монгол бичгийн соёл” арга хэмжээг зохион байгуулж хорооны 20 гаруй иргэдийг хамруулсан байна. Дүүргийн хэмжээнд сургууль завсардалтын судалгааг шинэчлэн гаргаж байна. | 70 |
| 18 | 1.2.3 | Орон | 1. Дүүргийн | Үйл | 100% | - | Дүүргийн соёлын төвийн үйл ажиллагааг | 90 |

| | | | | | | |
|--|---|---|--------------------------------------|--|---|--|
| | <p>нутгийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан дүүргийн нутаг дэвсгэрт Соёлын ордон байгуулж, соёлын төвийн үйл ажиллагааг дэмжинэ.</p> | <p>Соёлын төвийн үйл ажиллагааг дэмжин, материаллаг баазыг нэмэгдүүлнэ.</p> | <p>ажиллагааны хэрэгжилт, хувиар</p> | | <p>дэмжин материаллаг баазыг нэмэгдүүлэх хүрээнд дүүргийн төсвийн 50,0 сая төгрөгөөр автомашин, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн. Хүүхэд залуусын авьяас билгийг нээн хөгжүүлэх, иргэдэд соёл урлагаар үйлчлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон, үр ашигтайгаар өнгөрүүлэх зорилгоор дуу хөгжим, морин хуур болон бүжгийн дугуйланг хичээллүүлж давхардсан тоогоор нийт 113 хүүхэд суралцаж байна. "Дөрвөн цаг" хамтлагийн уран бүтээлчид болон соёлын төвийн уран бүтээлчид Сар шинийн баярыг тохиолдуулан 3, 8, 9, 10, 11, 16, 18, 19-р хороодын ахмадуудад хүндэтгэл үзүүлж урлагийн тоглолт үзүүлсэн. "Даншиг наадам-Хүрээ цам 2017" шашин, соёлын арга хэмжээнд Төв цэнгэлдэх хүрээлэнгийн урд хаалган дээр нийслэлийн 9 дүүргийн ардын авьяастнуудын "Монголын гайхамшигт урлаг" тоглолтыг Нийслэлийн Соёл урлагийн газраас хоёр өдрийн турш зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Чингэлтэй дүүргийн Соёлын төвийн дэргэдэх ахмадын "Дөрвөн цаг" хамтлагийн уран бүтээлчид ардын урлагийн нэг цагийн тоглолтыг хоёр өдрийн турш тоглож сонирхуулсан юм. Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Төгөлдөр урлаг ТББ-тай хамтран зохион байгуулсан Олон улсын ахмад ардын авьяастнуудын "Эгшиглэнт аялгуу" ардын урлагийн наадам Нийслэлийн Улаанбаатар чуулгын концертын танхимд болсон. Тус наадамд Монгол, Өвөр Монголын 10 гаруй хамтлагийн 300 гаруй уран бүтээлчид ур чадвар, авьяас билгээрээ өрсөлдсөн бөгөөд дүүргийн Соёлын төвийн дэргэдэх "Дөрвөн цаг" хамтлагийн уран бүтээлчид гоцлол хөгжим, хамтлаг хөгжим, гоцлол дуу, гоцлол бүжиг,</p> | |
|--|---|---|--------------------------------------|--|---|--|

| | | | | | | | |
|----|--|---|-----------------------------------|------|--------------------|---|----|
| | | | | | | хоршил бүжиг, хамтлаг бүжиг, язгуур урлаг гэсэн төрлүүдэд оролцож 10 алт 2 хүрэл медаль хүртэж, нийлбэр дүнгээр “Шилдгийн шилдэг” хамтлагаар шалгарлаа. | |
| 19 | | 2.Үндэсний соёл урлагийг нийтэд сурталчлан таниулах, соёлын салбарын үр өгөөжийг нэмэгдүүлэн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | Дүүргийн төсөв 7.0 | Хүүхэд багачуудыг бага наснаас нь эхлэн үндэсний өв соёл, уламжлалт зан заншлаасаа суралцах, өв соёлоороо бахархах үзэл төлөвшүүлэх зорилго бүхий “Би монгол хүүхэд” ёс заншлын наадмыг дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд зохион байгуулж төрийн өмчийн сургуулиудын 13 багийн 130 сурагч, 40 гаруй багш, 200 гаруй эцэг эхчүүд оролцлоо. Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг хүүхэд багачуудад таниулах, сурталчлах, тэдний дунд уран уншлагын урлагийг хөгжүүлэх зорилготой жил бүр зохион байгуулагддаг “Уран жиргээ” наадмыг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, бага насны ангилалд-1, сургуулийн дунд насны ангилалд-4, сургуулийн ахлах насны ангилалд-3 нийт 8 сурагч шалгарч Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаанд оролцлоо. Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Дэлхийн Зөн олон улсын байгууллага хамтран “Бидний бахархал” хүүхдийн ардын урлагийн наадмыг 11 дэх жилдээ зохион байгуулсан. Дүүргийн 25 жилийн ой, Эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд зохион байгуулсан “Бид сайн сайханд дагуулна” иргэдийн баярт дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбатын урилгаар Оросын холбооны улсын Улаан-үд хотын Советский дүүргийн төлөөлөгчид ирж оролцон монгол уламжлал, ёс заншилтай танилцсан. Оросын Холбооны Улсын Бүгд найрамдах Саха /Якутск/ Улсын Хангаласский дүүргийн даргын албан урилгаар Үндэсний уламжлалт нарны баяр болох “Ыһых” баярт албаны хүмүүс орлцож, морин хуурын аялгуугаар ая дууны мэнд дэвшүүлж, | 70 |

| | | | | | | | |
|----|--|---|------------------------------|-----|----------------------|---|----|
| | | | | | | үндэсний соёл уламжлалыг сурталчилан таниулсан. Нүүдэлчин ард түмний соёл, түүний дотор угсаатны дээл хувцас, эд хэрэглэл, соёлын биет болон биет бус өвийг гадаад, дотоодод сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилготой “Дээлтэй Монгол 2017” наадам 11 дэх жилдээ зохион байгуулагдлаа. Тус наадамд дүүргийн 19 хороод, Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын ажилтан албан хаагчид, иргэдээс бүрдсэн 700 гаруй иргэн дүүргээ төлөөлөн оролцож “Шилдгийн шилдэг дүүрэг”-ээр шалгарлаа. | |
| 20 | 1.2.4 Иргэдийн хөгжлийг бүх талаар дэмжсэн "Хотын иргэн-хотын соёл" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ. | 1. "Хотын иргэн-хотын соёл" хөтөлбөрийг боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллана. | Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар | 30% | Дүүргийн төсөв 150.0 | Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хотын иргэн-хотын соёл" хөтөлбөрийг Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, дүүргийн 1-3 дугаар хорооны иргэдээр хэлэлцүүлж гарсан санал зөвлөмжийг хөтөлбөрт тусган дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 26 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлуулсан. Тайлант хугацаанд хөтөлбөрийн хүрээнд "Харилцааны соёлын дадал" сургалтыг дүүргийн Засаг даргын тамгын газрын 60 гаруй ажилтан, албан хаагч нарын дунд зохион байгуулж, гарын авлага тараасан. Мөн дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид, төрийн захиргааны албан хаагчид, иргэдийн дунд 7 удаагийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 11500 гаруй иргэнийг хамруулсан байна. Дүүрэг дэх соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагч нарын бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх зорилго бүхий "Соёлын биет бус өвийн бүртгэл мэдээллийн сан, тодорхойлолт" сэдэвт сургалтыг дүүргийн 19 хороодын нийгмийн ажилтнуудад зохион байгуулж Соёлын өвийн төвөөс бэлтгэсэн баримтат киног | 90 |

| | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|
| | | | | | <p>үзүүлж, Монгол Улс дахь соёлын биет бус өвийн урьдчилсан жагсаалт, ангиллын талаарх гарын авлагыг тараасан. Мөн Соёлын биет бус өв, өвлөн уламжлагч нарын судалгааг 3 үе шаттайгаар явуулахаар бэлдэж эхний 2 шатыг амжилттай хийж дуусган, соёлын биет бус өвийг өндөр төвшинд өвлөн эзэмшсэн 25, Өвлөн суралцагч 301, Ардын урлагийн мэргэжлийн уран бүтээлчид 57, нийт 384 өвлөн уламжлагч, ардын авьяастан уран бүтээлчдийн нэгдсэн судалгааг гаргасан.</p> <p>Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд дүүргийн зорилтот бүлгийн 6677 хүүхэд багачуудад дүүргийн Засаг даргын гарын бэлгийг батлагдсан хуваарийн дагуу хэлтсүүд хороодод зохион байгуулан гардуулсан ба Тусгаар тогтнолын талбайд дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын урлагийн тоглолт, Соёлын төвийн уран бүтээлчдийн тоглолт, “Улаан театр”-ын тоглолт, хөгжөөнт тоглоом зэрэг олон арга хэмжээг зохион байгууллаа.</p> <p>Бага, өсвөр насны хүүхдүүдийн хүмүүжил болон танин мэдэхүйг сайжруулах зорилгоор Үлгэрийн цаг арга хэмжээг 14 удаа, “Сайн жаал” сургалт зөвлөгөөг 6 удаа, шинжлэх ухаан танин мэдэхүйн кино цагийг 8 удаа, Би хэн бэ? уулзалт чөлөөт ярилцлагыг 4 удаа, “Би монгол хүн” уулзалт чөлөөт ярилцлагыг 3 удаа, “Зохиолч-Уншигчдын уулзалт”-ыг 6 удаа тус тус зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 2500 гаруй хүүхэд багачууд хамрагдсан байна. Үндэсний их баяр наадмын өдрүүдэд иргэдэд урлаг, соёлын үйлчилгээ үзүүлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Соёл Урлагийн их сургууль хамтран Хүй долоон худгийн Монгол наадам цогцолборт “Соёлын наадам-2017” фестивалийг зохион</p> | |
|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | | |
|----|--|--|-----------------------------------|------|---|---|----|
| | | | | | | байгуулж, Монголынхоо түүх, өв соёл, нүүдэлчин ахуйг харуулсан “Соёлын наадам-2017” фестиваль нь жуулчид, наадамчин олонд урлаг соёлын бие даасан үйлчилгээ үзүүлснээрээ онцлог боллоо. Монгол дахь дэлхийн яруу найргийн өдрүүдийн хүрээнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболдын ивээл дор зохион байгуулсан Олон улсын яруу найргийн наадмыг Явуухулангийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнд зохион байгууллаа. Тус наадмыг “Данзанравжаа”-гийн нэрэмжит болгосон ба дэлхийн 40 орчим орны 200 гаруй яруу найрагч, зохиолч, нийтлэлч, орчуулагч, урлаг соёлын зүтгэлтнүүд оролцлоо. | |
| 21 | 1.2.5 Залуучууд, есвэр үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн “Хөгжлийн төв” байгуулж, олон талт ажиллагаа явуулна. | 1. Залуучуудын хөгжлийн төв байгуулж, олон талт ажиллагаа явуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | Монгол Улсын Засгийн Газар, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүн амын сан, Швейцарийн Хөгжлийн Агентлаг, Люксембургийн Засгийн Газар, “Оюу толгой” ХХК-ийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучуудын хөгжил 2013-2017” төслийн хүрээнд дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэд “Залуучуудын хөгжлийн төв”-ийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлээ. Тус төв нь залуучуудад амьдрах ухааны сургалт явуулах танхим, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө, компьютерийн өрөө, номын сан, шатар даам тоглох танхим зэрэг залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хөгжих боломжтой байхаар тохижуулж, интернэт орчин, тоног төхөөрөмж, ном, гарын авлагаар иж бүрэн хангагдсан. Залуучуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжилд тэдний санал санаачлагыг тусгах, тулгамдаж буй асуудлыг гаргаж шийдвэрлэх арга замыг олох, залуучуудын клубыг шинэчлэн байгуулж, идэвхжүүлэх зорилготойгоор 18-35 насны 100 залуучуудын дунд “Залуучуудын оролцоо ба нөлөөлөл” зөвлөгөөнийг зохион | 90 |

| | | | | | | | |
|---------------------------------------|---|---|---|------|---|--|------------------|
| | | | | | | байгуулсан. "Аз жаргалтай гэр бүл" сарын аяны хороодын зорилтот залуу гэр бүлүүдийн дунд, гэр бүлд тулгамдаж байгаа асуудлын мөн чанар шалтгааныг тодорхойлон, асуудлаа шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох "Гэр бүлийн үнэ цэнэ" сургалтыг 15 гэр бүл буюу 38 залуучуудын дунд зохион байгууллаа. НҮБ-ын Хүн амын сан /UNFPA/, Жи Си Ай Прогресс /JCI progress/ салбар байгууллагаас зохион байгуулж буй "1000 идэвхтэй иргэн" залуучуудын хөгжлийн төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болсон ба эхний арга хэмжээ болох "Миний бизнесийн амжилт" сэдвээр сургалт зохион байгуулж 15, 16, 18 дугаар хорооны 48 идэвхтэй залуучууд хамрагдсан. | |
| 1.3 НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛАЛ | | | | | | | |
| 22 | 1.3.1 Ахмадын амралт, сувиллын үйл ажиллагааг дэмжин ажиллаж, төсөл хөтөлбөрийн хүрээнд "Ахмадын асаргаа сувилгаа"-ны төвийн барилгын ажлыг эхлүүлнэ. | 1. Ахмадын амралт сувилалын материаллаг баазыг бэхжүүлж, ахмадуудад үйлчлэх урлаг соёлын танхимтай болгоно. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | "Ногоон булан" ахмадын амралт сувиллын материаллаг баазыг бэхжүүлж, ахмадуудад үйлчлэх урлаг соёлын танхимтай болох ажлын хөрөнгө дүүргийн төсөвт суугдаагүй тул тус ажил хойшилсон. | Үнэлэх боломжгүй |
| 23 | 1.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд анхаарч, барилга | 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, гарц, шат, хаалга, бие засах газрын стандартыг мөрдүүлэн | Стандартын дагуу шинээр хийгдсэн зам, гарц хаалга, бие засах газрын тоогоор | 50% | - | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Японы ОУ-ын JICA байгууллагатай хамтран төрийн болон үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээ, явган хүний гарц, гэрлэн дохио, замын уулзваруудын хүртээмжид үнэлгээ хийх Ажлын хэсэг байгуулагдан дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр болон харьяа хэлтэс, өрхийн эрүүл мэндийн төв, худалдааны | 50 |

| | | | | | | | |
|----|---|--|-----------------------------------|------|--|---|----|
| | байгууламж, зам талбайн стандартыг хангуулна. | ажиллана. | | | | төвүүдэд зөвлөгөө, зөвлөмж өгч, зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайланг 11 сард авахаар ажиллаж байна. Дүүрэгт шинээр байгуулагдсан цэцэрлэгүүдийн орц гарц, ариун цэврийн өрөөг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулан тохижуулсан бөгөөд Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын 52,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 49 дүгээр сургуулийн ариун цэврийн өрөөнүүдийг засварлан тохижуулсан ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөөг тусгайлан тохижууллаа. | |
| 24 | | 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх санал санаачлагыг дэмжин олон талт үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | Дүүргийн төсөв, ОУБ, ТББ-ын дэмжлэг 50.0 | Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар комиссыг дүүргийн Засаг даргын 2017 оны А/198 дугаар захирамжаар шинэчлэн байгуулсан. Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт үеийн илрүүлэлт, оролцоо” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан, цэцэрлэгийн эмч, бүлгийн багш, эрүүл мэндийн Нийгмийн ажилтнууд нийт 60 гаруй албан хаагчийг хамруулж сертификат гардууллаа. Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын “Хайлааст” ОНХХ, ИРИМ судалгааны хүрээлэнтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд тэгш хамруулан сургах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийг 13-19 дүгээр хороодод хэрэгжүүлж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлэх үнэлгээний аргачлалын туршилтыг дүүргийн 17, 72, 37 дугаар Ерөнхий боловсролын сургуулиудын 5784 хүүхдэд амжилттай явуулсан. “Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг угтан Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн үндэсний төвөөс зохион байгуулсан “Хайраар дүүрэн гэр бүл” өдөрлөгт тус дүүргийн харьяалалтай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн | 70 |

| | | | | | | | |
|----|---|---|----------------------------------|------|----------------------|---|----|
| | | | | | | төлөөлөл 10 гэр бүлийг оролцуулж, чих хамар хоолой, шүдний үзлэг оношлогоонд хамруулж, үнэ төлбөргүй хууль эрх зүйн зөвлөгөөнд зуучилсан. Мөн дүүргийн харьяа хөгжлийн бэрхшээлтэй 20 хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд үнэгүй хамруулж, тэдний эцэг эхчүүдийг “хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдэвт сургалтанд хамруулан ажилласан. Евро Азийн нүүдэлчдийн сонсголын бэрхшээлтэй иргэдийн спортын анхдугаар наадамд дүүргээ төлөөлөн жудо бөх, чөлөөт бөх, сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис гэсэн спортын төрлүүдэд амжилттай оролцсон 22 тамирчинг дүүргийн 25 жилийн ойн медалиар шагнаж, Засаг даргын Тамгын газрын даргын А/191 тоот тушаалаар мөнгөн дэмжлэг олгосон. | |
| 25 | 1.3.3 Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, нийгмийн халамж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | 1. Нийгмийн халамжийн чиглэлээр төрөөс үзүүлж буй үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй, ил тод хүргэнэ. | Үйлчилгээ авсан иргэдийн тоогоор | 100% | Дүүргийн төсөв 400.0 | Нийгмийн халамжийн чиглэлээр төрөөс үзүүлж буй үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй, ил тод хүргэн ажиллаж, тайлант хугацаанд Нийгмийн халамжийн тэтгэвэрийг 2461 иргэнд 2.264.434.790 төгрөг, Нийгмийн халамжийн тэтгэмжийг 2817 иргэнд 1.159.726.150 төгрөг, Ахмад настны тусламж, хөнгөлөлтийг 4934 иргэнд 817.865.659 төгрөгний хөнгөлөлт, тэтгэмжид тус тус хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжийг 1281 иргэнд 228.161.170 төгрөг, Алдар цолтой ахмад настанд төрөөс олгож буй мөнгөн тусламжийг 329 иргэнд 214.300.200 төгрөг, Жирэмсэн нярай хөхүүл хүүхэдтэй олгох тэтгэмжийг 5947 эхэд 1.103.911.870 төгрөг, Алдарт эхийн одонгийн тэтгэмжийг 8435 эхэд 1.094.700.000 төгрөг, Насны хишгийг 6901 иргэнд 570.230.000 төгрөгийн үйлчилгээнд тус тус хамруулан ажиллалаа. | 70 |
| 26 | | 2. Эмзэг бүлгийн иргэд, өрх | Дэмжлэг туслалцаа | 100% | Дүүргийн төсөв 100.0 | Өрхийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан өрх толгойлсон /эцэг/ эх, хөгжлийн бэрхшээлтэй | 70 |

| | | | | | | | |
|----|---|--|---|---------------------|---------------------------------------|--|----|
| | | толгойлсон эх /эцэг/-чүүдэд шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | авсан иргэдийн тоогоор | | | иргэн, ахмад настан, зорилтот бүлгийн иргэдээс ирүүлсэн нийт 323 иргэний өргөдлийг хүлээн авч, “Нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу 233 иргэний өргөдөл хүсэлтийг шийдвэрлэж, тусламж дэмжлэгт хамруулсан. | |
| 27 | 1.3.4 Хүн амын хөгжлийг дэмжсэн гэр бүлд зөвлөн туслах, зорилтод бүлэг рүү чиглэсэн халамж үйлчилгээг дэмжсэн төслүүдийг хэрэгжүүлнэ. | 1. Хүн амын хөгжил, гэр бүлд зөвлөн туслах үйлчилгээний чиглэлээр төсөл хэрэгжүүлэх иргэн, төрийн бус байгууллагатай хамтран ажиллана. | Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоогоор | 2-3 ТББ-ыг дэмжинэ. | Улс, нийслэлийн төсөв, ОУБ-ын дэмжлэг | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн зөвлөх үйлчилгээ арга хэмжээний хүрээнд нийт 37 төслийг хүлээн авснаас 6 төсөл сонгон шалгаруултад тэнцсэн. Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд нийт 56 ахмад настан төсөл ирүүлнээс 22 төслийг сонгон шалгаруулж, 17,5 сая төгрөгийн дэмжлэг олгогдоод байна. Мөн Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын “Чингэлтэй” ОНХХ, “Хайлааст” ОНХХ-тэй хамтран “Өрхийн амжиргааг сайжруулах” хөтөлбөрийг 2020 оныг хүртэл хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хамтран ажиллах санал тусгасан. | 70 |
| 28 | | 2. Өрхийн хэрэгцээ, чадавхи, санаачлагыг дэмжин эмзэг бүлгийн өрхийн амьжиргааг дээшлүүлнэ. | Амьжиргаа нь дээшилсэн өрхийн тоогоор | 30% | Улс, нийслэлийн төсөв, ОУБ-ын дэмжлэг | “Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр ажлын байртай болох зорилготой иргэдэд зориулж жижиг зээлийн арга хэмжээний хүрээнд аж ахуй, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнд 10 сая хүртэл, аж ауйн нэгж, нөхөрлөл хоршоонд 20 сая хүртэлх төгрөгийн жижиг зээл олгох ажлыг Голомт банктэй хамтран хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 97 төсөлд 133,5 сая төгрөг, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн 54 төсөлд 89,0 сая төгрөг, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн 5 төсөлд 33,0 сая төгрөг, “Ахмад мэргэжилтний | 90 |

| | | | | | | | |
|----|---|--|--|------|---------------------|--|----|
| | | | | | | зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдах арга хэмжээний 22 төсөлд 17,5 сая төгрөгийг тус тус олгосон бол дүүргийн төсвийн 283,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 30 цэгт ажлын байр бий болгон ажиллаж байна. | |
| 29 | 1.3.5 Хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, оюун ухаан, авъяас билэг, бие бялдар, ур чадварыг нь хөгжүүлэхэд чиглэсэн "Жаргалтай гэр бүл" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ. | 1. "Жаргалтай гэр бүл" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 30% | Дүүргийн төсөв 50.0 | Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Жаргалтай гэр бүл" хөтөлбөрийг Монгол улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 25 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 3 бүлэг 21 хэрэгжүүлэх үйл ажиллагаа бүхий ажлын төлөвлөгөөнөөс 15 үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллалаа. | 70 |
| 30 | Хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, оюун ухаан, авъяас билэг, бие бялдар, ур чадварыг нь хөгжүүлэхэд чиглэсэн "Жаргалтай гэр бүл" хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ. | 2. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллээс татгалзах хандлагыг олон нийтэд төлөвшүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулна. | Сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоогоор | 100% | - | "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль"-ийг иргэдэд сурталчлан таниулах ажлын хэсэг дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн даргын А/06 тоот тушаалаар байгуулагдан дүүргийн ерөнхий боловсролын 12 сургуулийн 9-11 дүгээр ангийн ахлах ангийн 1236 сурагч, 110 багш, дүүргийн 19-н хорооны 1600 иргэн, 200 ажилтан албан хаагчдад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа. Дүүргийн хэмжээнд хамгаалал шаардлагатай хүүхдийн эрсдлийн түвшин тогтоох програмд нийт 766 хүүхэд бүртгэлтэй байгаагаас хөдөлмөр эрхэлдэг хүүхэд 21, хүчирхийлэлд өртсөн хүүхэд 63, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 571, хараа хяналтгүй хүүхэд 67, гэмт хэрэгт холбогдсон хүүхэд 7, гамшиг осолд өртсөн хүүхэд 3, асрамж халамжийн төвд 13 хүүхэд, сургууль завсардсан 21 хүүхэд тус тус бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд хороо тус | 90 |

| | | | | | | | |
|----|---------------------------------|---------------------------|------|---|--|--|--|
| | | | | | | <p>бүрээс хүүхдийн эрсдэлийн түвшин тогтоох програмд бүртгэлтэй хүүхдүүдэд Хамтарсан багийн зүгээс үйлчилгээ үзүүлж хамтарч ажилласан. Тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд гарч байгаа гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн талаар хүүхдийн 108 утсанд 145 дуудлага, бусад эх сурвалжаас 29 дуудлага хүлээн авч холбогдох хуулийн хүрээнд мэргэжлийн байгууллагууд, хороодын хамтарсан багтай хамтран дараах байдлаар хариу үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. Үүнд: Бие махбодийн хүчирхийлэл 21, сэтгэл санааны хүчирхийлэл 14, үл хайхрах хүчирхийлэл 39, бэлгийн хүчирхийлэл 6, эдийн засгийн хүчирхийлэл 1, хараа хяналтгүй хүүхэд 9, хөдөлмөр эрхэлдэг 3, гэмт хэрэгт холбогдсон 1 хүүхэд илэрч нийт 94 кейс мэдээллийн дагуу хүүхэд, эцэг эхэд эрсдэлийн түвшинг тогтоон, нийгэм сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ /холбон зуучлах/, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулах, хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалтанд хамруулах болон дүүргийн Засаг даргын захирамжаар 28 хүүхдэд асран хамгаалагч харгалзан дэмжигч тогтоолгож, 41 хүүхдийн үрчлэлийн асуудлыг шийдвэрлэсэн. “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооцгооё” аяны хүрээнд дүүргийн ГХУСАЗСЗ, Дэлхийн Зөн ОУБ-тай хамтран Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 1236 сурагчид “Цахим гадуурхал”, “Үе тэнгийн дарамт хүчирхийлэл”, “Хүүхдийн хөгжил, оролцоо”, “Хууль эрх зүй” /Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгаалалын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын талаар мэдээлэл өглөө.</p> | |
| 31 | 3. Хүүхдийн нийгмийн хамгааллыг | Үйл ажиллагааны хэрэгжилт | 100% | - | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, JICA ОУБ, Японы хүүхдийг ивээх сангийн дэмжлэгээр хэрэгжих “Монгол улс дахь | 70 | |

| | | | | | | | |
|--|--|--|---------------|--|--|--|--|
| | | <p>сайжруулж, хүүхэд, гэр бүлийг хүчирхийллээс хамгаалах “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.</p> | <p>хувиар</p> | | | <p>хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд дүүргийн 9, 10 дугаар хорооны хамтарсан багийн гишүүд, хэсгийн ахлагч нарын бүрэлдэхүүнтэй 50 хүнд чадавхжуулах сургалт зохион байгуулж, Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиуд шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан түүнийг хэрэгжүүлэхэд дагалдан гарсан журмуудыг танилцуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, туршлага хуваалцах, кейс менежмент хийх, стресс бухимдлаа даван туулах аргачлал, арга зүйг олголоо. Мөн тус төслийн хүрээнд Баянзүрх дүүргийн 23, 27 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 2, 10 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 9, 10 дугаар хороодын хамтарсан багийн гишүүдийн дунд туршлага солилцох уулзалт хэлэлцүүлгийг 9 дүгээр хорооноос эхлүүлэн сайн туршлагаа түгээн дэлгэрүүллээ. Хүүхэд хамгааллын үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийлэлд хамтарсан багаар хариу үйлчилгээ үзүүлэх чанар хүртээмжийг сайжруулах, зорилгоор “Хүчирхийллийг таслан зогсооё” кейс хэлэлцүүлгийг зохион байгуулж, 1-19 дүгээр хорооны Хамтарсан багийн ахлагч буюу хорооны Засаг дарга, нийгмийн ажилтанууд, хэсгийн байцаагч нар, ГБХЗХХ-ын хамгааллын ажилтанууд нийт 60 хүн хамрагдсан. ДЗМОУБ-ын “Хайлааст ОНХХөтөлбөр”, Монгол өрх ТББ-тай хамтран 3 удаагийн сургалтанд давхардсан тоогоор хамтарсан багийн 150 гаруй гишүүдийг хамруулан зохион байгуулж хүүхэд хамгааллын үйлчилгээ, гэр бүлийн хүчирхийлэлд хариу үйлчилгээ үзүүлэх чанар хүртээмжийг сайжруулах, хүндэрсэн кейсийн гарц шийдлийг хэлэлцэн санал бодлоо солилцлоо. ДЗОУБ-тай хамтран Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан</p> | |
|--|--|--|---------------|--|--|--|--|

| | | | | | | | |
|--|--|---|----------------------------------|------|----------------------|---|----|
| | | | | | | сэргийлэх хороодын хамтарсан багийг идэвхжүүлэх, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх, ажил, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, үр дүнг үнэлж, дүгнэх зорилготой “Хамтарсан багийн хамтын ажиллагаа” 3 сарын уралдаант аяныг зарлан хэрэгжүүлж, аяны нэгдсэн дүнг гаргахаар ажиллаж байна. | |
| 2. ЖАРГАЛТАЙ ИРЭЭДҮЙ-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ | | | | | | | |
| 2.1 ЭДИЙН ЗАСАГ | | | | | | | |
| 32 | 2.1.1 Монгол Улсын төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн тэнцвэрт байдал, эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэн, нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэн ажиллана. | 1. Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулж, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон талт ажлыг зохион байгуулж, төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд тавих хяналтад төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн ил, тод нээлттэй байдлыг ханган, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 100.0 | Тайлант хугацаанд буюу 2017 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн байдлаар улсын төсөвт 34.078,5 сая төгрөг төвлөрүүлэхээс 43.194,4 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 126.7 хувийн, нийслэлийн төсөвт 44.791,5 сая төгрөг төвлөрүүлэхээс 38.682,7 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 86.4 хувийн, дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, орон нутгийн төсөвт 34.670,5 сая төгрөг төвлөрүүлэхээс 41.860,8 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 120.7 хувийн тус тус биелэлттэй ажилласан. Дүүргийн Засаг даргын 2017 оны А/15 дугаар захирамж авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдол, авто зам ашигласны төлбөр хураах, техник хяналтын үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах төв ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгуулагдан дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бүртгэлтэй бүх төрлийн тээврийн хэрэгсэл эзэмшигчдээс авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах ажлыг 1 дүгээр сарын 18-наас 5 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл зохион байгуулан ажилласан. Дүүргийн Замын цагдаагийн хэлтсээс нийт 1802 ширхэг тээврийн хэрэгслийн гэрчилгээ хураагдаж ирснээс 1656 тээврийн хэрэгслийн гэрчилгээг буцаан олгож, АТБӨЯХАТатвар 2.111.5 сая | 70 |

| | | | | | | |
|----|---|----------------------------------|------|--------------------|--|----|
| | | | | | <p>төгрөг, Автозам ашигласны төлбөр 966.4 сая төгрөг, Агаарын бохирдлын төлбөр 88.9 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн. Мөн хөдөлгөөнд оролцдоггүй, татвараа хугацаанд нь төлөөгүй тээврийн хэрэгслийн судалгааг гарган Татварын хэлтсийн ХХОАТ-ын тасаг болон хороодтой хамтран холбогдох байгууллагаас 750 тээврийн хэрэгслийг авто тээврийн үндэсний төвөөс хасуулахаар татварыг төлүүлэн ажилласан. Төсвийн орлогын тогтвортой орчинг бүрдүүлж, татварын бааз суурийг өргөжүүлэх, орлогын төлөвлөгөөг татварын нэр төрлөөр нь ханган биелүүлэх, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн урамшууллын нэгдсэн системд холбогдсон байдал, цахим төлбөрийн баримт хэвлэж өгөхгүй явдлыг богино хугацаанд арилгах чиглэлээр ажлын хэсэг байгуулагдан үл хөдлөх эд хөрөнгө эзэмшигч хувь хүн хуулийн этгээдийн тооллого бүртгэлийг нутаг дэвсгэрийн зарчмаар явуулж, татварт бүрэн хамруулах, хувь хүн, хуулийн этгээдийн түрээсийн гэрээ хэлэлцээр, аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хянан шалгах хууль хэрэгжүүлэх шат дараалсан арга хэмжээ авч, гарсан үр дүнг тайлагнан ажилласан.</p> | |
| 33 | 2. Төсвийн урсгал зардалд дүн шинжилгээ хийн, зардал бууруулах, төсвийн сахилга | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 2.0 | <p>Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Төсвийн зарлагын хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай” 147 дугаар тогтоол, 2015 оны “Төсвийн зардлыг бууруулах тухай” 230 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсөвт байгууллагын санхүүжилтын эрх болон</p> | 70 |

хариуцлага,
дүүргийн төсвийн
байгууллагуудын
орлого, зарлага
хөрөнгө
оруулалтын ажил
болон хууль
тогтоомж,
бодлогын баримт
бичгийн
хэрэгжилтэд
тавих хяналтыг
сайжруулна.

холбогдох зардлуудыг өдөр тутам үндсэн баримтаар хянан, гүйцэтгэлээр нь олгох ажлыг хийж гүйцэтгэсэн. Дүүргийн 2017 оны батлагдсан төсөвт тусгагдсан гэрэл цахилгаан, халаалт дулаан, цэвэр бохир усны үнэ, тариф тооцооллын үндэслэлийг үндсэн нэгжид удирдамж өгч, шалган зааварчлах зохион байгуулалтын ажлууд хийгдсэн. Түлш, нүүрсээр халдаг хороодын цогцолбор байруудад шаталтын хувь өндөртэй нано болон бусад технологийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх зорилго тавин судалгааны материалыг нэгтгэж, хороодын удирдлагуудад өөрийн хорооны бичиг хэрэг, хангамжийн материалын зардлыг зарцуулах саналын эрхийг өгөх замаар тус зардлуудын хязгаарыг тогтоож үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах арга замыг нээлттэй болгож өгсөн. Дүүргийн төсөвтэй харилцагч 66 төсөвт байгууллагуудаас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээг хянан хүлээн авч нэгтгэснээр төсвийн зардлыг бууруулах оновчтой аргыг олоход шаардлагатай судалгааны суурь баазыг нэмэгдүүлэх, зардал тус бүрээр нарийвчлах, оновчтой дүн шинжилгээ хийх нөхцлийг бүрдүүлсэн. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд дүүргийн хэмжээнд төсвөөс гаргаж байсан гар утасны зардлын санхүүжилтийг зогсоож, 1 өдөр явах авто машины шатахууны зардлыг 40 км-ээс хэтрүүлэхгүй байхаар тооцсон. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд төрийн албанаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн албан хаагчийн орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байж, ажил үүргийн хуваарийг өөрчлөх замаар зохицуулалт хийн ажилласан. Мөн дээрх тогтоолын хэрэгжилтийн хүрээнд төрийн албан

| | | | | | | | |
|----|--|--|--|-----|---------------------|---|----|
| | | | | | | хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах буюу царцаах, цалин хөлсийг цаашид нэмэгдүүлэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан ажиллаж байна. Төрийн албан хаагчдын албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлал ахиулахыг түр зогсоож, энэ талын шийдвэр гаргахгүйгээр ажилласан. | |
| 34 | | 3. Төсөв, санхүүгийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төсвийн захирагч, санхүү, бүртгэлийн ажилтнуудыг чадваржуулах чиглэлээр сургалт семинар зохион байгуулж, мэдээллээр хангана. | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо | 95% | Дүүргийн төсөв 18.4 | Монгол Улсын Сангийн яамтай хамтран Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцооны шинэчлэлийн ажлын хүрээнд “Засгийн газрын санхүүгийн тайлан”-г хүлээн авах, онлайнаар илгээх, тушаах, нэгтгэх, баталгаажуулах, төсөвт байгууллагын санхүүгийн “Э-ТАЙЛАН”-гийн шинэ програмаар 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргах програмын дэлгэрэнгүй сургалтыг зохион байгуулж, орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлэгийн 67 төсөвт байгууллагуудын 50 нягтлан бодогч хамрагдсан. Дүүргийн төсөвтэй харилцагч орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын 2017 оны нэгдсэн зөвлөгөөнийг төсөвт байгууллагуудын 67 нягтлан бодогчийг хамруулан зохион байгууллаа. Нэгдсэн зөвлөгөөнөөр “Дүүргийн 2016 оны Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийж, аудитаас гарсан дүгнэлт, зөвлөмж, тайланд дурдагдсан зөрчил, дутагдлыг арилгах арга зам, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд зохион байгуулах ажлын чиглэл, түүний үр дүн”-гийн талаар, “Дотоод аудитын албанаас төсвийн байгууллагад 2016 онд хийсэн шалгалтын ажлын үр дүн, цаашдын чиг хандлага”-ын талаар, “2016 онд зохион байгуулсан сургалт, зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангах, шалган зааварчлах ажил, | 70 |

| | | | | | | | |
|----|---|---|----------------------------------|------|---------------------|--|----|
| | | | | | | мэдээ судалгаа авалтын ажлын үр дүн, цаашид анхаарах асуудал"-ын талаар тус тус хэлэлцлээ. Мэргэжлийн Нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуу Тангараг өргөх ёслолын үйл ажиллагаанд дүүргийн Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагуудын 19 нягтлан бодогч, аж ахуйн нэгж байгууллагуудын 31 нягтлан бодогч оролцлоо. Дүүргийн "Шилэн дансны мэдээлэл" самбарын доторх тоон болон график, диаграммын хүснэгтэн мэдээллийг сар бүр сольж иргэд, олон нийтэд мэдээллийн ил тод, нээлттэй, ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэж ажилласан. | |
| 35 | | 4. Улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл арга хэмжээний уялдааг ханган, санхүүжилтийг олгож, гүйцэтгэлд хяналт, шалгалт хийж, олон нийтийг мэдээллээр хангана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 30.0 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд хэрэгжүүлэх 28 төсөл арга хэмжээнээс 23 ажил 100 хувь хийгдэж дууссан. Гэрээ байгуулагдан хэрэгжиж буй 5 төсөл арга хэмжээ байна. Үүнээс ажлын гүйцэтгэлээр нийт 1 тэрбум 573 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 25 төсөл арга хэмжээнээс 18 ажил 100 хувь хийгдэж дууссан. Гэрээ байгуулагдан хийгдэж буй 6 ажлын явц 90 хувьтай байна. Олон нийтийн оролцоотой хийгдэх ажлын хүрээнд 1 иргэдийн бүлэгтэй гэрээ байгуулах шатандаа байна. Нийт ажлын гүйцэтгэлээр 160 сая 323 мянган төгрөгийн санхүүжилтийг олголоо. Төсвийн тодотголоор 42 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 5 ажил 100 хийгдэж дууссан. Гэрээ байгуулагдан хэрэгжиж буй 16 ажлын явц 50 хувьтай, бэлтгэл ажлын хүрээнд болон гэрээ байгуулах шатандаа 21 ажил байна. Нийт ажлын гүйцэтгэлээр 113 сая 788 мянган төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласан. | 70 |
| 36 | 2.1.2 Дүүргийн өмч хөрөнгийн ашиглалтын | 1. Орон нутгийн өмчийн эзэмшилт, | Үйл ажиллагааны хэрэгжилт | 100% | Дүүргийн төсөв 1.0 | Тайлант хугацаанд нийт 1.699,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн 31 ажлыг дүүргийн байнгын ажлын хэсгийн комисс | 70 |

| | | | | | | | |
|--|--|---|---------------|--|--|---|--|
| | <p>менэжментийг сайжруулан, үр ашгийг нэмэгдүүлнэ.</p> | <p>ашиглалтыг сайжруулж, эд хөрөнгийн үзлэг тооллогыг хагас, бүтэн жилээр явуулж, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр дүүргийн хэмжээнд хийгдэж байгаа өмч хөрөнгийг эзэнжүүлж, бүртгэлд бүрэн хамруулна.</p> | <p>хувиар</p> | | | <p>хүлээн авч ажилласан. Дүүргийн 17 дугаар хорооны Ахуйн үйлчилгээний төвийн байрны ашиглалтыг хариуцуулах гэрээг дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй, 14 дүгээр хорооны Халуун ус ахуйн үйлчилгээний төвийн ашиглалтыг хариуцуулах гэрээг “Эхлэл” иргэдийн бүлэгтэй, 17 дугаар хорооны Олон нийтийн заалны ашиглалтыг хариуцуулах гэрээг иргэн Д.Отгонбаяртай, дүүргийн өмчийн арчлалт, хамгаалалтыг хариуцуулах гэрээг дүүргийн Тохижилт үйлчилгээний компанитай тус тус байгуулан ажилласан. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор шилжиж ирсэн “Амар тайван Чингэлтэй хөтөлбөр”-ийн хүрээнд суурилуулсан 284,9 сая төгрөгийн үнэ бүхий хяналтын камеруудыг Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/81 дугаар тушаалаар, “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-аас балансаас балансад шилжин ирсэн 506,8 сая төгрөгийн тээврийн хэрэгслүүдийг Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/65 дугаар тушаалаар, Нийслэлийн төсвийн 172,6 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдсэн хогийн сав хог ачих төхөөрөмжүүдийг Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны А/72 дугаар тушаалаар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Нийслэл, дүүргийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээний тухай” 04 дүгээр тогтоолоор 4,7 тэрбум төгрөгийн хөрөнгийг тус тус дүүргийн өмчид бүртгэн авч ажилласан. Нийслэлийн Өмчийн Харилцааны газрын даргын А/406 дугаар тушаал, Эргэлтийн бус хөдөлгөөн хариуцсан комиссын 2017 оны 07 дугаар сарын 27-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу 29,520,000 төгрөгийн зөөврийн ажлын байрыг дүүргийн Жижиг дунд</p> | |
|--|--|---|---------------|--|--|---|--|

| | | | | | | | |
|----|--|--|----------------------------------|------|---------------------|--|----|
| | | | | | | үйлдвэрлэлийг дэмжих Бизнес Инкубатор төвийн балансад шилжүүлэн ажилласан | |
| 37 | 2.1.3 Дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн гадаад орнуудын сайн туршлагыг нэвтрүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. | 1. Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлэн шинээр хамтын ажиллагаа тогтоох, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд улс орнуудын сайн туршлагаас нэвтрүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 85.0 | Япон Улсын Шизуока мужийн Засаг дарга Кавакцу Хэйтагийн урилгаар дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат тэргүүтэй албаны хүмүүс 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын 24-ний өдрүүдэд ажлын айлчлал хийсэн. Уг айлчлалаар тус мужийн хоттой шинээр хамтын ажиллагаагаа эхлүүлэн, цаашид боловсролын чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Манжуур хотын Ардын Их Хурлын дарга Го Цзин Мины урилгаар дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч Л.Баярсайхан тэргүүтэй Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын хамтарсан ажлын хэсэг 2017 оны 04 дүгээр сарын 10-14-ны өдрүүдэд Манжуур хотод ажлын айлчлал хийсэн. Тус айлчлалын хүрээнд 7 дугаар сард болох БНХАУ-ын Хойд бүсийн олон улсын шинжлэх ухаан, технологийн 14 дэх удаагийн үзэсгэлэнд дүүргийн жижиг дунд бизнес эрхлэгчдийг оролцуулах, Манжуур хотод “Чингэлтэйд үйлдвэрлэв төв”-ийг нээх талаар холбогдох албаны хүмүүстэй уулзалт яриа хэлэлцээрийг хийлээ. Дүүргийн жижиг дунд бизнес эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг Манжуур хотод борлуулах төвийг нээснээр иргэдийн амжиргааг дээшлүүлж, улмаар Монгол Улсыг зүүн хойд Азид сурталчлах чухал ач холбогдолтой юм. Айлчлалын хүрээнд Манжуур хотын их сургуулийн Оюутны парк хүлэмжийн ногоон байгууламж, төлөвлөлт, тохижилт, гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийн технологи, стандарт, түүний арчлалт, хамгаалалт, Спортын цэцэрлэгт хүрээлэн, Манжуур хотын технологи дамжуулах олон | 70 |

| | | | | | | | |
|----|--|--|-----------------------------------|------|---|---|----|
| | | | | | | улсын төв, жишиг хорооллын тохижилт зэрэгтэй танилцаж туршлага судалсан. Дүүргийн Засаг дарга Ж.Эрдэнэбат Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчон хотын Сонам дүүргийн Мёнжи Олон улсын эрүүл мэндийн төвийн менежер Жей Шим нар Чингэлтэй дүүрэг, Мёнжи эмнэлэг хооронд хамтын ажиллагааны тогтолцоог байгуулж, харилцан дэмжлэг тусалцаа үзүүлэх, эмнэлгийн чанартай үйлчилгээг үзүүлэх зэргээр эмнэлгийн үйл ажиллагааны хөгжлийг эрэлхийлэх зорилготой санамж бичгийг үзэглэсэн. Тус хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд дүүргийн Хүүхдийн амбулаторид Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Мёнжи эмнэлгээс нарийн мэргэжлийн эмч нарыг урьж авчран урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан. БНСУ-ын Ёнсу дүүрэгтэй сурагч солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж, Ёнсу дүүргийн боловсролын газрын 2 мэргэжилтэн, 12 сурагч, нийт 14 хүний бүрэлдэхүүнтэй баг хүрэлцэн ирж Монгол ахуй, соёл, ёс заншилтай танилцсан. | |
| 38 | 2.1.4 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг олон нийтэд ил тод болгож, “Шилэн тендер шалгаруулалт” бодлого хэрэгжүүлэн, сонгон | 1. Төлөвлөгдсөн худалдан авах ажиллагааны 60-аас доошгүй хувийг цахим тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, үр дүнг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод нээлттэй мэдээллэнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | Цахим тендер шалгаруулалтын ажлын хүрээнд дүүргийн 16 дугаар хорооны Болзох цэгийн тохижилт, 17 дугаар хорооны Сурагчийн 84-р гудамжны Ахмадын талбайн тохижилт, 4 дүгээр хорооны 30А байрны дунд талбайн тохижилтын ажлуудыг Төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн цахим систем www.tender.gov.mn цахим хуудсаар зарлах бэлтгэл ажлыг ханган ажиллалаа. Мөн тус цахим хуудсанд нийтлэгдсэн нийт 7 төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үр дүнгийн мэдээллийг оруулсан болно. Тендерийн үнэлгээ хийх бүрт үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилтэй эсэх талаарх мэдүүлгийг аван, давхардсан тоогоор | 70 |

| | | | | | | | |
|----|---|-----------------------------------|------|---|--|---|--|
| | шалгаруулалтын ил тод байдал, иргэд олон нийтийн оролцоог хангана. | | | | | Үнэлгээний хорооны 282 гишүүнээс авсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын www.iaac.mn цахим хуудсанд байршууллаа. Хөрөнгө оруулалтын ажлын нээлт, явц болон үр дүнгийн мэдээг тухай бүр дүүргийн www.chingeltei.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Тус цахим хуудсанд 2017 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 63 хөрөнгө оруулалтын ажлын худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын нээлтийн мэдээ, 48 үр дүнгийн мэдээг байршуулсан байна. | |
| 39 | 2. Тендерт оролцогчдын мэдээллийн санг бий болгож, тендертэй холбоотой мэдээллийг ил тодоор мэдээллэн худалдан авах ажиллагааны зарчмыг баримтлан тендер шалгаруулалтыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | Тендерт оролцох хүсэлтэй аж ахуй нэгжүүдийн хамтран ажиллах хүсэлтийг хүлээн авч нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлсэн ба мэдээллийн санд 167 аж ахуй нэгжийн ерөнхий болон чадварын мэдээлэл бүртгэгдсэн. Тендерт оролцогчдийг өрсөлдөх тэгш боломжоор ханган тендерийн урилгыг цаг тухай бүр www.chingeltei.gov.mn цахим хуудсанд 54, www.tender.gov.mn цахим хуудсанд 9, өдөр тутмын сонинд 21 нээлттэй тендерийн урилгыг нийтлүүлж мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллалаа. Дүүрэгт 2017 онд хийж хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороодод иргэдийн төлөөлөл болж 6 иргэн, Төрийн бус байгууллагын төлөөлөл 4 иргэн, Захиалагчийн төлөөлөл 6 хүн оролцсоноор худалдан авах ажиллагааны иргэдийн оролцоог ханган ажиллалаа. Худалдан авах ажиллагааны хэмнэлттэй байх зарчмыг баримтлан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх 25 төсөл, хөтөлбөр, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь зохион байгуулж, төсвийн дүн болон гэрээ байгуулсан үнийн дүнгээс 10 985 700 төгрөгийн хэмнэлт үүсгэсэн. Мөн дүүргийн төсвийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх нийт 29 төсөл, | 70 | |

| | | | | | | | |
|----|---|--|---------------------------------------|------|---|---|----|
| | | | | | | <p>арга хэмжээнээс 27 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, төсвийн дүн болон гэрээ байгуулсан үнийн дүнгээс 161 596 093 төгрөгийн хэмнэлт үүсгэсэн болно. Мөн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны “Нийслэлийн 2017 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 10/13 дугаар тогтоолоор батласан 580 000 000 төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 төсөл, хөтөлбөр, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2017 оны А/339, А372 дугаар захирамжуудаар тус тус дүүргийн Засаг даргад эрх шилжүүлэн дүүргийн Засаг даргын А/333, А/334, А/353 дугаар захирамжуудад үндэслэн худалдан авах ажиллагааг 100 хувь зохион байгууллаа.</p> | |
| 40 | <p>2.1.5 Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хүн амд нийгмийн даатгалын үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэж, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.</p> | <p>1. Иргэн бүрийг нийгмийн даатгалд хамруулах талаар сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулж, заавал даатгуулагч болон ажил олгогчийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.</p> | <p>Даатгалд хамрагдагсдын тоогоор</p> | 100% | - | <p>Нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг хамруулах, хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлуудыг зохион байгуулсны үр дүнд оны эхнээс шинээр 275 ажил олгогч, 984 даатгуулагчийг бүртгэн, шимтгэл тооцох цалингийн сан 697,8 сая төгрөгөөр нэмэгдэж, нийгмийн даатгалын сангийн орлого 98270,7 сая төгрөг төвлөрүүлэхээс 8 дугаар сарын 20-ны байдлаар 110477.7 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөт зорилтоо 112.4 хувиар биелүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн орлого 13405.1 сая төгрөгөөр буюу 11,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийгмийн даатгалын байгууллага үүсч хөгжсөний 75 жилийн ойг тохиолдуулан зарласан “Чанартай үйлчилгээ-соёлтой харилцаа” 75 хоногийн аяны хүрээнд “Нээлттэй өдөрлөг-Нэг цонхны үйлчилгээ” сэдэвт өдөрлөгийг зохион байгуулж, 1-19 дүгээр</p> | 90 |

| | | | | | | | |
|----|-------|--|----------------------------------|------|---|---|----|
| | | | | | | хороодод 6 удаа, хэлтэс, албадуудтай хамтарсан өдөрлөгийг 7 удаа зохион байгуулж, нийт 3450 гаруй иргэн, даатгуулагчдад нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжоор зөвлөгөө мэдээлэл өгч, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. “Хүнсний биш худалдаа эрхлэгчдэд зориулсан хууль сурталчлах сургалт”-нд 70 гаруй худалдаа эрхлэгчид, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 13 аж ахуйн нэгж байгууллагын 714 инженер техникийн ажилтнууд, “Бөмбөгөр худалдааны төвийн 300 гаруй түрээслэгчид хамрагдаж, нийт 2100 орчим тараах материалыг тараасан. Ерөнхий боловсролын сургуулиудын төгсөх ангийн 514 сурагчдын дунд “Даатгалтай ирээдүй” аяныг зохион байгуулж, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжуудын ач холбогдлыг сурталчлах ажлыг хийж хэрэгжүүлсэн. | |
| 41 | | 2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж төлөх үйлчилгээг арилжааны банкны ухаалаг үйлчилгээ ашиглан төлөх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | Даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл авах ndaatgal.mn "Даатгуулагчийн бүртгэл"-д 8617 даатгуулагчийг бүртгэснээр даатгуулагч өөрийн төлсөн шимтгэлийг цахим хаягаараа хүлээн авах боломжтой болсон. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн цахимаар илгээсэн тайлан авалт 97,3 хувьтай явагдаж байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг гар утасны ухаалаг үйлчилгээ, цахим хэлбэрээр төлөх ажлыг ХААН банкт хамтран зохион байгуулж 7 хоногийн 1 өдөр банкны ажилтан хэлтэс дээр байрлан ухаалаг үйлчилгээг иргэдэд танилцуулах өдөрлөг явагдаж байна. Одоогийн байдлаар нийт шимтгэл төлөгчдийн 45 хувь нь нийгмийн даатгалын шимтгэлээ цахимаар төлж байна. | 70 |
| 42 | 2.1.6 | 1. Дүүргийн | Үйл | 100% | - | Дүүргийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтийн | 70 |

| | | | | | | | |
|----|--|---|----------------------------------|------|---------------------|---|----|
| | Статистикийн тоон мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг сайжруулж, үнэн зөв байдлыг ханган, мэдээ судалгааны хамрах хүрээг өргөжүүлнэ. | нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтээр Статистикийн эмхтгэл, нийгэм, эдийн засгийн танилцуулгыг сар, улирал, жилээр гаргаж иргэн аж ахуй нэгж байгууллагыг мэдээллээр хангана. | ажиллагааны хэрэгжилт хувиар | | | эмхэтгэлийг дүүрэг үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ойн хүрээнд 1992-2016 оны динамик үзүүлэлтүүдийг багтаахаар ажиллаж, мэдээлэл цуглуулах ажлыг хийж дуусгасан. Дүүргийн нийгэм, эдийн засгийн танилцуулгыг сар бүр эмхэтгэн нэгтгэж, Нийслэлийн статистикийн газар, дүүргийн цахим хуудсанд тогтмол байршуулж, иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг мэдээллээр хангаж байна. | |
| 43 | | 2. Хүн ам, өрхийн мэдээллийн санг баяжуулж, оршин суугчдын аюулгүй байдлын судалгаа, орон сууцны хангамж нөхцөл байдлын судалгаа, хүн ам, хөдөлмөр эрхлэлтийн судалгааг тодотгон шинэчилнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн алдааг тухай бүр хороодод хүргүүлж, орон сууцны төрөл, боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, хөдөлмөр эрхлэлт зэрэг нөхөгдөөгүй мэдээллүүдийн баяжилтыг хийлгэн, алдааг залруулж ажиллаж байна. Албан ёсны болон захиргааны статистик мэдээллээр хийгдэх орон сууцны нөхцөл хангамж, мал тэжээвэр амьтдад болон хөдөө аж ахуйн судалгаа, хүн ам хөдөлмөр эрхлэлт, дүүргийн оршин суугчдын аюулгүй байдлын судалгаануудын үзүүлэлтийг нэгтгэх ажиллагаа хийгдэж байна. | 50 |
| 44 | 2.1.7 Монгол Улсын Татварын тухай болон бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган, татварын өр барагдуулалтыг стандартад | 1. Нэмэгдсэн өртгийн албан татвар, Нийслэл хотын албан татварын хуулийг сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж, иргэдийн татварт хамрагдалтыг | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 12.0 | Тус дүүргийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй төлбөрийн баримт олгох үүрэг бүхий 3755 бизнес эрхлэгч хувь хүн, хуулийн этгээдийн ажлын байранд очиж НӨАТУС-ийн нэгдсэн цахим төлбөрийн системийн талаар зөвлөгөө өгч ажиллалаа. Төлбөрийн баримт олгохгүй байгаа 2390 иргэн, аж ахуй нэгжид шаардлага гардуулан хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Цахим төлбөрийн баримтын системд 2017 онд шинээр 776 иргэн, | 70 |

| | | | | | | | |
|----|--|---|----------------------------------|------|--------------------|--|----|
| | хүргэж, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, татварын бааз суурийг өргөтгөнө. | нэмэгдүүлнэ. | | | | аж ахуй нэгж шинээр бүртгүүлэн холбогдсон байна. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж буй зочид буудал, бар, ресторан, паб зэргийг бүртгэх, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийг тайлбарлан таниулах ажлын төлөвлөгөө гарган ажиллалаа. Тооллогоор 178 объект хамрагдсанаас 133 аж ахуй нэгж, иргэн нь кассын хэвлэх төхөөрөмжтэй болон Е баримт хэвлэн өгч байна. Нийт 117 иргэн, аж ахуй нэгж НХАТ төлөгчөөр бүртгэлтэй, 61 аж ахуй нэгж, иргэн нь бүртгэлгүй байсан. Манай дүүрэгт бүртгэлтэй боловч НХАТ төлөгчөөр бүртгүүлэх шаардлагатай 19 иргэн, аж ахуй нэгжийн 11 аж ахуй нэгжийг бүртгээд байна. Бусад дүүрэгт бүртгэлтэй 25 аж ахуй нэгж, 6 иргэнийг мэдээллийг харьяалах дүүрэгт нь бүртгэн авах талаар албан бичгээр хүргүүлж ажилласан. | |
| 45 | | 2. Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй томоохон зах, худалдааны төвүүдийг татварын албаны “Нэгдсэн ба хэрэглэгчийн систем”-д холбон бүртгэлжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 6.0 | Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон зах худалдааны төвүүдийн удирдлагуудад Татварын ерөнхий хууль болон НӨАТ-ын тухай хууль, НХАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар уулзалт ярилцлага зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд томоохон зах, худалдааны төвүүд болох Тэди, Монтел, Моби шоп, Пийс тауэр, МВ, Алтжин, Содон, Юмт бөмбөгөр гэсэн 6 худалдааны төвд тасгийн дарга нараар ахлуулсан 6 баг хуваарилагдан ажиллаж, худалдааны төвүүдийн удирдлага болон түрээслэгч нартай уулзаж хуулийн хэрэгжилтийн талаарх нэгдсэн сургалтуудыг зохион явуулсан. Худалдааны төвүүдэд үйл ажиллагаа явуулж байгаа 1489 ажлын байранд биечлэн очсоноос 1157 иргэн, аж ахуй нэгжид НӨАТУС-д холбогдон бүртгүүлэх шаардлагыг биечлэн хүргүүлж ажилласан. Нарантуул-2 худалдааны төвд дундын пос терминал төхөөрөмж тавьж манай дүүрэгт харьяалагдах 115 бизнес эрхлэгчдэд Е баримт олгох код | 70 |

| | | | | | | | |
|-----------------------------|---|---|----------------------------------|------|-----------------------|--|----|
| | | | | | | олгон бүртгэснээр үйлчлүүлэгч нарт цахим төлбөрийн баримт олгож эхлээд байна. | |
| 2.2 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ | | | | | | | |
| 46 | 2.2.1 Дотоодын ажиллах хүчний нөөцийг үр дүнтэй ашиглаж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн жилд 2000-аас доошгүй мэргэжилтэй ажилчдыг сургаж, хөдөлмөрийн насны иргэдийг ажлын байраар хангана. | 1. Ажил олоход хүндрэлтэй, сургууль завсардсан иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг үзүүлж, 1000 иргэнийг ажлын байртай болгоно. | Ажилд зуучилсан иргэдийн тоогоор | 100% | Улсын төсөв | Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд нийт 756 иргэнийг хамруулснаас ганцаарчилсан зөвлөгөөнд 446 иргэн, бүлгийн сургалт, зөвлөгөөнд 310 иргэнийг хамруулсан. Зөвлөгөө, мэдээлэл авсан иргэдийн 95 хувь нь ажил хайгчид бөгөөд насны бүлгээр нь авч үзвэл 25-34 насны залуучууд болон 55-59 насны иргэд дийлэнх хувийг эзэлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг иргэдэд шуурхай, ил тод хүргэх, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний үр дүнг нэмэгдүүлэх, иргэдийг зөвлөгөө, мэдээллээр хангах зорилгоор 16, 17 дугаар хороодод Ажлын байрны нээлттэй өдөрлөг, явуулын биржийг ажиллуулсан ба хуваарийн дагуу 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл бусад хороодод зохион байгуулахаар ажиллаж байна. | 50 |
| 47 | | 2. Ажил, мэргэжилгүй иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн болон давтан сургалтад хамруулж, 60-аас доошгүй хувийг нь ажлын байраар хангана. | Ажилд зуучилсан иргэдийн тоогоор | 60% | Улс, нийслэлийн төсөв | Ажил идэвхтэй хайж хандсан иргэдийг бүртгэн авч ажил олгогч байгууллагаас ирсэн ажлын байрны захиалгын дагуу иргэдийг хүсэл сонирхол, дадлага туршлага, ур чадварыг нь харгалзан ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн тохирох ажлын байранд холбон зуучлах үйлчилгээг үзүүлж, 1784 иргэнийг ажил хайгч иргэний бүртгэл, хөдөлмөрийн зах зээлийн Хөдөлмөрийн зах зээл-2 маягтаар бүртгэн авч, холбогдох мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан /LMIS/-д бүртгэлжүүлэн оруулсан. Хөдөлмөрийн зах зээлийн LMIS программын мэдээллийн санд ажил хайгч 1686 иргэн, 400 ажил олгогчийн 1917 ажлын байрны захиалга авч, 273 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан. | 50 |

| | | | | | | | |
|----|--|--|---|-------------------------|---------------------------------------|---|----|
| 48 | 2.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн зах зээлд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, иргэдийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлнэ. | 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломжийг судлан хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамруулна. | Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоогоор | 100% | Улс, нийслэлийн төсөв, ОУБ-ын дэмжлэг | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдахаар 91 төслийг хүлээн авч төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн 54 төсөлд 89.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 70 |
| 49 | Хөдөлмөрийн зах зээлд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, иргэдийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлнэ. | 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хөгжүүлэх төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан, нийгэм хамт олонд түшиглэсэн үйлчилгээг өргөжүүлнэ. | Хамрагдаж буй хүүхдийн тоогоор | 2-3 төвийг бий болгоно. | Дүүргийн төсөв | Дүүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч хөгжүүлэх үйл ажиллагаа явуулж буй “Гэгээлэн” /17-р хороо/, “Шинэ хос номин оюу” /9-р хороо/, 16-р хороонд байрладаг “Сайн хөрш” нийгэмлэг, 18-р хороонд байрладаг ХТҮГ-ын харьяа Хүүхэд хамгааллын төвүүдээр дамжуулан 150 гаруй хүүхдүүд асаргаа сувилгаа, хөгжлийн үйлчилгээ авч байна. Хүүхэд харах үйлчилгээний 8 газар ажиллаж байгаа бөгөөд эдгээрт 5 ХБХ хамруулан хөгжүүлж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, тэдний сурч хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн “Чингэлтэйн боловсрол-2020” хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд суралцах боломжийг бүрдүүлсэн тусгайлан заалт оруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Хайлааст ОНХХ, Хараат бус судалгааны хүрээлэнтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд тэгш хамран сургах “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийг 13-19 дүгээр хороонд хэрэгжүүлэн ажиллаж байна. | 70 |

| | | | | | | | |
|----------------------------------|---|---|-----------------------------------|-------------------|---------------------|---|----|
| 50 | 2.2.3 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний “Чингэлтэй” сүлжээг өргөжүүлэн, залуу ахмад үеийн залгамж холбоог бэхжүүлнэ. | 1. Дүүрэг, хорооны ахмадын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, ажлын дадлага, туршлагатай ахмадуудын баг, бүлэг байгуулах үүсгэл санаачилгыг дэмжин ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | Дүүргийн төсөв 87.3 | Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний Зөвлөлийн 01 дүгээр тушаалаар батлагдсан “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нь нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн мэдлэг, ажлын туршлагыг нь өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх, өсвөр хойч үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдах арга хэмжээнд нийт 57 иргэн төсөл ирүүлснээс 22 төсөл шалгарч, 17.500.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгогдсон. Зөвлөх үйлчилгээний 37 төсөл ирүүлснээс 7 төсөл сонгогдоод байна. | 70 |
| 51 | 2.2.4 Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ. | 1. “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 30% | Дүүргийн төсөв 50.0 | Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг Монгол улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 27 дугаар тогтоолоор батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 6 бүлэг 22 үйл ажиллагаа бүхий ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд дүүргийн төсвийн 283,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 30 цэгт ажлын байр байгуулсан. | 70 |
| 2.3 ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ | | | | | | | |
| 52 | 2.3.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг | 1. “Чингэлтэйд үйлдвэрлэв” | Үйл ажиллагааны | 300 дээш үйлдвэрл | Дүүргийн төсөв 90.0 | “Чингэлтэйд үйлдвэрлэв” салбар дэлгүүрүүдэд нийт 201 иргэний бараа бүтээгдэхүүн | 70 |

| | | | | | | | |
|----|---|---|----------------------------------|---|---------------------|--|----|
| | дэмжих “Чингэлтэйд үйлдвэрлэв” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ. | худалдааны төвийн үйл ажиллагааг сайжруулан зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. | хэрэгжилт хувиар | эгч хамруулна | | худалдаалагдаж, нийтдээ 108,1 сая төгрөгний борлуулалт хийсэн байна. Чингэлтэйд үйлдвэрлэв салбар дэлгүүрүүдийн борлуулалтыг идэвхжүүлэхээр 2 иргэнийг нэмж худалдагчаар ажиллуулсан ба барааны өрөлт хураалтыг шинэчилэн зохион байгуулж, бараа бүтээгдэхүүний ангилал төрөлжилтийг хийсэн. Бараа бүтээгдэхүүний 5-15 хувийн хямдралтай худалдааг 2017 оны 02 сарын 01-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд явуулсан. Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвтэй хамтран жижиг дунд үйлвэрлэл эрхлэгчдэд зориулсан худалдан борлуулж буй бараа бүтээгдэхүүнээ хэрхэн хаягжуулах, бараа бүтээгдэхүүний сав баглаа боодлын давуу тал ач холбогдлын талаарх сургалтанд “Чингэлтэйд үйлдвэрлэв” дэлгүүрийн 2 ажилтныг хамруулсан. Чингэлтэйд үйлдвэрлэв 3 салбар худалдааны төвийг дүүргийн 12 дугаар хороонд байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | |
| 53 | | 2. Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, олон улсын болон дотоодын үзэсгэлэн худалдаанд үйлдвэрлэгчдийг хамруулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 10-с дээш удаагийн үзэсгэлэнд 150 гаруй үйлдвэрлэгч хамруулна | Дүүргийн төсөв 15.0 | Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Бизнес инкубатор төв, “Нэг Архангай” төрийн бус байгууллагатай хамтран “Цагаан сар” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, Архангай аймгийн Чулуут, Өндөр-Улаан, Хангай, Цахир, Ихтамир, Тариат, Булган сумдын нийт 90 гаруй малчдын 10 гаруй нэр төрлийн 130,0 гаруй тн цагаан идээний борлуулалт хийсэн. Тус үзэсгэлэн худалдааны үеэр дүүргийн жижиг дунд өрхийн үйлдвэр эрхлэгч 12 иргэн 10-15 нэр төрлийн ноос ноолууран эдлэл, монгол дээл, монгол гутал, хүүхдийн буриад гутал, савхин бээлий, ууж хантааз, авдар, тавгийн цар, хэвийн боов, жимс жимсгэнэ зэргээр бүтээгдэхүүнээ төрөлжүүлэн худалдаалж 15,0 сая төгрөгний борлуулалт хийсэн. Мөн Гүүд Нэйборс ОУТББ-ийн “Тахилт” орон нутгийн хөгжлийн төвд хамрагддаг Хүннү кашмер сүлжмэлийн бүлгийн | 70 |

| | | | | | | | |
|----|---|--|---|---------------------|---|--|----|
| | | | | | | <p>гишүүдийг үзэсгэлэн худалдаанд оролцуулж 8 нэр төрлийн 1,5 сая төгрөгний бараа худалдаалсан байна. Цагаан сарын үзэсгэлэн худалдаануудад давхардсан тоогоор 116 үйлдвэрлэгч оролцож нийт 81.888.500 төгрөгний борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 31,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 05-р сарын 02-ны өдрийн 08 дугаар хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу 2017 оны 7 дугаар сард Манжуур хотод зохион байгуулагдах Монгол-Орос-Хятадын үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаанд дүүргийн өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгчдийг оролцуулах ажлыг зохион байгуулж 16 иргэн, аж ахуй нэгж, бизнес эрхлэгчдийн төлөөллийг оролцуулж, 3 хоногийн үзэсгэлэнгийн хугацаанд нийт 20,1 сая төгрөгний борлуулалт хийгдсэн.</p> | |
| 54 | <p>2.3.2 Жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлогыг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.</p> | <p>1. Жижиг дунд үйлдвэрийн салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлогыг хэрэгжүүлж, үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин ажиллана.</p> | <p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p> | <p>Гүйцэтгэлээр</p> | - | <p>Тайлант хугацаанд 40 гаруй үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээлд хамруулах хөтөлбөрийн дагуу бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд санхүүгийн дэмжлэг хүссэн үйлдвэрлэгчдэд жижиг зээлийн төсөл боловсруулах зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Дэлхийн зөн ОУБ-ын эдийн засгийн хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмжийн дэмжлэг олгох төсөлд 21 иргэний төсөл ирүүлснээс 9 иргэний төсөл дэмжигдэж үсчин, арьсан оёдол, шулуун оёдлын машины дэмжлэг олгохоор шийдвэрлээд байна. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн тоног төхөөрөмж, технологийг сайжруулан өрхийн үйлдвэрлэгчдийг чадавхижуулах зорилго бүхий “Хамтдаа бүтээе” тоног төхөөрөмжийн төслийг амжилттай хэрэгжүүллээ. Уг төслийн хүрээнд Чингэлтэй дүүргийн 7-19 хороонд үйлдвэрлэл эрхлэгч 45 иргэнд үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног</p> | 70 |

| | | | | | | | |
|----|---|---|--|--|---------------------|---|----|
| | | | | | | төхөөрөмжийн дэмжлэгийг олгосон. Энэхүү төсөл хэрэгжсэнээр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт тулгамдаж буй тоног төхөөрөмж, технологийн шинэчлэл шаардлагатай үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх, үйлдвэрлэгчдийн хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэх, чанар стандарт сайжрах, хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжоор хангагдаж байна. | |
| 55 | 2.3.3 Бизнес инкубатор төвийг бүсчилсэн хэлбэрээр нэмж байгуулна. | 1. Бизнес инкубатор төвийн салбаруудын тоог нэмэгдүүлэх, үйлдвэрлэл эрхлэгчдийг түрээсийн хөнгөлөлттэй ажлын байраар хангах, зөөврийн ажлын байрны үйл ажиллагааг сайжруулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 30 гаруй иргэд хөнгөлөл тэй ажлын байраар хангагдана. | - | Тайлант хугацаанд Бизнес инкубатор төвийн хөнгөлөлттэй түрээсийн байранд 12, 11-р хорооны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих инкубатор төвийн байранд 1, 12-р хорооны салбар байранд 2, 17-р хорооны салбар байранд 2 үйлдвэрлэгч тус тус бойжиж байна. Бизнес инкубатор төвийн төв байранд шинээр 12 мкв хэмжээтэй өрөөнд 12 дугаар хорооны зөөлөн оёдлоор үйлдвэрлэл эрхэлдэг 1 иргэнийг хөнгөлөлттэй түрээсийн байраар ханган ажиллаж байна. Дүүргийн төсвийн 283,2 сая төгрөгийн хөрөнгөөр 30 явуулын ажлын байр, 56,0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж нийлүүлж ажлын байрны үйл ажиллагааг дэмжин ажиллалаа. | 70 |
| 56 | | 2. Бизнес эрхлэгчдийн мэдлэг, бизнес эрхлэх ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшсэн сургалтуудыг зохион байгуулна. | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо | 5 дээш удаагийн сургалта нд 80 гаруй иргэдийг хамруулна. | Дүүргийн төсөв 20.0 | Бизнес эрхлэгчдийн аж ахуй эрхлэх ур чадварыг олгох хөтөлбөрийн сургалт, бизнес эрхлэгчийн хувь хүний болон бизнесийн хөгжлийг дээшлүүлэх зорилгоор 2017 онд 6 төрлийн 20 удаагийн сургалтад нийт 350 үйлдвэрлэгч хамруулахаар төлөвлөсөн ба 8 дугаар сарын байдлаар 5 төрлийн сургалт зохион байгуулж, 84 үйлдвэрлэгчийг хамруулаад байна. | 90 |
| 57 | | 3. Инновацид суурилсан | Үйл ажиллагааны | 100% | Дүүргийн төсөв 50.0 | Тайлант хугацаанд нийт 150 гаруй иргэдэд кластерын талаар зөвлөгөө мэдээлэл өгч, | 70 |

| | | | | | | | |
|----|--|--|----------------------------------|------|---------------------|---|----|
| | | Кластерын төвийг хөгжүүлэн тогтворжуулж, бүсчилсэн байдлаар өргөжүүлнэ. | хэрэгжилт хувиар | | | тогтмол 15 иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна. Кластерийн төв нь эхний хагас жилийн байдлаар 20 гаруй байгууллага аж ахуй нэгжээс 90 гаруй сая төгрөгний 1570 гаруй хувцасны захиалга авч нийлүүлсэн. Дэлхийн Зөн ОУБ-д хүсэлт гаргаж арьсан бүтээгдэхүүн оёдог хатуу оёдлын ТА – 1130 загварын 2 ширхэг машины дэмжлэг 10, 12 дугаар хорооны 2 иргэнийг ажиллуулж арьсан цүнх үйлдвэрлэж байна. Кластерын төвд давхардсан тоогоор 200 орчим үйлдвэрлэгчидтэй уулзаж, сургалт хийснээр 20 гаруй үйлдвэрлэгч иргэдийн бүрэлдэхүүнтэй “Баялаг бүтээмж” хоршоог үүсгэн байгуулсан. Тус хоршооны гишүүдийн 5 иргэн нь өөрийн гэсэн цехтэй учир кластерын төвийн тусгай зориулалтын машинаар үйлчлүүлж жижиг кластерын системээр ажиллаж байна. Хоршоо нь зөөлөн оёдол, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэгдсэн технологид тулгуурласан үйлдвэрлэлийн дамжлагын системийг нэвтрүүлээд байна. “Баялаг бүтээмж” хоршоо нь арьсан эдлэл, хүүхдийн хувцасны “ББ” брэнд үүсгэн өөрийн гэсэн хаяг логотой болж, оюуны өмчөөр баталгаажуулах хүсэлтээ өгсөн. | |
| 58 | 2.3.4 Үйлдвэрлэл, үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх, оюуны багтаамжтай үйлдвэрлэлийг голлосон инновацийг нэвтрүүлнэ. | 1. Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээнд олон улсын стандартын ноу-хау дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 10.0 | Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих “Бизнес инкубатор төв”-ийн бойжигч, үйлдвэрлэгчдийн төлөөлөл Багануур дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн ажилтан, бойжигчдийн төлөөлөлтэй уулзаж, туршлага солилцсон. Энэ үеэр дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих “Бизнес инкубатор төв”, “Кластерын төв”, “Чингэлтэйд үйлдвэрлэв” худалдааны төвүүд, Зөөврийн ажлын байрны төсөл хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийн үйлдвэрлэл, 10 дугаар хороонд байрлах нийтийн хоолны тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл худалдааны “Чиглэл” ХХК-ийн үйл ажиллагаатай | 50 |

| | | | | | | | |
|---|--|--|----------------------------------|------|--------------------|--|----|
| | | | | | | танилцуулсан. Мөн дүүргийн кластерын төвийн үйл ажиллагааг сурталчилах хамтын ажиллагааг сайжруулах, харилцан туршлага судлах ажлуудыг тогтмол зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд дүүргийн Кластерын төвийн үйл ажиллагаатай Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Үйлдвэрлэл Инновацийн газрын албаны хүмүүс ирж туршлага судалж зөвлөмжийг өгч цаашид хамтран ажиллахаар шийдвэрлээд байна. | |
| 2.4 ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ | | | | | | | |
| 59 | 2.4.1 Хүн амыг эрүүл, баталгаатай хүнсээр хангах зорилтын хүрээнд хэрэглэгчдийн хүнсний талаарх боловсролын түвшинг дээшлүүлэх олон талт ажлыг зохион байгуулна. | 1. Дүүргийн худалдаа, үйлчилгээний газруудын нэгдсэн мэдээллийн санг бий болгож, бүртгэлжүүлэн мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 7.0 | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг тодорхойлох, хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа төрийн байгууллагын зүгээс мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх зорилгоор тайлант хугацаанд нийт 476 иргэн, аж ахуйн нэгжтэй “ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ГЭРЭЭ”-г байгуулан, мэдээллийн санд бүртгэлжүүлэн хог хаягдал гаргасны төлбөр хураамжинд 55,5 сая төгрөгийг дүүргийн татварын орлогод төвлөрүүлэн ажилласан. Мэдээллийн нэгдсэн санд архины тусгай зөвшөөрөлтэй 426, тамхины тусгай зөвшөөрөлтэй 259, хүнсний мухлагны тусгай зөвшөөрөлтэй 215, хүнс биш барааны тусгай зөвшөөрөлтэй 220 аж ахуй нэгжийг бүртгэж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. | 70 |
| 60 | | 2. Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний "Хоолны газрын | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | Нийслэлийн Засаг даргын орлогчийн баталсан ерөнхий боловсролын сургуулийн цайны газрын “Үдийн цай” хөтөлбөрт шалгалт хийх удирдамжийн дагуу дүүргийн төрийн өмчийн 12, хувийн хэвшлийн 6, нийт 18 ерөнхий | 70 |

ангилал,
зэрэглэл, үндсэн
шаардлага MNS
4946:2005"
стандартыг
мөрдүүлэн
ажиллана.

боловсролын сургуулийн цайны газрын “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд шалгалт хийсэн. Шалгалтанд хамрагдсан сургуулиудад нийт 23904 сурагч, 1174 багш, ажилтан ажиллаж үүнээс **336 бүлэгт 12121** бага ангийн сурагчид “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж байгаа нь нийт сурагчдын **48 хувийг** эзэлж байгаа буюу 35 хувь нь мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон Ажлын байрны дүгнэлттэй, үлдсэн нь стандартын шаардлага хангахгүй, ажлын байрны дүгнэлтгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа тухай дүгнэлтийг Нийслэлийн ажлын хэсэгт хүргүүлсэн. Хүн амыг эрүүл, баталгаатай хүнсээр хангах зорилтын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудийн “Үдийн цай хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэгч болон хоол үйлдвэрлэл үйлчилгээний ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Олон улс дахь сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ" ба "Үдийн цай хөтөлбөр"-ийн өнөөгийн байдал сэдэвт сургалтыг дүүргийн хурлын танхимд зохион байгуулсан. Сургалтанд дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн нийт 18 сургуулийн цайны газрын түрээслэгч, тогооч, сургуулийн эмч, эцэг эхийн зөвлөлийн гишүүн нийт 50 гаруй хүнийг хамруулсан. МХЕГ-ын даргын 2017 оны “2017-2018 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг шалгах тухай” 01/93 дугаар удирдамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн МХГ-ын даргын баталсан хуваарийн дагуу дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран цэцэрлэгүүдийн хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил хангагдсан байдалтай танилцаж, хяналт тавьж ажилласан. Шалгалтын үеэр хэсгийн болон зөөврийн усан хангамжтай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн ундны ус нь стандартын шаардлага хангасан

| | | | | | | | |
|----|--|--|----------------------------------|------|--------------------|--|----|
| | | | | | | байдалд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор сорьц авч, НМХГ-ын Нэгдсэн төв лабораторид хүргүүлсэн. Ажлын хэсгээс сургууль, цэцэрлэгүүдэд хичээлийн шинэ жилийг угтаж цэвэрлэгээ үйлчилгээг хийх, мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэл, шавжгүйтгэл хийлгэх, завсар үйлчилгээг бүрэн хангуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. | |
| 61 | | 3. Зах, худалдааны төвүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, тээвэрлэлт, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалалтад хяналт тавьж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 5.0 | “Эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 7 худалдааны төвүүдийн захирлуудтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд хамтран ажиллах чиглэлээ тодорхойлон АЛБАН ДААЛГАВАР хүргүүлэн ажилласан. Хамтран ажиллах чиглэлийн хүрээнд Нарантуул, Хүчит шонхор төвүүд “Эрүүл хүн-Эрүүл хүнс” аяныг зохион байгуулж нийт 800 гаруй түрээслэгч, 1200 гаруй иргэд хамрагдан хэрэглэгчээ дээдэлсэн соёлтой үйлчилгээ, эрүүл, аюулгүй, баталгаатай бүтээгдэхүүнээр үйлчилж байна. Дээрхи захууд хэрэглэгчийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн утсаар, цахим хэлбэрээр өргөдөл гомдол хүлээн авдаг ажилтантай болж 4 ажлын байрыг шинээр нэмсэн байна. “Аюулгүй хүнс” сарын аян зохион байгуулж, аяны хүрээнд дүүргийн худалдаа, үйлчилгээний 23 аж ахуйн нэгжийн 45 иргэнийг оролцуулан, хууль, тогтоомжийг сурталчилан таниулах зорилгоор зөрчилтэй хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргаж, худалдаалах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас болон хэрэглэгчийн хяналтын хуудсыг сурталчилан ажиллалаа. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй сургуулийн ойр орчимд худалдаа, үйлчилгээ эрхэлдэг 11 аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтын ажилтан болон хүнсний | 70 |

| | | | | | | | |
|----|--|--|--|------|--------------------|---|----|
| | | | | | | худалдаа эрхлэгч иргэдийг хамруулан “Хүнсний баталгаат байдал”, “Хүнсний аюулгүй байдлыг хангуулахад ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөх, түүний ач холбогдол”, “ЕБС-ийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах шаардлага, сурагчдад зориулсан үйлчилгээнд хориглох хүнсний бүтээгдэхүүн”, “дотоод хяналт хэрэгжүүлэх нь” зэрэг сэдвүүдээр онлайн хэлбэрээр сургалт зохион байгуулсан. | |
| 62 | 2.4.2 Худалдаа үйлчилгээний салбаруудад тавигдах стандартын хэрэгжилтийг ахисан түвшинд хүргэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана. | 1. Худалдаа, хоол үйлдвэрлэлийн салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, эрх зүйн чиглэлээр сургалт, өдөрлөг, уралдаан тэмцээн зохион байгуулна. | Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо | 100% | Дүүргийн төсөв 5.0 | Худалдаа, үйлчилгээний салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх, жижиглэнгийн худалдаанд олон улсын стандартыг нутагшуулах боломж, ая тухтай март дэлгүүрийн туршлага, худалдааны мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх сургалтыг Худалдааны академийн сургалтын төвтэй хамтран 2 үе шаттайгаар зохион байгуулж, давхардсан тоогоор 52 аж ахуйн нэгж хамрагдсан. “Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журам” батлах тухай Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 1-6 дугаар хороонд хүнсний биш барааны худалдаа эрхэлдэг 110 гаруй ААНБ, иргэдийн судалгааг гарган ШӨХТГ, Худалдааны дээд сургууль, ЭМНДХ, ХЭАХН-тэй хамтран “Хууль сурталчлах” сургалтыг зохион байгуулж 50 аж ахуйн нэгж, иргэд хамрагдсан. Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэлийн жилийн хүрээнд “Нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын шинэчилсэн төслийн нээлттэй хэлэлцүүлгийг УБ хотын ЗАА-ны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран Бишрэлт зочид буудлын хурлын танхимд зохион байгуулж 250 аж ахуйн нэгж, 18 иргэний төлөөлөл, хороодын Засаг дарга, хороодын | 90 |

| | | | | | | | |
|----|---|--|----------------------------------|------|---|--|----|
| | | | | | | <p>Засаг даргын Ажлын албаны дарга 24, нийт 292 хүн оролцсон. 12 дугаар хорооны Засаг даргын Ажлын албатай хамтран “Хууль сурталчлах өдөрлөг”-ийг зохион байгуулж, худалдааны байгууллагуудын өнөөгийн чиг хандлага, худалдааны ёс зүй, худалдан борлуулж буй бараа бүтээгдэхүүний өрөлт, хураалт зэрэг сэдвүүдээр МЖДДХ-ноос мэдээлэл хийж давхардсан тоогоор 60 гаруй аж ахуйн нэгж, иргэд оролцуулж, дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс тус бүрийн чиглэлээр мэдээллэл хийсэн. Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд бизнес эрхлэгчдийг холбох үйл явцыг эрчимжүүлэх зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт төвлөрсөн зах, худалдааны төв, үүрэн телефон, худалдаа үйлчилгээний байгууллагуудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, Татварын тухай хууль тогтоомж, нийслэлийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмын талаар харилцан мэдээллэл солилцож чиглэл үүрэг өгч ажилласан. Энэхүү уулзалтаас гарсан шийдвэрийн дагуу Хүчит Шонхор, Мобиком, Эрдэнэбулган, Алтжин худалдааны төвүүдийн түрээслэгч нарт Татварын хэлтсээс давхардсан тоогоор 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд Е баримт хэвлэдэг автомат төхөөрөмж худалдаалдаг компаниудын танилцуулгыг өдөрлөг хэлбэрээр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.</p> | |
| 63 | 2.4.3 Иргэдийг чанартай, экологийн цэвэр бүтээгдэхүүн, хүнсний ногоогоор хангах | 1. Өвлийн хүлэмжийн аж ахуйг дэмжиж, иргэдийг шинэ жимс, хүнсний ногоогоор | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | <p>Дүүргийн төсвийн 47,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар өвлийн хүлэмж барьсан. Иргэдийг өөрийн оршин суух хашаандаа хэрэглээний төмс, хүнсний ногоогоо тарьж ургуулахад дэмжлэг үзүүлэх үүднээс Нийслэлийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Швейцарийн хөгжлийн</p> | 70 |

| | | | | | | | |
|----|--|--|----------------------------------|------|--------------------|--|----|
| | нөхцлийг бүрдүүлж, газар тариалан эрхлэгчдийг бараа бүтээгдэхүүнээ борлуулахад нь дэмжлэг үзүүлнэ. | тогтмол хангах боломжийг бүрдүүлнэ. | | | | агентлагын санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол ногоо” төсөлтэй хамтран Тариаланчдын 2 удаагийн цогц сургалтыг 4 болон 7 дугаар саруудад зохион байгуулсан. Сургалтыг танхимын болон дадлагын хичээлийн хөтөлбөрөөр явуулсан бөгөөд нийт 14 хороодын төмс, хүнсний ногоо тариалдаг, цаашид тариалах хүсэлтэй нийт 85 иргэн хамрагдаж, өөрсдийн мэдлэгийн түвшингөө дээшлүүлсэн. | |
| 64 | | 2. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний аж ахуй эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, иргэдэд эрүүл, баталгаатай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдан борлуулах сүлжээг боловсронгуй болгоно. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 7.0 | Иргэдэд эх орны хөрсөнд ургасан, хямд чанартай төмс, хүнсний ногоо нийлүүлэх ажлын хүрээнд дүүргийн 16, 17 дугаар хороонд байрлах ногоо худалдаалах чингэлгүүдэд өрх толгойлсон, эмзэг бүлгийн нийт 6 иргэнийг түр ажлын байраар ханган төмс, хүнсний ногоо худалдаалах ажлыг зохион байгуулж 5 сараас 8 сар хүртэлх хугацаанд нийт 3.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Байгаль орчныг хамгаалах, мод үржүүлгийн аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг дэмжих, зорилгоор “Мод, бут, сөөгний суулгац, үр, үрсэлгээний үзэсгэлэн худалдаа”-г Барилгачдын талбайд зохион байгуулж, мод сөөгний суулгац, үр үрсэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 14 аж ахуйн нэгж байгууллага, 17 иргэнийг оролцуулж 26 гаруй нэр төрлийн мод, суулгац, 100 гаруй нэр төрлийн нарийн ногооны үр, үрсэлгээ, таримал цэцгийн худалдаа явагдаж нийт 255.5 сая төгрөгийн худалдаа хийсэн. “Адра-Монгол” олон улсын байгууллагатай хамтран “Өрхийн тогтвортой тариалан төсөл”-ийн хүрээнд дүүргийн 14, 17, 18, 19 дүгээр хорооны төсөлд хамрагддаг 220 өрхийн “Эко хүнсний ногоо” нээлттэй өдөрлөгийг Барилгачдын талбайд зохион байгуулж, иргэдэд амталгаат худалдаа, газар тариалангийн чиглэлээр заавар, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан. Нээлттэй | 90 |

| | | | | | | | |
|----|---|--|----------------------------------|------|---|---|----|
| | | | | | | өдөрлөгийн үеэр нийт 1100 иргэн хамрагдсан. Иргэдийг шинэ ургацын төмс, хүнсний ногоогоор хангах, тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор “Алтан намар” үзэсгэлэн худалдааг 4 дүгээр хороо Барилгачдын талбайд зохион байгуулж, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн тариалан эрхлэгчдийг оролцуулж байна. | |
| 65 | 2.4.4 Ахуй үйлчилгээний төвлөрсөн бичил төв байгуулах иргэд, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, санал санаачилгыг дэмжинэ. | 1. Гэр хороололд халуун усны газрын тоог нэмэгдүүлэх, нөхцөл хүртээмжийг сайжруулах, хөнгөлөлттэй зээл тусламжид хамрагдахад дэмжлэг үзүүлэн ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | Дүүргийн ОНХС-гийн 100.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 10 дугаар хороонд баригдсан “Ахуйн үйлчилгээний бичил төв”-ийн ажлын байранд ахуйн үйлчилгээний чиглэлээр үйлчилгээ үзүүлэх, ажлын байртай болох хүсэлт гаргасан иргэдийн өргөдлийг шийдвэрлэн, 9 ажлын байрыг 7 иргэнд хүлээлгэн өгч, цахилгааны асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. “Гүүд нейборс” ОУБ-ын хөрөнгө оруулалтаар “Халуун ус, ахуйн үйлчилгээний төв” байгуулахаар Засаг даргын 2016 оны А/771 дугаар захирамжаар газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. Уг төв нь дүүргийн 19 дүгээр хороо буюу “Шунхлай” ШТС-ын хажууд байгуулахаар шийдвэрлэсэн ба санхүүжүүлэгч талаас ахуйн үйлчилгээний төв болгон хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | 70 |
| 66 | | 2. Жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээг нэвтрүүлж, аялал жуулчлалын компанитай хамтран ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | Жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд Нарантуул, Дипломат, Премиум зочид буудлуудтай хамтран ажиллаж, жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуй нэгж, иргэдээ дэмжин бэлэг дурсгал, гараар урласан бүтээгдэхүүн худалдаалах боломжийг бүрдүүлсэн. “Даншиг наадам-Хүрээ цам 2017” шашин соёлын наадмын үеэр Төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаа үйлчилгээг зохион байгуулж, Жуулчдад зориулж Чингэлтэй дүүргийг сурталчлах, Монгол зан үйл, зан заншил, ахуйн соёлын талаар ойлголт өгөх зорилгоор Айрагны асар-Шагайн наадгайн | 70 |

| | | | | | | | |
|---------------------------------------|--|--|----------------------------------|------|--------------------|--|----|
| | | | | | | асрыг иргэн н.Гүндэгмаатай хамтран гаргаж, жуулчдыг татах зорилгоор “Дэмбээ-наадгай” тэмцээнийг дүүргийн 13 дугаар хорооны иргэн О.Батзаяа санаачлан зохион байгуулж, 15 иргэнийг хамруулсан нь олны анхаарлыг татсан үйл ажиллагаа болсон. Мөн Нийслэлийн Аялал жуулчлалын газраас гаргасан асарт жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч Зөгийн-Үүр ТББ, Чингэлтэйд үйлдвэрлэв салбар дэлгүүр болон 4 иргэний үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. | |
| 67 | | 3. Зочид буудлын үйлчилгээний ажилтнуудад сургалт зохион байгуулах, олон улсын уралдаан тэмцээнд оролцуулах, олон улсын стандартад нийцсэн өндөр зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаатай танилцуулах, харилцан туршлага судлах арга хэмжээг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 3.0 | Эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд Халдварт өвчин судлалын үндэсний төв, Нийслэлийн аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг зочид буудлын удирдах ажилтнуудад БЗДХ, ХДХВ, ДОХ-ын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж 20 гаруй буудлын эзэд болон удирдах албан тушаалтнууд оролцсон. Нийслэлийн аялал жуулчлалын газраас зохион байгуулсан “Зочид буудал, дэн буудал, жуулчны бааз, гэст хаус зэрэг зочлох үйлчилгээний байгууллагуудын стандартыг шинэчлэх хэлэлцүүлэг”-т дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг зочид буудал, дэн буудлын холбогдох ажилтан, албан тушаалтан 11 иргэнийг хамруулсан. Нийслэлийн АЖГ-аас зохион байгуулсан “Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2021 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”, “Шөнийн Улаанбаатар дэд хөтөлбөр”-н төслийг боловсруулах хэлэлцүүлэгт 4 аж ахуйн нэгжийн удирдлагуудыг оролцуулан салбарын хөгжил, дэвшил, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог ханган ажилласан. | 50 |
| 3. ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ-ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ | | | | | | | |
| 3.1 ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА | | | | | | | |

| | | | | | | | |
|----|---|--|----------------------------------|------|--------------------|--|----|
| 68 | 3.1.1 Улс, нийслэл, дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн дүүргийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г жил бүр тодотгон хэрэгжүүлнэ. | 1. Дүүргийн “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан дүүргийн 2017 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт 70 хувьтай байна. Төлөвлөгөөний хүрээнд газрын төлбөрийн орлогод 2017 оны 8 дугаар сарын 20-ны байдлаар 300,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 230,5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүллээ. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах сургууль, цэцэрлэг, эмнэлгийн талбайн байршлыг судалж 11 дүгээр хороонд 240 ортой Хүүхдийн цэцэрлэг барих ажилд шаардагдах 1 нэгж талбарын газрыг 2014 онд нөхөн олговортойгоор чөлөөлсөн. 5 нэгж талбарын газрыг чөлөөлөхөөр хүлээгдэж байна. Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороонд Эрүүл мэндийн төв барих байршилд НЗД-ын 2016 оны А/850 тоот захирамжаар 1000м2 газрыг шийдвэрлэсэн. Оны эхний 8 сарын байдлаар нийтдээ дүүргийн Засаг даргын 41 удаагийн захирамжаар нэр шилжих 508 иргэн, хугацаа сунгах 257 иргэн, талбайн хэмжээ өөрчлөх 68 иргэн, газар баталгаажуулсан захирамжаар 19 иргэний буюу нийт 852 иргэн, аж ахуй нэгж байгууллагын газрын эзэмшлийн асуудлыг шийдвэрлэсэн байна | 70 |
| 69 | | 2. Нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй тавигдсан ТҮЦ, хайс, хашаа зэргийг “Хашаа” нэгдсэн арга хэмжээний хүрээнд шийдвэрлэнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 1.0 | Нийслэлийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 08-ны А/863 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт Нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй тавигдсан ТҮЦ, хайс, хашааг нүүлгэх ажлын хүрээнд 28 ТҮЦ, 33 хайс, хашааны газрыг чөлөөлсөн. | 70 |
| 70 | 3.1.2 Иргэдэд газар | 1. Газар өмчлөлийн | Үйл ажиллагааны | 100% | - | Газар өмчлөлийн LPIS.2.0 программ хангамжийг боловсронгуй болгож, газар | 50 |

| | | | | | | | |
|----|---|---|----------------------------------|------|---|--|----|
| | эзэмшүүлэх, өмчлүүлэх болон газраа эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилгыг дэмжин, газрын харилцаатай холбоотой | талаар нарийвчилсан мэдээлэл бүхий сан үүсгэж, иргэд, олон нийтэд нээлттэй ил тод болгоно. | хэрэгжилт хувиар | | | өмчлөгчийн өгөгдлийн мэдээллийн баазыг өргөтгөж ажиллалаа. Тус мэдээллийн баазад гэр хорооллын нийт иргэдийн 78 хувь буюу 17800 иргэн нь газраа өмчилж авсан бүртгэлтэй байна. www.umc.ub.gov.mn сайтанд цахимаар газар өмчлөх талаар мэдээллийг дэлгэрэнгүй байршуулсан ба хороодын нэг цонхны үйлчилгээгээр иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. | |
| 71 | мэдээллийг нээлттэй ил тод болгоно. | 2. Иргэн бүрийг өмчтэй болгох бодлогын хүрээнд хашааны газар өмчлөл, зуслангийн газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 101, 187 дугаар тогтоолоор батлагдсан хаягжилт, ерөнхий төлөвлөгөөний зургийн дагуу зуслангийн амуудад газар эзэмшиж буй иргэдэд газрыг өмчлүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 8 удаагийн захирамжаар 298 иргэнд 15,1 га газрыг нэг удаа үнэгүйгээр өмчлүүлсэн. Үүнээс хашааны газраа өмчилсөн 156, зусланд газраа өмчилсөн 142 иргэн байна. Хамтран өмчлөгчөө хасуулах болон Кадастрын зурагт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан 108 нэгж талбарт хамаарах 275 иргэний материалыг “Газар өмчлөлийн шийдвэрийн төслийг бэлтгэх” ажлын хэсгийн хуралдаанд танилцуулан нийслэлийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн. Эдгээр иргэд цахимаар болон орон нутагтаа газар өмчилж авах эрх нь нээлттэй болсон. | 70 |
| 72 | 3.1.3 Дүүргийн нутаг дэвсгэрт тохилог орон сууц, амины орон сууц барих төсөл хэрэгжүүлэгчдийг дэмжин ажиллаж, дэд бүтэц, инженерийн | 1. “Нэг өрх-нэг орон сууц” загвар төслийг хэрэгжүүлэгч мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 10% | Гадаадын зээл тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | Дүүргийн 19 дүгээр хороо Салхитын аманд газар дахин шинэчилэн сайжруулах тохилог, инженерийн дэд бүтэцтэй амины орон сууцны хороолол бий болгох үүднээс “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт тусгасны дагуу газар шинэчлэн зохион байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний эскиз зураг, инженерийн дэд бүтцийн хангамжийн ажлын зураг төсөл | 50 |

| | | | | | | | |
|----|---|---|----------------------------------|------|------------------------|---|----|
| | шугам сүлжээнд холбогдсон тохилог сууцнуудыг бий болгоно. | | | | | боловсруулах ажлын даалгавар боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Мөн төслийн хүрээнд Тусгаар тогтнолын талбайд “Изо Хаус” ХХК-тай хамтран Канад модон хийцтэй угсармал зөөврийн амины орон сууцны үзэсгэлэн гаргаж тайлант хугацаанд 1200 гаруй иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Дүүргийн тодорхой хэсгүүдэд хэсэгчилсэн инженерийн хангамж бүхий Дэд бүтцийн төв буюу “Сервис центр”-ийг барьж байгуулахаар төлөвлөсөн бөгөөд “Сервис центр”-ийн үйл ажиллагааг танилцуулах уулзалтыг 7, 13, 14, 15, 16, 17, 18, 19 дүгээр хорооны иргэдэд зохион байгууллаа. | |
| 73 | 3.1.4 Олон жил болсон орон сууцны байрнуудын дулаан алдагдлыг бууруулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ. | 1. Нэн шаардлагатай орон сууцны байрнуудын дээвэр засварын ажлыг хийж гүйцэтгэнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Нийслэлийн төсөв 200.0 | Нийслэлийн 2017 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 44,6 сая төгрөгийн хөрөнгөөр 5 дугаар хорооны 17 дугаар байрны дээврийн засварын ажлыг “Болор эм би” ХХК, 54,4 сая төгрөгийн хөрөнгөөр 6-р хорооны 62/1, 53 дугаар байруудын дээврийн засварын ажлыг “ЭЭБТ” ХХК тус тус хийж гүйцэтгэж байна. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 6-р хорооны 45-р байрны фасад засварын ажлын гүйцэтгэгчээр “Төгс үлэмж чанар” ХХК шалгаран гэрээ байгуулагдан зураг төсвийн ажил хийгдэж байна. Мөн дүүргийн 2017 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1-р хорооны ТЕГ-50 дугаар байрны фасад засварын ажлыг “Энэрэлт их эрдэнэ” ХХК 49,8 сая төгрөгөөр, 2-р хорооны 23-р байрны дээвэр засварын ажлыг “Хоовжий” ХХК 68,8 сая төгрөгөөр, 3-р хорооны 40-0-тын 13 дугаар байрны фасад засварын ажлыг “Их галдайн оргил” ХХК 48,9 сая төгрөгөөр, 4-р хорооны 39-р байрны фасад засварын ажлыг “Зэндмэнэ тулга” ХХК 49.9 сая төгрөгөөр, 5-р хорооны 12 дугаар байрны фасад засварын ажлыг “Мөнхтэнцвэрт өргөө” ХХК 49,9 сая төгрөгөөр, 6-р хорооны 58 дугаар байрны дээвэр засварын ажлыг “Тэгш өргөө” ХХК 45,8 сая төгрөгөөр тус тус хийж | 70 |

| | | | | | | | |
|----|---|--|---------------------------------|------|---------------------------------------|---|----|
| | | | | | | гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. | |
| 74 | 3.1.5 Нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, орон сууц гэр хорооллын гэрэлтүүлэг, камержуулалтыг шинээр нэмэгдүүлж, нэгдсэн удирдлага-хяналтын системд холбоно. | 1. Гэр хороод болон нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлж, сайжруулна. | Тавигдсан гэрэлтүүлгийн тоогоор | 100% | Нийслэл, дүүргийн төсөв, гүйцэтгэлээр | Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “И Пи Эс” ХХК 7, 8, 10, 12 дугаар хороонд, “Согриглүн” ХХК 15, 17, 19 дүгээр хороонд, “Филипс гэрэлтүүлэг” ХХК 13, 14, 16 дугаар хороодод нийт 218,3 сая төгрөгийн төсөв өртөг бүхий 133 ширхэг гэрэлтүүлэг тавьсан. Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр хийгдэж буй авто зам дагуу Чингэлтэй дүүргийн гэрэлтүүлгийн ашиглагч “Соёндрийм” ХХК шинээр гэрэлтүүлэг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 11, 12 дугаар хороо, Самбалхүндэвийн эргэмжийн газраас Дэнжийн мянган авто замтай нийлэх авто зам дагуу 19 ширхэг гэрэлтүүлэг, 7, 10 дугаар хорооны авто зам дагуу 33 ширхэг гэрэлтүүлэг, 11 дүгээр хорооны байрлуу явсан авто зам дагуу 15 ширхэг гэрэлтүүлэг, 17 дугаар хорооны байрлуу явсан авто зам дагуу 7 ширхэг гэрэлтүүлэг, 19 дүгээр хорооны байрлуу явсан авто зам дагуу 8 ширхэг гэрэлтүүлэг тус тус хийж гүйцэтгэж нийт 82 ширхэг гэрэлтүүлэг 114,8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. | 90 |

3.2 ХОТ ТОХИЖИЛТ, ДЭД БҮТЭЦ

| | | | | | | | |
|----|--|--|--------------------|------|------------------|---|----|
| 75 | 3.2.1 Зам, замын байгууламжийн оновчтой төлөвлөлтийг хэрэгжүүлж, асфальт, бетонон болон байгалийн чулуун замуудаар гэр хорооллын гол гудамжуудыг төв замтай холбож, олон чиглэлийн зам харилцааг | 1.Орон сууцны хороолол дундах авто замын шинэчлэл, засварын ажлыг үргэлжлүүлэн хийнэ | Авто замын урт, км | 100% | Нийслэлийн төсөв | Дүүргийн хөрөнгө оруулалтаар Жуулчны гудамж "Урт цагаан"-ны үйлчилгээний төвийн өмнө 3158м2 талбайн авто зогсоолыг шинэчлэх ажил хийгдэж нийт 130 авто машин зогсох хүчин чадалтай даацын эко хавтан, явган хавтан бүхий 4 ширхэг орц гарцтай авто зогсоолыг дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК хийж гүйцэтгэсэн. Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр хийгдэж буй 4 дүгээр хороо “Хийморь” цогцолбор байрны зүүн талын тохижилтын ажилтай уялдуулан “МАКС ГРУПП” ХХК авто замыг өргөсгөх, бордюр шинээр солих, замын хөдөлгөөн тусгаарлах зурвас хийж иргэдийн чөлөөтэй зорчих ая тухтай | 70 |
|----|--|--|--------------------|------|------------------|---|----|

| | | | | | | | |
|----|---|--|------|-------------------------|---|---|--|
| | хөгжүүлнэ. | | | | | байдлыг хангаж ажилласан. Нийслэлийн авто замын сангийн хөрөнгөөр 2 дугаар хороо, Бэтүб хийд орчмын байгалийн чулуун замыг “Хайдро проект” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 50 хувьтай байна. Самбуугийн гудамж, 19/3 дугаар байрны баруун талын замыг хойш нь холбож чулуун зам барих, Лааганы гудамжийг орон сууцны хорооллын замтай холбох, 3 дугаар хороо Барилгын коллежийн байр болон 23 дугаар байрны араар чулуун зам барих ажлууд тендерийн маргааны улмаас хойшилсон. Мөн нийслэлийн төсвийн 50,0 сая төгрөгийн хөрөнгөөр авто замын нөхөөс 1-6 дугаар хороонд 1000м2 талбайд тавих ажлыг Улаанбаатар Зам засвар арчлалтын газар хийж гүйцэтгэсэн. | |
| 76 | 2. Гэр хорооллын гол гудамжуудыг байгалийн чулуун, бетонон болон асфальтан авто замуудаар холбох, гол замаас сургууль, цэцэрлэг, хороод руу салсан замын ажлын зураг төслийг боловсруулж, ажлыг эхлүүлнэ. | Зураг төсөв боловсруулах ажлын явц, хувиар | 100% | Нийслэл, дүүргийн төсөв | Дүүргийн хэмжээнд 2017 онд 6,1 тэрбум төгрөгөөр 11 байршилд 7,8 км авто зам хийгдэж байна. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2016 оны концессийн гэрээгээр хийгдэж эхэлсэн ажлын үргэлжлэл 16 хороо Баянхошууны хөтөл “Ринг роуд” ХХК, 19 дүгээр хороо Яргайтын богино “ХАКМС” ХХК тус тус хийж гүйцэтгэж байна. Нийслэлийн 2017 оны төсвийн хөрөнгөөр 12, 16 дугаар хороо Дэнжийн мянган авто замын үргэлжлэл 0,9 км замыг “Билэгт зам” ХХК хийж гүйцэтгэж байна. Дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр 11, 12 дугаар хороо, Самбалхүндэвийн эргэмжийн газраас Дэнжийн мянган авто замтай нийлэх 0,52 км авто замын ажил хийгдсэн бөгөөд 7, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт Хувьсгалчдын замаас Дэнжийн мянган цагаан байрны хойд талын зам буюу “Ундрам” дэлгүүрийн авто замтай нийлэх 1,2 км авто замын ажил хийгдсэн. Мөн 9, 11, 17, 19 дүгээр хорооны байр луу явсан нийт 0,8 км авто замын ажил эхэлсэн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 7 дугаар хороо, Эрх зүйн туслалцааны төвөөс Самбалхүндэвийн | 70 | |

| | | | | | | | |
|----|---|--|----------------------------------|------|-----------------------------|--|----|
| | | | | | | эргэмжийн газрын авто замтай нийлэх 0,39 км авто замын ажлыг “Өргөн говь” ХХК хийж гүйцэтгэсэн. | |
| 77 | 3.2.2 Сэлбэ дэд төвийн төслийг үргэлжлүүлэн хийж дуусгахад хамтран ажиллана. | 1. Сэлбэ дэд төвийн дэд бүтцийг байгуулах ажлын хүрээнд Хайлаастаас 7 буудал хүртэлх бохир усны гол шугамын ажлыг үргэлжлүүлэн хийж дуусгахад хамтран ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Улсын төсөв 600.0 | Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банкны хамтарсан 1 тэрбум төгрөгний санхүүжилтээр хэрэгжиж буй гэр хорооллын хөгжлийг дэмжих ажлын хүрээнд "Сэлбэ дэд төв" 2.2 км урттай, DN400 мм-ийн DI бохир усны коллектор шугамын барилгын ажил 7 буудлаас Хайлаастын замын уулзвар хүртэл 14, 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт төв замын баруун талаар хийгдэж байна. Тус ажлын хүрээнд бохир усны гол шугамын ажил явагдаж байгаа бөгөөд гүйцэтгэгчээр “Хүрд ХХК ажиллаж дууссан ба авто болон явган замын нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэгчээр “Зэст Хөлөг” ХХК ажиллаж ажлын явц 50 хувьтай байна. Тус ажлын хүрээнд бохир усны шугамын трассд 28 нэгж талбар өртөж газар чөлөөлөх ажил бүрэн хийгдэж дууссан. | 70 |
| 78 | 3.2.3 Хүчдэлийн уналттай болон гэрэл цахилгаангүй бүх өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг үе шаттай хийнэ. | 1. Айл өрхийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангах, хүчдэлийг сайжруулах, дэд станц, шугамын өргөтгөл шинэчлэлийг үе шаттай хийхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 50% | Улс, нийслэлийн төсөв 500.0 | Дүүргийн хэмжээнд гэр хорооллын 19 байршилд 9 хорооны нутаг дэвсгэрийг хамарсан 702 өрх буюу 3510 орчим хүн ам хүчдэлийн уналттай хэсгийн судалгаанд хамрагдсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Би Эн Жи Эл” ХХК нь 19-р хороо АТП 827 дэд өртөөний өргөтгөл 69 өрх, 18-р хороо яргайтын гудамж АТП, 7-р хороо КТПн ачаалал хөнгөлөх ажил, “Дархан Ферагон” ХХК нь 16-р хороо Согоотын 83-р гудамж 51 өрх, 17-р хороо Сурагчийн 6, 7-р гудамж, Зүрх уулын орчим 42 өрх, Тахилтын 3 гудамж 42 өрх “Хүрд” ХХК нь 16-р хороо Согоотын 2, 59а гудамж 87 өрх, 19-р хороо Өвөр гүнтийн орчим 78 өрхийн цахилгаан сайжруулах ажлуудыг хийж дуусган улсын комисст хүлээлгэн өгсөн. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 18 дугаар хорооны зарим байршилд “Сүлжээний урсгал” ХХК 25,7 сая | 90 |

| | | | | | | | |
|----|--|---|---|-----|-----------------------------|---|-----|
| | | | | | | <p>төгрөгний санхүүжилтээр 21 тоолуур бүхий 12 тулгуур, 700 метр шугамын ажил гүйцэтгэж дууссан. Мөн 16-р хороо Согоотын 90, 86-р гудамжны айл өрхөд цахилгааны шугам татах /45 өрх/ ажлыг “Энержи комплекс” ХХК, 19-р хороо Ар согоотын гудамжны айл өрхөд цахилгааны шугам татах /70 өрх/ ажлыг “Ачит эрчим” ХХК гэрээ байгуулан эхлүүлээд байна. Нийт 5 хорооны 369 айл өрхийн хүчдлийг нэмэгдүүлээд байна. Дүүргийн нутаг дэвсгэрт тулгамдаж буй эрчим хүчний талаар болон Засгийн газраас нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд эрчим хүчний шөнийн тарифыг 100 хувь хөнгөлөх ажлыг дэмжин хэрэгжүүлж буй “Монватт” ХХК-ны монгол гэрт дулаан хуримтлуулах “эко тулгат” халаалтын төхөөрөмжийг танилцуулах ажлыг “Монватт” ХХК-тай хамтран 7-18 дугаар хороодын Засаг дарга, ажлын албаны дарга, хэсгийн ахлагч нарын дунд зохион байгуулсан.</p> | |
| 79 | <p>3.2.4 Гэр хороодын гуу жалга бүхий газруудад явган шат, гүүр, ус түгээх байр барьж, иргэдийн амьдрах орчныг сайжруулна.</p> | <p>1. Гэр хороодын гуу жалгатай газруудад явган шат, гүүр барих ажлын зураг төслийг боловсруулан иргэдийн бүлгийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.</p> | <p>Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар</p> | 50% | <p>Дүүргийн төсөв 120.0</p> | <p>Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр иргэдийн бүлгийн оролцоотой хийгдэх явган зам, тохижилтын ажлын хүрээнд 9 дүгээр хорооны Цагаан байрны автобусны буудал орчмын тохижилтын ажлыг “Дэнж” иргэдийн бүлэг 14,9 сая төгрөгөөр, 15-р хороо 84-ийн автобусны буудлаас Чингэлтэй өгсдөг авто гүүрэнд хашлага хийж тохижуулах ажлыг “Хөгжил” иргэдийн бүлэг 5,1 сая төгрөгөөр, 18 дугаар хороо Яргайтын 19, 22 дугаар гудамжны заагт явган хүний зам тавих ажлыг “Цоглог” иргэдийн бүлэг 7,9 сая төгрөгөөр, 7 дугаар хорооны хаягжуулалтыг “Эв нэгдэл” иргэдийн бүлэг 14,4 сая төгрөгөөр, 8 дугаар хорооны хаягжуулалтыг “Найрамдал” иргэдийн бүлэг, 18 дугаар хорооны хаягжуулалтыг “Хүчилтөрөгч” иргэдийн бүлэг 11,8 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн.</p> | 100 |

| | | | | | | | |
|----|---|--|----------------------------------|------|------------------------|---|----|
| 80 | | 2. Хүн амыг баталгаат ундны усаар хангах, ус түгээх байруудын баталгаат нөхцөл байдалд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалт хийж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Нийслэлийн төсөв 160.0 | Хүн амыг баталгаат ундны усаар хангах, ус түгээх байруудын баталгаат нөхцөл байдлыг хангах ухаалаг төхөөрөмжийг дүүргийн хэмжээнд нэвтрүүлэх ажлыг Ус сувгийн удирдах газар, Зөөврийн ус хангамжийн албатай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Уг ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгөөр 19 дүгээр хороо Доод салхитад зөөврийн ус түгээх байр, 18 дугаар хороо яргайтын 83-р гудамжинд гүний худаг, 17 дугаар хороо Олон булагтай цэцэрлэгт хүрээлэнгийн орчимд шугамын ус түгээх байр, Зүрх уулын 3 дугаар гудамжинд гүний худаг, 16 дугаар хороо Согоотын 90-р гудамжинд гүний худагны 5 байршилд түлхүүр гардуулах нөхцөлтэй тендер зарлагдсан. Мөн нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 16-р хороо Шинэ эцсийн буудлын хажууд Зөөврийн ус түгээх байр, 12-р хороо Булгийн 19-р гудамж Зөөврийн ус түгээх байрууд баригдахаар тендер зарлагдсан. | 50 |
| 81 | 3.2.5 Иргэдийн эрэлтэд нийцсэн нийтийн тээврийн шинэ чиглэл бий болгох ажлыг дэмжин хамтран ажиллана. | 1. Алслагдсан гэр хороодын нийтийн тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх, чиглэл маршрутыг уртасгах ажлыг иргэдийн санал, хүсэлтэд тулгуурлан холбогдох байгууллагад уламжлан, хамтран ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 50% | - | Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд дүүргийн зүгээс 7 дугаар хороо, Хувьсгалчдын гудамж Зурагтын шинэ эцсийн буудлаас хуучин эцсийн буудал хүртэл хотын төв рүү орох Баянгол дүүрэг талдаа шинээр автобусны дундын зогсоол нэмэх, 11 дүгээр хороо, Дэнжийн 1000 гудамж Хүчит шонхор захын зүүн талын автобусны дундын зогсоолын хэмжээ нэмэх тусгаарлах хашлага хийх, 13 дугаар хороо, Чингэлтэйн өргөн чөлөө 56 дугаар цэцэрлэгийн автобусны дундын зогсоолыг шилжүүлэх, 14 дүгээр хороо, Чингэлтэйн өргөн чөлөө 6 буудлын автобусны дундын зогсоолыг шилжүүлэх 4 байршилд санал гарган хүргүүлсэн. Мөн Тээврийн газарт дүүргийн хэмжээнд төв замаас алслагдсан нийтийн тээврийн чиглэлийн хүртээмж муу талаар 7, 10 | 70 |

| | | | | | | | |
|--|--|--|--|--|--|---|--|
| | | | | | | дугаар хороодын иргэдээс ирсэн санал хүсэлтийн дагуу тус хороодын нутаг дэвсгэрийг хамарсан “Алтан дорнын хүч” ХХК-ны боловсруулсан нийтийн тээврийн чиглэл нэмэгдүүлэх төслийг хүргүүлэн ажилласан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 18 дугаар хороо Сургуулийн буудлаас хотын төвийн чиглэлд "АВТОБУСНЫ БУУДЛЫН САРАВЧ" барьж ашиглалтанд оруулсан. Зуны хуваарь 6 дугаар сарын 10-наас шөнийн тээврийн ШҮ:1 "5 шар-Ботаник", ШҮ:2 "Нисэх-МУБИС-Ард", ШҮ:3 "Зунжин-7 буудал-МУБИС" чиглэлд нийтийн тээврийн автобус үйлчилнэ. Тус чиглэлд 22:30 цагаас 01:30 цаг хүртэл явж байна. Мөн зуслангийн чиглэлийн зорчих эрэлтэд үндэслэн ЗҮ:1 "Гүнт-Жигжид-Тэнгис кино театр" чиглэлд 3 тээврийн хэрэгсэл, ЗҮ:2 "Гоодой-Тэнгис кино театр" чиглэлд 1 тээврийн хэрэгсэл, ЗҮ:3 "Баянбулаг-Тэнгис кино театр" чиглэлд 1 тээврийн хэрэгсэл тус тус үйлчилгээнд явж эхлээд байна. | |
|--|--|--|--|--|--|---|--|

4. ЖАРГАЛТАЙ ОРЧИН-НОГООН ХӨГЖИЛ

4.1 БАЙГАЛЬ ОРЧИН

| | | | | | | | |
|----|--|--|--|------|-------------------------------|--|----|
| 82 | 4.1.1 Ногоон хөгжлийг дэмжих замаар “Ногоон дүүрэг” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ. | 1. Агаар, хөрсний тоосжилтыг бууруулах зорилгоор гудамж талбайг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгоно. | Зүлэгжүүлж, хатуу хучилттай болгосон талбай м2-аар | 100% | Нийслэл, дүүргийн төсөв 460.0 | Агаар, хөрсний тоосжилтыг бууруулах зорилгоор гудамж талбайг зүлэгжүүлж, хатуу хучилттай болгох ажлын хүрээнд 34580м2 асфальтан хучилт, 2, 3, 4, 6, 10, 12 дугаар хороодод дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр 2956м2 эко хавтан, 1750м2 явган зам тус тус хийж гүйцэтгэсэн бөгөөд нийт 39286м2 талбайг хатуу хучилттай болгосон. Дүүргийн нийтийн эзэмшлийн талбайд шинээр 2400 м2, орон сууцны хороолол дунд 4500м2, бичил цэцэрлэгүүдэд 1800м2, нийт 8700 м2 талбайд зүлэгжүүлэлтийн ажил хийгдсэн. Нийтийн эзэмшлийн талбайд 43 м2, орон сууцны хорооллын дунд 18 м2, бичил цэцэрлэгүүдэд 11.5м2, нийт 72.5 м2 талбайд | 70 |
|----|--|--|--|------|-------------------------------|--|----|

| | | | | | | | |
|----|--|---|------------------------------|------|------------------------------|---|----|
| | | | | | | цэцгийн мандал байгуулсан. “Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд нийт 2278 иргэн, 98 аж ахуйн нэгж оролцож, дүүргийн ЗДТГ-ын хэлтэс, албад, хороод орчин тойрон, бичил цэцэрлэг, сад, цэцэрлэгт хүрээлэнд 3437 ширхэг мод, айл, өрхийн хашаандаа 1054 ширхэг мод, 2150м2 талбайд зүлэгжүүлэлт, 4388 ширхэг бут сөөг тарьсан. | |
| 83 | | 2.Нийтийн эзэмшлийн гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэнд орчин үеийн шийдэлтэй мод бут ургуулж, арчлах, хэлбэржүүлэх ажлуудыг үргэлжлүүлнэ. | Таригдсан мод, бутны тоогоор | 100% | Нийслэл, дүүргий төсөв 120.0 | Тайлант хугацаанд дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбай ногоон байгууламжийн арчилгааны ажлын хүрээнд 7 байршилд 34861 м2 талбайд цэнэг усалгаа, 250 ширхэг мод, бутны хэлбэржүүлэлт, арчилгааны ажлыг Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК хийж гүйцэтгэсэн. Ж.Самбуугийн нэрэмжит гудамжинд 1186660 м2 зүлэгт талбайн цэвэрлэгээ, 61840 м2 зүлэг тайрч тэгшлэх, 179440 м2 зүлэг савардаж цэвэрлэх, 1193500 м2 талбайд усалгаа, 25 ш модны шуудуу ухах, 68 ш мод сөөгний тогоо гаргах ажилбар, 136 ш мод шохойдох, 37.5м3 мод сөөгний нүх ухах, 20 ш мод тарих, 2 эгнээгээр 10020 ш сөөг тарих болон 170 ш сөөг тарих, 1600 у/м хайс будах, 30 м2 талбайд цэцгийн мандал суулгаж 7000 ш цэцэг тарих, 14 ш цэцгийн саванд 1000 ш цэцэг тарих, шинээр 4867 м2 зүлэг тарих, 6540 м2 ургамлан хашлага тайрч тэгшлэх, 140 ш сөөг тайрч хэлбэржүүлэх, 750м2 цэцгийн мандал услах, 270 м2 /хөл газрын ургамал /зэрлэг/ зулгааж, 194 м3 ахуйн хог болон чулуу, шороо, зэрлэг ургамал ачих ажлууд болон өдөр тутмын усалгаа арчилгааг хийж гүйцэтгэсэн. Анкарагийн нэрэмжит гудамжинд 601000м2 зүлэгт талбайн цэвэрлэгээ, 28 ш мод шохойдох, 21 ш модны тогоо гаргах ажилбар, 15м3 сөөгний нүх ухах, 15 ш сөөг тарих, 21600 м2 зүлэг тайрч тэгшлэх, зүлэг тайрч тэгшлэх, 102000 м2 савардаж цэвэрлэх, 7356 м2 ургамлан хашлага сөөг | 90 |

| | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|
| | | | | | <p>тайрах, 24 ш сөөг тайрч хэлбэрт оруулах, 26 м2 талбайд цэцгийн мандал суулгаж 3000 ш цэцэг тарих, 287 м2 талбайн зүлэг нөхөн тарих, 566000 м2 талбайд усалгаа хийх, 650 м2 цэцгийн мандал услах, 221 м2 /хөл газрын ургамал /зэрлэг/ зулгааж, 1578 у/м хайс будах, 120.5 м3 ахуйн хог болон чулуу, шороо, зэрлэг ургамал ачих ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн. Мөн бордоот болон өдөр тутмын усалгаа бүрэн хийгдсэн. Явуухулангийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнд 278057 м2 зүлэгт талбайн цэвэрлэгээ, 87 ш модны шуулт хийх, 10м3 сөөгний нүх ухах, 10 ш сөөг тарих, 8400 м2 талбайн зүлэг тайралт, 18 ш цэцгийн саванд 2500 ш цэцэг тарих, 197525 м2 талбайд усалгаа, 26017 м2 талбайн зүлэг самналт, 1200 м2 ургамлан хашлага тайрч тэгшлэх, 9 м2 цэцгийн мандал услах, 85 м2 /хөл газрын ургамал /зэрлэг/ зулгааж, 58.5 м3 ахуйн хог болон чулуу, шороо зэрлэг ачих ажлууд болон өдөр тутмын усалгаа, арчилгаа бүрэн хийгдсэн. Жуулчны гудамжинд 452380 м2 зүлэгт талбайн цэвэрлэгээ, 30 ш мод сөөгний тогоо гаргах, 3 ш мод хэлбэржүүлэх, 3300 ш шар хуайс, 52000 м2 талбайн зүлэг самналт, 19350 м2 талбайн зүлэг тайрч тэгшлэх, 45 м2 талбайн сөөг тайрч тэгшлэх, 1842 м2 талбайн зүлэг нөхөн тарих, 77 ш сөөг тайрч тэгшлэх, 770 м2 /хөл газрын ургамал /зэрлэг/ зулгааж, 86 м3 ахуйн хог болон чулуу, шороо, зэрлэг ургамал ачих, 335200 м2 талбайд өдөр тутмын усалгаа, цэвэрлэгээг хийж гүйцэтгэлээ. Бага тойруугийн гудамжинд 363100 м2 зүлэгт талбайн цэвэрлэгээ, 20248 м2 зүлэг тайрч тэгшлэх, 70868 м2 талбайн зүлэг самналт, 2904 м2 ургамлан хашлага тайрч тэгшлэх, 322480 м2 талбайд усалгаа, 972 м2 /хөл газрын ургамал /зэрлэг/ зулгааж, 70 м3 ахуйн хог болон чулуу,</p> | |
|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | | |
|----|-----------------------|---|----------------------------------|------|---------------------|---|----|
| | | | | | | шороо, зэрлэг ургамал ачих ажлууд болон өдөр тутмын усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна. Мөн Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК нь орон сууцын дундах болон гэр хорооллын дундах 44 бичил цэцэрлэгийн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтыг хариуцан ажиллаж байгаа бөгөөд 453335 м2 зүлэгт талбайн цэвэрлэгээ, 325210м2 усалгаа, 17215м2 зүлэг тайрж хэлбэржүүлж, 5613м2 /хөл газрын ургамал /зэрлэг/ зулгааж, 230м2 хольцоор хучилт хийж, 230 м2 зүлэгний үр цацаж ажилласан. Чингэлтэй дүүргийн хэмжээнд хөгширсөн ургалтгүй 32 ш мод байна. Үүнээс Анкарагийн гудамжны хөгширсөн ургалтгүй 12 ш модыг чөлөөлсөн. Анкарагийн гудамжны 5 дугаар сургуулийн урд талын 3 ш модон дээр “Тохижилт үйлчилгээ” ХХК сийлбэр хийх ажлын гэрээг байгуулан ажиллаж байна. | |
| 84 | | 3. Байгаль хамгаалах, ногоон байгууламж нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт, сурталчилгаа явуулж, урамшуулах тогтолцоог бий болгоно. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 20.0 | Байгаль орчин аялал жуулчлалын яамтай хамтран байгаль хамгаалах, ногоон байгууламж нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад сургалт зохион байгуулж 40 гаруй иргэдийг хамруулан, оролцсон иргэдэд жимсний суулгац гардуулж өгсөн. Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 1-19 дүгээр хорооны 91 иргэдэд “Ногоон байгууламжид таригдсан мод сөөгний усалгаа, арчилгаа” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтын үеэр 3 төрлийн 270 гаруй мод, суулгац иргэдэд тараасан. Чингэлтэй дүүргийн 25 жилийн ойн бүтээлч ажлын хүрээнд “Чингэлтэй дүүрэг орчмын байгалийн ургамалыг нөхөн сэргээх арга өнгөт зургийн цомог” бүтээх ажлыг зохион байгуулж, нийт 500 ш ном хэвлүүлсэн ба хороодын иргэний танхимаар тараахаар ажиллаж байна. | 90 |
| 85 | 4.1.2 Аялал жуулчлал, | 1. Чингэлтэй хайрхан руу | Зураг төсөв гарган | 100% | Дүүргийн төсөв 90.0 | Чингэлтэй хайрхан руу чиглэсэн аялалын маршрут гарган өвөл зуны туршид амрах, үдлэх | 90 |

| | | | | | | | |
|---|--|--|---|------|---|--|----|
| | амралт зугаалга, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах спортын задгай талбай бүхий Олимп хотхоныг байгуулна. | чиглэсэн аялалын маршрут гарган өвөл зуны туршид амрах, үдлэх тохижсон цэгүүдийг бий болгон иргэд, жуулчлалд зориулсан бүсийг үе шаттай байгуулна. | маршрутын цэгүүдийг тогтоон баталгаажуулна. | | | тохижсон цэгүүдийг бий болгон иргэд, жуулчлалд зориулсан бүсийг байгуулах ажлын хүрээнд Нийслэлийн төсвийн 40 сая төгрөгөөр 100 ширхэг мод, 33 ширхэг дрожер, 26-ийн диаметртэй зогсоол, 225 у/м байгалийн чулуун зам, 460 м2 явган зам, 47 ш гэрэлтүүлэг, усалгааны систем суурилуулсан. | |
| 86 | | 2. Аялал жуулчлал, амралт зугаалга, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах спортын задгай талбай бүхий Олимп хотхоны ажлыг эхлүүлнэ. | Зураг төсөв боловсруулах ажлын явц, хувиар | 100% | Дүүргийн төсөв 300.0 | Аялал жуулчлал, амралт зугаалга, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах спортын задгай талбай бүхий Олимп хотхоны ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд Санзайн гудамжнаас Олимп цогцолбор хүртэлх авто замын ажлын зураг төсвийг “Жи Ар Си” ХХК хийж гүйцэтгэж, магадлал хийгдэж байна. | 90 |
| 87 | 4.1.3 Ногоон байгууламж, тохижилт бүхий “Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн” байгуулна. | 1. Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлуудыг үргэлжлүүлэн хийнэ. | Таригдсан мод, нөхөн сэргээлтийн хувиар | 50% | Дүүргийн төсөв 90.0 | Чингэлтэй хайрхан Эрдмийн цэцэрлэгт хүрээлэнд 197 ширхэг шилмүүст мод шилжүүлэн суулгаж, 108 ширхэг нарс, 1250 ширхэг шинэс, 78 ширхэг гацуур мод, 96 ширхэг бургас, 25 ширхэг улиас, 10 ширхэг голт бор, 20 ширхэг гүйлс, нийт 1204 ширхэг мод, бут сөөг шинээр тарьж, 690 м2 талбайд зүлэгжүүлэлт хийсэн. | 70 |
| 4.2 ХОГ ХАЯГДАЛ, АГААР, ХӨРСНИЙ БОХИРДОЛ | | | | | | | |
| 88 | 4.2.1 Хог хаягдлын менежментийг сайжруулж, тээвэрлэх, ангилах, боловсруулах, | 1.Олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтран хог хаягдлын менежментийг боловсронгуй | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 50% | Нийслэл, дүүргийн төсөв, ОУБ-ын дэмжлэг | Тохижилт, хог хаягдлын чиглэлээр хөндлөнгийн хяналтын үүрэг гүйцэтгэж буй Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны гэрээт “Шинэ тосгон”, “Урагш дэвших холбоо” төрийн бус байгууллагууд дүүргийн нутаг дэвсгэрт тогтмол хяналт тавин чиг үүргийн дагуу мэдээлэл өгч арга хэмжээ авч ажиллаж байна. “Тохижилт | 90 |

| | | | | | | | |
|----|--|---|----------------------------------|------|---|--|----|
| | худалдан авах цогц менежментийг үе шаттай хэрэгжүүлнэ. | болгох төсөл хэрэгжүүлнэ. | | | | үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК байгууллагууд төвийн болон гэр хорооллын айл, өрх аж ахуйн нэгжүүд хог тээвэрлэлтийн дагуу тогтмол тээвэрлэлт явуулж байна. | |
| 89 | | 2. Хог хаягдлын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, чанарт хяналт тавьж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | - | Хог хаягдлын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, чанарт хяналт тавих ажлын хүрээнд хороо тус бүрийн хог тээвэрлэлт, зам талбайн цэвэрлэгээ, аж ахуйн нэгж байгууллагуудын тохижилт, цэвэрлэгээний үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн 1-19 дүгээр хорооны айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлыг цуглуулж тээвэрлэхэд “Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК 40 орчим техник, машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлээр ханган тогтмол ачиж тээвэрлэн 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт 1120 рейс буюу 7799,4тонн хог хаягдлыг устгалд оруулан төвлөрсөн хогийн цэгт хүргүүлсэн. | 70 |
| 90 | | 3. Гэр хорооллын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилт, цэвэрлэгээний ажилд иргэдийн бүлгийг татан оролцуулж, тэдний үйл ажиллагааг тогтмолжуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө 110.0 | Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-ууд 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс иргэдийн бүлгийг ажиллуулаад байна. Тайлант хугацаанд “Тохижилт үйлчилгээ” ХХК 7-16 дугаар хороо буюу 2 дугаар бүсэд 59 хүний бүрэлдэхүүнтэй 10 бүлэг, “Найши трейд” ХХК 3 дугаар бүс болох 17-19 дүгээр хороонд 12 хүний бүрэлдэхүүнтэй иргэдийн бүлгийг тогтмол ажиллуулж хэвшсэн. Чингэлтэй дүүргийн гэр хорооллын 7-19 хороонд хоёр компанийн нийт иргэдийн бүлгийн 71 хүний бүрэлдэхүүнтэй өдөр тутмын түүвэр цэвэрлэгээг хийж гүйцэтгэж байна. Цэвэрлэгээний явцад 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт 759632 м2 талбайн 621,59 тонн үүсмэл хог хаягдлыг цуглуулан цэвэрлэж | 90 |

| | | | | | | | |
|----|----------------------|--|---|------|-------------------------|--|----|
| | | | | | | <p>ачилт хийн ажиллаж байна. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2017 оны А/04 тоот “Нийслэлийн нутаг дэвсгэрт их цэвэрлэгээ зохион байгуулах тухай” тушаалаар, дүүргийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны А/17 тоот “Нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай” захирамжийн дагуу 8 дугаар сарын 20-ны байдлаар нийт 5 удаагийн давтамжтай их цэвэрлэгээ хийгдээд байна. Дүүргийн Засаг даргын “Хөл газрын ургамал /зэрлэг/-тай тэмцэх аян” зохион байгуулах тухай 2017 оны А/410 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө гарган ажиллаж байна. Аяны хүрээнд дүүргийн хэмжээнд 318090м² хөл газрын ургамал /зэрлэг/-ыг цэвэрлэн, 204.15 тонн хог хаягдлыг тээвэрлэж, давхардсан тоогоор 666 хүн хамруулсан. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан 2 удаагийн “Шарилжгүй Улаанбаатар” аяны хүрээнд Чингэлтэй дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-ийн ажилтнууд болон хороодын иргэдийн бүлэг нийт 80 гаруй хүн ажиллаж 7 байршилд 71400 м2 талбайн хөл газрын ургамал /зэрлэг/ зулгааж ажилласан.</p> | |
| 91 | | 4. Авто болон явган хүний зорчих хэсгийн халтиргаа гулгааг арилгах машин, техникийг нэмэгдүүлж, шинэлэг менежмент хэрэгжүүлнэ. | Шинээр нэмэгдсэн машин, техникийн тоогоор | 50% | Хувийн хэвшлийн хөрөнгө | <p>“Тохижилт үйлчилгээ” ХХК тусгай зориулалтын зам цэвэрлэгээ болон усалгааны 10 тонны камаз маркын 1 машин, “Найши трейд” ХХК хог тээврийн тусгай зориулалтын 15 тонны 1 машин нэмэгдүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.</p> | 90 |
| 92 | 4.2.2 Агаар, хөрсний | 1. Тогтвортой хөгжлийн үзэл | Үйл ажиллагааны | 100% | Дүүргийн төсөв 8.0 | <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь “Их цамхаг хүрээ” ХХК-тай хамтын ажиллагааны</p> | 70 |

| | | | | | | | |
|----|---|---|---|-----|-------------------|--|----|
| | бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | баримтлалын хүрээнд сэргээгдэх эрчим хүчээр хангах төслүүдийг хэрэгжүүлнэ. | хэрэгжилт хувиар | | | гэрээ байгуулсан бөгөөд 4 дүгээр хороо, Самбуугийн гудамжинд 44 ширхэг нарны зайн гэрэлтүүлэг, 19 дүгээр хороо Ар согоотын зусланд 10 ширхэг нарны зайн гэрэлтүүлэг нийт 54 ширхэг гэрэлтүүлэг тус тус хийсэн. | |
| 93 | | 2. Түүхий нүүрсний хэрэглээг багасгах дулаан баригч утаа шүүгчийн үнийн зохицуулалтыг шийдвэрлүүлж, хэрэглээг нэмэгдүүлэхэд төр, хувийн хэвшил, иргэдтэй хамтран ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 70% | ОУБ-ын дэмжлэг | Гэр хорооллын айлуудад яндангийн дулаан баригчийг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Гүүдшэйрийнг” ХХК-тай санамж бичиг байгуулж, тайлант хугацаанд 1531 ширхэг дулаан баригч суурилуулж дууссан. Мөн дүүргийн нутаг дэвсгэрт тулгамдаж буй эрчим хүчний талаар болон Засгийн газраас нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд эрчим хүчний шөнийн тарифыг 100 хувь хөнгөлөх ажлыг дэмжин хэрэгжүүлж буй “Монварт” ХХК-ны танилцуулж буй монгол гэрт дулаан хуримтлуулах “эко тулгат” халаалтын төхөөрөмжийг танилцуулах ажлыг 7- 18 дугаар хороодын Засаг дарга, ажлын албаны дарга, хэсгийн ахлагч нарын дунд зохион байгуулж ажилласан. “Дулаалга аян”-д нийт 35 айл, өрх бүртгүүлснээс 18 нь дулаалгын материалын 30% төлбөрийг төлж, материалаа авч дулаалгаа хийсэн. Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газраас дүүргийн 7, 8, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Ногоон технологитой хороо” төсөл хэрэгжүүлэхээр болсон. Энэ төслийн ажлын хүрээнд 13 дугаар хорооны 10 айлыг одоогоор цахилгаан халаалтын системд шилжүүлээд байна. Төслийн хүрээнд цаашид 7, 8 дугаар хорооны 20 айлын халаалтын асуудлыг шийдвэрлэхээр Нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газартай хамтран ажиллаж байна. Нийслэлийн Агаарын чанарыг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн 1 дүгээр бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа нийт 191 иргэн аж ахуйн нэгж байгууллагад | 70 |

| | | | | | | | |
|---|--|---|-----------------------------------|------|----------------------|--|----|
| | | | | | | албан шаардлага хүргүүлсэн. | |
| 5. ЖАРГАЛТАЙ ИРГЭН-НУТГИЙН УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ | | | | | | | |
| 5.1 НУТГИЙН УДИРДЛАГА | | | | | | | |
| 94 | 5.1.1 Төрийн албан хаагчдын ажлын үр дүн, хариуцлага тооцох системийг оновчтой хэрэгжүүлж, тэдний ажиллах таатай орчинг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах зорилгоор дүүргийн “Хүний нөөц, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ. | 1. “Хүний нөөц, нийгмийн баталгааг хангах” дэд хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | Дүүргийн төсөв 100.0 | Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Хүний нөөцийн хөгжил нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлуулсан ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх 7 бүлэг 34 заалт бүхий ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд Засаг даргын Тамгын газар болон хороодын ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, мэдээлэл солилцох зорилгоор “Мэдээллийн цаг сургалт”-ыг 8 удаа зохион байгуулсан. Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг орон сууц, хашаа байшин худалдан авахад хөнгөлөлттэй зээлд хамруулах, санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 5 төрийн албан хаагчдад 17.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, өвчлөлтийг эрт илрүүлэх зорилгоор нарийн мэргэжлийн эрүүл мэндийн үзлэг оношлогоо, шинжилгээнд хамруулах ажлыг “Сөүл сонгдо” эмнэлэгтэй хамтран нийт 166 ажилтан, албан хаагчдыг үзлэгт хамруулсан. | 70 |
| 95 | | 2. Хороодын үйл ажиллагааг бие даасан байдлыг нэмэгдүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 70% | Дүүргийн төсөв 114.0 | Хороодын Засаг дарга, Ажлын албаны дарга нарын шуурхай зөвлөгөөнийг 2017 оны эхний 8 сарын байдлаар нийт 26 удаа зохион байгуулсан. Мөн хэсгийн ахлагчдын зөвлөлдөх уулзалтыг 3 удаа зохион байгуулж Нийслэл, | 70 |

| | | | | | | | |
|----|--|--|----------------------------------|------|---------------------|---|----|
| | | | | | | дүүргийн хийж хэрэгжүүлсэн ажил, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг танилцуулж, цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар танилцууллаа. Хороодын Засаг даргын ажлын албаны үйл ажиллагааг дэмжих хүрээнд дүүргийн 2017 оны төсөвт хороо тус бүрт 500.000 төгрөг төсөвлөж, хороодын үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. | |
| 96 | | 3. Хороодоос иргэдэд үзүүлж байгаа Нэг цэгийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, нийслэлийн Үйлчилгээний төв болон бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 5.0 | Оны эхний 8 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 19 хороо болон дүүргийн “Нэг цонхны үйлчилгээ”-гээр 268491 иргэн үйлчлүүлж 267092 санал, хүсэлт хүлээн авч асуудлыг шийдвэрлэсэн байна. Дүүргийн Засаг даргын 2017 оны А/4 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд хороодын “Нэг цонхны үйлчилгээ”-ний мэдээг сар бүрээр нэгтгэж, дүүргийн удирдлагуудад танилцуулж http://www.chingeltei.gov.mn/ сайтад байршуулсан. Дүүргийн Засаг даргын захирамжаар батлагдсан хуваарийн дагуу дүүргийн эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсээс 1-19 дүгээр хороодын иргэдийг оролцуулан “Нээлттэй хаалганы өдөр-Нэг цонхны үйлчилгээ” өдөрлөгийг нийтдээ 5 удаа зохион байгуулж 350 гаруй иргэнийг хамруулсан. 2017 оны нэгдүгээр ээлжийн цэрэг халах, татах ажлын хүрээнд төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, чирэгдэлгүй үйлчлэх зорилгоор татвар, эрүүл мэнд нийгмийн даатгал, иргэний бүртгэл, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр төрийн үйлчилгээг үзүүлж, мэдээлэл тайлбар өгч, гарын авлага тараах материалыг 150 гаруй иргэдэд өгсөн. | 70 |
| 97 | 5.1.2 Нутгийн захиргааны байгууллагын нээлттэй, ил тод | 1. Нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 45.0 | Нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газраас олон нийтийн хэвлэл | 70 |

| | | | | | | | |
|----|--|---|---------------------------------------|------|----------------------|---|----|
| | байдлыг ханган, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлнэ. | үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагуудтай гэрээ байгуулан хамтран ажиллана. | | | | мэдээллийн 4 байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Тухайлбал ТВ5, STAR, MN 25, UBS телевизүүдтэй гэрээ байгуулж иргэд олон нийтэд мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Түүнчлэн дүүргийн цахим хуудас болон дээрх гэрээт телевизүүдээр 8 дугаар сарын байдлаар 757 гаруй зурган мэдээ, 178 гаруй дүрст мэдээллээр үйл ажиллагаагаа сурталчлан ажиллалаа. | |
| 98 | | 2. Нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлаар ном, товхимол, гарын авлага хэвлүүлэн иргэдэд ажлаа тайлагнана. | Хэвлүүлсэн ном, гарын авлагын тоогоор | 100% | Дүүргийн төсөв 50.0 | Нутгийн захиргааны байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 1000 ширхэг, эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг 200 ширхэг хэвлүүлэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд ашиглахаас гадна иргэдэд тараасан. Дүүргийн Бизнес инкубатор төвийн үйлдвэрлэгч бойжигчдын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор “Хамтдаа хөгжье” сэтгүүлийн шинэ дугаарыг бэлтгэн 1000 ширхэг хэвлүүлсэн. | 70 |
| 99 | | 3. Дүүргийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан, үр ашигтай санал санаачилга гаргасан иргэн, төрийн ба төрийн бус, олон нийтийн байгууллагыг бүх талаар дэмжиж, шагнаж | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | Дүүргийн төсөв 100.0 | Дүүргийн Засаг даргын Тамгын газраас жил бүр зохион байгуулдаг тэмдэглэлт баяруудаар эрхэлсэн ажилдаа амжилт гарган олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа иргэн аж ахуйн нэгж байгууллагын ажилтан албан хаагчдад Засаг даргын шагналыг гардуулж өгөх ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд: Дүүргийн “Хүндэт тэмдэг”-ээр 43, “Хөдөлмөрийн алдар медаль”-иар 79, “Тэргүүний сурагч” 66, “Хүндэтгэлийн цом” – 5 буюу нийт 193 иргэнд шагнал гардуулж хүндэтгэл үзүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар | 70 |

| | | | | | | | |
|-----|--|--|----------------------------------|------|----------------|--|----|
| | | урамшуулна. | | | | батлагдсан “Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар нэр дэвшүүлж шаардлага хангасан 3560 иргэний холбогдох баримтын бүрдлийг хүлээн авч дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, хурлын тэмдэглэл, тогтоолыг хавсарган баталгаажуулж, able cloud.mn сайтын шагналын дэд программд бүртгэлжүүлэн Нийслэлийн Засаг даргад уламжилсан. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 122 тоот зарлигаар “Алдарт эх” нэгдүгээр зэргийн одонгоор 21, “Алдарт эх” хоёрдугаар зэргийн одонгоор 335, нийт 356 эхийг шагнах, шагналын үйл ажиллагааг зохион байгуулсан. | |
| 100 | | 4. Төрийн үйлчилгээний нэгдсэн сангийн төрлийг нэмэгдүүлж, дүүргийн вэб сайтыг хөгжүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудын дотуур холбоог шинэчлэн өргөжүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв | Төрийн үйлчилгээний нэгдсэн сангийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Бүртгэлийн хэлтэс, Газрын алба, Замын цагдаагийн хэлтсийн иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний мэдээллийг шинэчлэн засварлалаа. Мөн байгууллагын ил тод байдлыг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн цахим хуудасны баяжилтийг сайжруулах, хэлтэс албадын мэдээллийг шинэчлэх, байгууллагын бүтцийн өөрчлөлттэй холбоотой мэдээлэл шинэчлэх ажлыг тус тус хийж ажиллалаа. Дүүргийн цахим хуудсанд дүүргийн статистикийн хураангуй мэдээлэл, байгууллагын хөдөлмөрийн аваргуудын булан, дэргэдэх хэлтэс, албадын холбоосыг цахим хуудасны нүүр хэсэгт байршуулж иргэдийн | 70 |

| | | | | | | | |
|-----|--|---|----------------------------------|------|-------------------------|---|----|
| | | | | | | мэдээлэл авах нөхцөлийг сайжруулан ажиллалаа. Мөн дүүргийн 1-19 дүгээр хороодыг цахим хуудастай болгон дүүргийн цахим хуудсанд хороодын мэдээллийг байршуулан хороодын ажлын албаны дарга нарт сургалт зохион байгуулан ажиллалаа. Иргэдийг мэдээ мэдээллээр хангах ажлын хүрээнд мэдээний сайтуудаар явагдаж буй дүүргийн мэдээ мэдээллийг цахим хуудсанд байршуулан ажиллалаа. Дүүргийн нэгдсэн сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд 2, 3, 8, 16, 17, 18, 19 дүгээр хорооны дотоод сүлжээг цэгцлэх, байгууллагын дотоод холбоог өргөтгөх ажлын хүрээнд хэлтсүүдийн дотоод холбооны үзүүрийг тохируулан өргөтгөж ажиллалаа. | |
| 101 | 5.1.3 Дүүргийн нэгдсэн сүлжээний ашиглалтын хүрээнд барилгажсан хэсэгт агаарын кабелийг үе шаттайгаар сувагчлалд шилжүүлэн, сүлжээний найдвартай ажиллагааг бүрэн хангана. | 1. Мэдээлэл холбооны сувагчлалын шинэчлэлийн ажлын хүрээнд агаараар явж байгаа трассыг үе шаттайгаар сувагчлалд шилжүүлэх ажлыг зохион байгуулж, гэмтлийг засварлан, сүлжээг өргөтгөнө. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Нийслэл, дүүргийн төсөв | Дүүргийн хэмжээнд шилэн кабелийг сувагчлалд шилжүүлэх ажлын хүрээнд агаараар явж байсан шилэн кабелийн трассыг 7 буудлаас 18 дугаар хороо хүртэл 900м газрыг сувагчлалд шилжүүлсэн. Шилэн кабелийн ашиглалтын хүрээнд дүүргийн хэмжээнд ашиглагдаж байгаа шилэн кабелийн сувагчлалын түрээсийн хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ компанитай гэрээгээ сунган ажилласан. Мөн дүүргийн 11, 12 хороо болон 61 дүгээр дунд сургуулийн шилэн кабелийн гэмтлийг тогтоон засварласан. Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн хяналтын камерын ашиглалтын хүрээнд дүүргийн 16 дугаар хорооны хяналтын камерын шилэн кабел гэмтсэн байсныг засварлан хэвийн ажиллагаанд оруулсан. | 70 |
| 102 | 5.1.4 Захын болон алслагдсан гэр хороололд утасгүй Wi-Fi үйлчилгээг | 1. Гэр хорооллын хорооны ажлын алба орчим утасгүй интернетийн үйлчилгээг | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 25.0 | Дүүргийн 1-19 дүгээр хорооны иргэний танхимд утасгүй интернетийн бүс байгуулан иргэдийн мэдээлэл авах нөхцөлийг сайжруулан ажиллаж байна. Мөн дээрх хороодын цогцолбор байрны гадна орчинд 200 метрийн радиустай орчинд Нийслэлийн мэдээллийн технологийн газраас | 70 |

| | | | | | | | |
|-----|--|---|-----------------------------------|-----|--------------------|---|----|
| | нэвтрүүлнэ. | хүргэн тодорхой орон зайд утасгүй интернетийн бүс байгуулна. | | | | нэвтрүүлж буй Улаанбаатар WiFi утасгүй интернетийн бүс байгуулах ажлыг Бодь Электроникс ХХК-тай хамтран дүүргийн нэгдсэн сүлжээнд өргөтгөл, шаардлагатай тохиргоог хийн амжилттай нэвтрүүлэн ажиллалаа. Улаанбаатар WiFi сүлжээний найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах ажлын хүрээнд 2, 3, 4, 5, 16, 18 дугаар хорооны сүлжээнд гарсан гэмтэл, саатлыг засварлан ажиллалаа. | |
| 103 | 5.1.5 Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлж, зөрчил дутагдлыг шуурхай арилгадаг, заавар зөвлөмжийг тогтмол өгдөг тогтолцоонд шилжүүлнэ. | 1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангуулах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй барилга угсралтын болон барилгын материалын үйлдвэрүүдэд сургалт зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 10% | Дүүргийн төсөв 5.0 | Тайлант хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт барилга угсралтын ажил гүйцэтгэж буй Титантауэр констракшн ХХК, Монбурда ХХК-уудыг “Хөдөлмөрийн харилцааг шалгах 4.6, Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах 4.1.2 кодтой хяналтын хуудас”-аар шалгахад Монбурда ХХК нь бага эрсдэлтэй, Титантауэр констракшн ХХК нь дунд эрсдэлтэйгээр тус тус үнэлэгдлээ. Титантауэр констракшн ХХК, Рич констракшн ХХК, Монбурда ХХК-уудад 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 02-01/628 тоот хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох дүрэм журам, стандартыг хэрэгжүүлж аюулгүй ажиллах талаар мэдэгдэл хүргүүлсэн. Дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтсийн сайтанд 4 зөвлөмж, 2 төрлийн сэрэмжүүлэг байршуулсан. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангуулах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй барилга угсралтын болон барилгын материалын үйлдвэрүүдэд 2017 оны 3, 4 дүгээр улирлуудад сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг зохион байгуулж байна. | 50 |
| 104 | | 2. Дүүргийн нутаг давсгэр дэх сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 20% | Дүүргийн төсөв 6.0 | Батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу дүүргийн хэмжээнд 12 цэцэрлэг, 3 ерөнхий боловсролын сургууль, 3 сургуулийн цайны газрыг түрээслэгч ААН, нийт 18 байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөл, цэцэрлэгийн хүүхдийн болон сурагчдын хоол | 70 |

боловсролын сургуулиудад гардаг халдварт өвчин, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа явуулж, хяналт шалгалт хийнэ.

үйлдвэрлэл, хүнсний чанарт хэмжилт, шинжилгээтэй шалгалт хийлээ. Шалгалтын явцад хүүхдийн хоолны 8 сорьц, унд ахуйн уснаас 6 сорьц, агаарын ариун цэврийн 3, дотоод орчны агаарын чанарын 3, хөрсний 1 сорьц, 3 цэцэрлэгийн 30 цэгээс эрүүл зүйн арчдас шинжилгээ авч НМХГ-ын Нэгдсэн төв лаборатори шинжлүүлэн үнэлэлт, дүгнэлт өгч ажилласан. Шалгалтын хугацаанд нийт 158 зөрчил илрүүлж 38 буюу 24 хувийг шалгалтын явцад арилгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага 18-ыг 214 заалттай /үүнээс эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр 109 заалттай/, шинжилгээний дүгнэлт 22-ыг үйлдэж 3 байгууллага, 1 албан тушаалтанд 640.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрүүл ахуй, хоол хүнсний аюулгүй байдлыг хангах, өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмолжуулах, эрүүл ахуйн зохистой дадлыг эзэмшүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, шалгагдсан байгууллага бүрт байгууллагын сургалтыг зохион байгуулж, бүртгэл хяналтын хөтлөлтийн загвараар хангаж ажиллалаа. Мөн дүүргийн хэсгийн болон зөөврийн усан хангамжтай 9 цэцэрлэг, 4 сургууль, төвлөрсөн усан хангамжтай 9 цэцэрлэг, нийт 22 хүүхдийн байгууллагын унд, ахуйн хэрэглээний уснаас сорьц авч НМХГ-ын НТЛ-ийн сорилтын дүнг үндэслэн улсын байцаагчийн 22 дүгнэлт үйлдсэн. Лабораторийн шинжилгээний сорилтын дүнгээр 3 цэцэрлэгийн ус химийн үзүүлэлтээр, 2 байгууллагын ус нян судлалын үзүүлэлтээр стандарт шаардлага хангаагүй үзүүлэлттэй гарсан тул дээрх байгууллагуудад ус нөөцлөх савыг зааврын дагуу угааж, халдваргүйтгэх, ундны усанд шүүлтүүр суурилуулах зааварчилгаа зөвлөмж

| | | | | | |
|--|--|--|--|--|---|
| | | | | | <p>өгч, давтан шинжилгээ сорьц авч, үнэлэлт дүгнэлт өгч ажилласан. МХЕГ, НМХГ хамтран “Сургууль, цэцэрлэгийн эрүүл ахуй, дотоод хяналтын асуудлууд” сэдэвт салбарын сургалтыг онлайнаар зохион байгууллаа. Сургалтад дүүргийн 37, 70, 102, 154, 173 дугаар цэцэрлэг, 17, 49, 57, 138 дугаар сургуулийн удирдлага, эмч, дотоод хяналт хариуцсан ажилтнууд хамрагдлаа. Мөн дүүргийн Ерөнхий боловсролын 20 сургуулийн бага ангийн менежер, дотоод хяналтын ажилтан, 16 цайны газрын цайны газрын ажилтан, нийт 45 хүнд “Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахад ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, аж ахуйн нэгжийн үүрэг, оролцоог сайжруулах нь” сэдэвт 4 цагийн сургалт зохион байгуулж, сурагчдын хоолны чанар, аюулгүй байдал, мөрдөж ажиллах тушаал шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгч, зөвлөмж хүргүүлж ажиллалаа. МХЕГ-ын ХАБХААХГ, ЭМБСХГ, НМХГ-аас хамтран зохион байгуулсан “Хүнсний бүтээгдэхүүнийг худалдаалахад тавигдах шаардлага” сэдэвт улсын хэмжээнд зохион байгуулсан салбарын сургалтанд дүүргийн 6 сургуулийн цайны газрыг түрээслэгч ААН, ЕБС-ийн орчим болон хүнсний худалдаа, үйлчилгээ эрхлэгч 12 иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийг хамрууллаа. МХЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу дүүргийн 19, 70, 247, 174-р цэцэрлэг, 117-р сургуулийн хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил хангагдсан байдалд хяналт тавьж ажиллалаа. Хэсгийн болон зөөврийн усан хангамжтай 174, 246-р цэцэрлэг, 117-р сургуулийн ундны ус нь стандартын шаардалага хангасан байдалд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор 3 сорьц авч НМХГ-ын Нэгдсэн төв лабораторит хүргүүлээ. Цэцэрлэгт</p> |
|--|--|--|--|--|---|

| | | | | | | | |
|-----|--|---|-----------------------------------|------|--------------------|--|----|
| | | | | | | бүртгүүлсэн хүүхдүүдийг хичээл эхлэхээс өмнө, хуваарийн дагуу цэцэрлэг дээр нь нэгдсэн журмаар эрүүл мэндийн шинжилгээнд хамруулах, сургуулийн бага ангийн багш, цэцэрлэгийн багш ажиллагсдыг нэгдсэн журмаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах хуваарийг гаргаж, бэлтгэл ажлыг хангуулж ажилласан. | |
| 105 | | 3. Дүүргийн нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн байгууллагаас үүдэн гардаг халдварт өвчнийг бууруулах талаар сургалт сурталчилгаа явуулж, хяналт шалгалт хийнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 10% | Дүүргийн төсөв 4.0 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд эрсдэлтэй гэж үнэлэгдэн шалгалтанд хамрагдахаар зарлагдсан Бэтүвданжай чойнхорлон хийдийн Найдан эмнэлэг, Уран манал уламжлалт эмнэлгүүдэд Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газрын даргын баталсан 02-01/143 тоот удирдамжийн дагуу шалгалт хийсэн. Шалгалтаар дээрх байгууллагуудад дотоодын хяналт хангалтгүй, хувь хүний хариуцлага сул зэрэг зөрчил дутагдал илэрсэн ба тус эмнэлгүүдэд байгууллагын сургалтуудыг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Дүүргийн 1-19 дүгээр хорооны ӨЭМТ-ийн эмч, сувилагч, нийгмийн ажилтан нарт “Хүүхдийн өвчний цогц менежмент” сэдвээр сургалт зохион байгуулж хяналт шалгалтын урьдчилсан дүнг танилцуулж, илэрч буй зөрчил, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. | 70 |
| 106 | | 4. Үйлчилгээний салбарт стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах зорилгоор хяналт шалгалтын ажлыг | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 5.0 | Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан 20 худалдаа, үйлчилгээний газарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээс дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргын баталсан хөтөлбөрийн дагуу 14 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хяналтын хуудсаар дүгнэхэд 39.5-51 хувийн дунд болон их эрсдэлтэй дүгнэгдсэн бөгөөд, улсын | 70 |

| | | | | | | | |
|-----|--|--|--|------|--------------------|--|----|
| | | тогтмолжуулан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлнэ. | | | | байцаагчийн 125 заалттай 14 зөвлөмж хүргүүлэн, гүйцэтгэлийг хангуулан ажиллалаа. Үндэсний их баяр наадмын үеэр хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээр хүсэлт гаргасан 82 ААН, иргэнд, худалдаа үйлчилгээ эрхлэхээр хүсэлт гаргасан 27 иргэнд нийт 109 иргэн, ААН-д үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл өгч хяналт тавин ажилласан. Төв Цэнгэлдэх хүрээлэнд хяналт шалгалт хийх явцад айргийн 7 цэгээс дээж авч шинжлүүлэн, зөвшөөрөлгүйгээр үйлчилгээ эрхэлж байсан 8 хуушуурын цэг, шорлог зарсан 3 иргэн, 3 ААН-ийн үйл ажиллагааг, 2 иргэний хөөсөн чихрийн худалдааг зогсоосон. Хүрээ цам - Даншиг наадмын үеэр 5 улсын байцаагч хяналт тавьж ажиллаж, хяналтын шалгалтын үеэр илэрсэн зөрчилгүй, олныг хамарсан хоолны хордлого, хордлогот халдвар гараагүй байна. | |
| 107 | 5.1.6 Улсын бүртгэлийн үйл ажиллагааг онлайн горимд шилжүүлж, үндэсний цахим баримт бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | 1. Дүүргийн 16-19 дүгээр хороонд ТҮЦ машины тоог нэмэгдүүлнэ. | Шинээр нэмэгдүүлсэн ТҮЦ машины тоогоор | 100% | Улсын төсөв 9.0 | Тайлангийн хугацаанд дүүргийн хэмжээнд ашиглагдаж буй ТҮЦ машины судалгаа, ТҮЦ машинаас гардаг лавлагаа мэдээллийн талаарх судалгааг хийсэн. Судалгаагаар дүүргийн 35 ТҮЦ машинаас 21 нэр төрлийн лавлагаа мэдээллийг иргэд авч төрийн үйлчилгээг хүртэж байна. Үндэсний Дата төвд ТҮЦ машиныг байршуулах хүсэлтийг хүргүүлсэн боловч одоогоор ТҮЦ машины нөөц дууссан байгаа тул нэмж байршуулах боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн. | 50 |
| 108 | 5.1.7 Гэр хорооллын гудамжны хаягжилтыг эрэмбэ дараатай цэгцлэн, иргэний бүртгэлийн хаягийн зөрчил давхардлыг | 1. Гэр хорооллын гудамжны хаягжилтийн зөрчлийн судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудтай хамтран зөрчлийг | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 7.5 | Тайлант хугацаанд 3 төрлийн хаягийн зөрчлийн судалгааг нэгтгэн гаргасан. Тус судалгаанд нийт 11577 иргэнээс нэг хаяган дээр бүртгэлтэй 10-аас дээш сонгогчтой 5901, тодорхой оршин суух хаяггүйн улмаас шилжилт хөдөлгөөн хийлгээгүй 5600, төлбөрийн чадваргүйн улмаас шилжилт хөөлгөөний бүртгэлд бүртгүүлээгүй 76 иргэн тус тус бүртгэгдсэн байна. Нийт зөрчилтэй иргэдээс тухай бүр иргэдтэй | 70 |

| | | | | | | | |
|-----|--|--|----------------------------------|------|---------------------|--|----|
| | арилгана. | арилгана. | | | | холбогдон 445 иргэний хаягийн зөрчил, сүлжээнд хаяг зөрүүтэй орсон 36 иргэний мэдээллийг тус тус засварласан. Мөн харъяатаас гарсан 2 иргэнийг тухайн хороод нь офлайн бүртгэлийн программаас хасалт хийж ажиллалаа. Мөн 3, 4 дүгээр саруудад хаягийн зөрчил арилгах аяныг 19 хороодын дунд зарлан нийт 925 хаягийн зөрчил илрүүлсэнээс 601 зөрчлийг нь арилгасан. Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн 1061 иргэн давхар болон хаягийн бичвэр алдаатай байсныг нэгтгэж хаягийн бичвэрийг зассан. | |
| 109 | 5.1.8 Батлан хамгаалах хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулж, хэрэгжилтийг хангуулан ажиллана. | 1. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг иргэд, байгууллага аж ахуйн нэгжид сурталчилж, хяналт тавина. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 10.0 | Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын удирдамж, дүүргийн Засаг даргын 2017 оны А/19 дүгээр захирамжийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн 7, төрийн бус 3, нийт 10 байгууллага, аж ахуй нэгжийн 647 цэргийн бэлтгэл үүрэгтнийг хамруулан шалган туслах ажлыг зохион байгууллаа. Тус ажлын хүрээнд нийт 205 иргэдийн зөрчлийг илрүүлж, цэрэг татлага, тоо бүртгэлээс завсардсан иргэдэд хуулиа биелүүлж, үүргээ ухамсарлах, шинээр батлагдсан Батлан хамгаалах багц хуулийг сурталчлах талаар яриа, таниулга хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Байлдагч, түрүүчийн алба хаах насны дээд хязгаарт хүрч цэргийн алба биеэр хаагаагүй иргэнд хуулийн дагуу мөнгөн төлбөр тогтоож нийт 117 иргэний 60,2 сая төгрөгийг Нийслэлийн төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. | 70 |
| 110 | | 2. Иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд залуучуудад цэрэг эх оронч | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 48.2 | Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны 25, Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 96 жилийн ойн үйл ажиллагааны хүрээнд дүүргийн ерөнхий боловсролын 12 сургуулиудын ахлах ангийн 300 гаруй сурагчдын дунд цэрэг спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг зохион байгуулж, | 70 |

үзлийг
төлөвшүүлэхэд
чиглэгдсэн үйл
ажиллагааг
зохион
байгуулна.

багийн нийлбэр дүнгээр тэргүүн байранд 24 дүгээр сургууль, дэд байранд 23 дүгээр сургууль, 3 дугаар байранд 72 дугаар сургууль тус тус байр эзэлсэн. “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 96 жилийн ойн баярын хурал, **Батлан хамгаалах багц хуулийг сурталчлах** өдөрлөгт бэлтгэл офицер, ахмад дайчин 100, оюутан сурагчид 200 нийт 300 иргэнийг оролцуулан, цэргийн штабын үйл ажиллагааг сурталчилж, иргэдэд батлан хамгаалах төрийн үйлчилгээг үзүүлж ажилласан. **“Эх орон-Тусгаар тогтнолын эзэд”** сэдэвт ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хүндэт харуулын цэргүүдийн жагсаалын үзүүлэх тоглолт, Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн гардан тулааны үзүүлэх тоглолт, БХИС-ийн Цэргийн хөгжмийн сургуулийн сонсогчдын үзүүлэх тоглолт, Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга болон дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсүүд, Замын цагдаагийн тасаг, Онцгой байдлын хэлтэс, Боловсролын хэлтэс болон бусад байгууллагуудтай хамтран Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулсан. Тус арга хэмжээний үеэр ерөнхий боловсролын 12 сургуулийн 800 сурагч үндэснийхээ хувцсаар гоёж эх орондоо андгай өргөсөн. Монгол цэргийн өдрийн хүрээнд батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний анги байгууллагуудыг сурталчилан таниулах, хүүхэд залуучуудад эх оронч хүмүүжил төлөвшүүлэхэд чиглэгдсэн **“Цэрэг эх-орны алба”** өдөрлөгийг Хилийн цэргийн 0151, ОБЕГ-ын харьяа аврах тусгай ангиудтай хамтран зохион байгуулсан. Энэхүү үйл ажиллагаанд дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын төлөөлөл болсон 100 гаруй сурагчдыг хамруулан цэргийн анги, байгууллагуудын үйл ажиллагаатай

| | | | | | | | |
|-----|------------------------------------|---|---------------------------|------|---------------------|--|----|
| | | | | | | <p>танилцуулж яриа таниулга хийж ажилласан. Чингэлтэй дүүрэг үүсэн байгуулагдсаны түүхт 25, Монгол цэргийн өдрийн хүрээнд дүүргийн хороодод “Мөрдэстэй залуу нас” сэдэвт алдаршуулах гурван үеийн уулзалт өдөрлөгийг зохион байгуулж, нийт 1200 гаруй иргэн хамрагдаж, 80 гаруй ахмад дайчин, офицер, ахлагч нарыг алдаршуулсан байна. Хугацаат цэргийн алба хааж байгаа болон тэдгээрийн ар гэрт Засаг дарга, дүүргийн удирдлага хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг уламжлал болгон зохион байгуулж, Зэвсэгт хүчний 015 дугаар ангид хугацаат цэргийн алба хааж байгаа цэрэг дайчдыг эргэх, Засаг даргын мэндчилгээг хүргэх үйл ажиллагааг зохион байгуулсан ба, хугацаат цэргийн алба хааж байгаа 6 байлдагчийг ар гэрийн хамт дүүргийн Засаг дарга хүлээн авч хүндэтгэл үзүүлэн тус бүр 500.000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж, хугацаат цэргийн албаа нэр төртэй хаахыг хүсэн мэндчилсэн. Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/144 дүгээр тушаал, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын даргын 11 дүгээр тушаалын дагуу зохион байгуулсан Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах Батлан хамгаалах яамны “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т оролцож 6 иргэнд цэргийн үүрэгтний үнэмлэх шинээр нээн олгож, 71 иргэнд Батлан хамгаалах багц хуулийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Батлан хамгаалах сайдын нэрэмжит улсын аврага шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмээнд дүүргийн ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн ахлах ангийн сурагчид оролцохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> | |
| 111 | 5.1.9 Дайчилгааны бэлэн байдлын | 1. Дайчилгааны төлөвлөгөөт арга хэмжээний | Үйл ажиллагааны хэрэгжилт | 100% | Дүүргийн төсөв 40.0 | <p>Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/49 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын А/71 дүгээр тушаалын дагуу</p> | 90 |

| | | | | | | | |
|-----|--|--|----------------------------------|------|---------------------|---|----|
| | төлөвлөлт, удирдлагын нэгдмэл байдлыг ханган ажиллана. | хэрэгжилтийг ханган сургалтуудыг чанаржуулна. | хувиар | | | хороодын Засаг дарга, Ажлын албаны дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан. Мөн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтыг Батлан хамгаалах туслах нийгэмлэгийн харьяа “Ар сайхан” авто сургуультай хамтран 10 бэлтгэл үүрэгтнийг жолооны В-С ангилал ахиулах, “ТЕЛЕФОНЧИН” мэргэжлээр 15 бэлтгэл үүрэгтнийг Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн тус тус 14 хоногийн хугацаатай зохион байгуулж явуулсан. Сургалтад хамрагдсан бэлтгэл үүрэгтнүүдийг анги командуудад оногдуулан дансалсан. 2017 онд явагдах сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчдын цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж, сургалтад хамрагдах 31 иргэнтэй гэрээ байгуулсан. | |
| 112 | | 2. Цэргийн бүртгэлийг чанаржуулан 2017 оны 1, 2 дугаар ээлжийн цэрэг халалт, татлага, ажлын байр, сургалт дамжаанд зуучлана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 20.0 | Дүүргийн Засаг даргын А/797 дугаар захирамжийн дагуу 2017 оны цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын бүртгэлийг 1 дүгээр сарын 04-ний өдрөөс 1 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал зохион байгуулж явуулсан бөгөөд бүртгэлийн хамралт 95.6 буюу өнгөрсөн жилийнхээс 0.2 хувиар өссөн дүнтэй байна. 2017 онд явагдах “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах оюутнуудын судалгааг гаргуулан, эрүүл мэндийн үзлэг, биеийн тамирын шалгалтад хамруулан, 7 сургуулийн 34 оюутныг ҮБХИС-д хүлээлгэн өгсөн. Дүүргийн Засаг даргын 2017 оны А/206 дугаар захирамжийн хүрээнд 2017 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг 2017.05.05-наас 2017.05.07-ны өдрүүдэд зохион байгуулан Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн Штабаас өгсөн хяналтын тоог бүрэн | 70 |

| | | | | | | | | |
|--|--|----------------------------------|---|----------------------------------|------|---|--|----|
| | | | | | | биелүүлсэн. Цэргийн бүртгэлийн мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулах зорилгоор шилжин ирсэн, явсан иргэдийн мэдээллийг тогтмол оруулж, 2017 оны 2 дугаар ээлжээр цэргийн албанд татагдах 18-26 насын иргэдийн нэрсийг хороо тус бүрээр гаргахад бэлэн болсон. | | |
| 5.2 ГЭМТ ХЭРЭГ, ГАМШИГ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ | | | | | | | | |
| 113 | 5.2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон талт хэмжээг байгуулж, үйлдэгдэж гэмт захиргааны зөрчлийг бууруулна. | Гэмт олон арга зохион буй хэрэг, | 1. Иргэдийн аюулгүй, тайван орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах хууль, эрх зүйн мэдлэг олгох ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 50.0 | Нийтийн хэв журам хамгаалах тасгаас нийт 21197 зөрчлийг илрүүлэн, 9732 иргэн, аж,ахуйн нэгж байгууллагыг 65,105,000 төгрөгөөр торгож, 499 иргэнийг материалжуулан баривчлах арга хэмжээ авч ажиллалаа. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчлэгдсэн заалтаар 1200 ширхэг, Насанд хүрээгүй хүүхдийн эрх ашиг хөндөгдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж сэрэмжлүүлэг 1500 ширхэгийг тус тус тарааж ажиллалаа. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 52 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг хороодын эрүү болон хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулан үр дүнг тооцон ажиллалаа. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 12 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг 71 удаа тус тус хороодын эрүү болон хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулан үр дүнг тооцон ажиллалаа. Тус дүүрэг дэх Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсээс Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, орон сууц, гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэргийг бууруулах зорилгоор нийслэл хотод орон сууцны барилгын орц, гадна орчин гэр хорооллын гудамж, талбай зэрэг газруудыг камержуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | 70 |

| | | | | | | | |
|-----|--|---|----------------------------------|------|---------------------|---|----|
| | | | | | | ажилд дэмжлэг үзүүлэх зорилготой “Камержуулалт” болзолт уралдааны хүрээнд СӨХ-11, Хөршийн хяналтын бүлэг-1, иргэн-2, аж ахуйн нэгж байгууллага-2 нийт 16 аж ахуйн нэгж байгууллагаас 46.250.000 төгрөгний төсөвтэйгээр 190 ширхэг камерыг хариуцсан нутаг дэвсгэртээ байршуулж ажилласан. Байршуулсан камеруудаас байшин хороололд 135, гудамжинд 46, гэр хороололд 9 камераар хяналт тавьж байна. | |
| 114 | | 2. Урамшилт эргүүлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, гэмт хэрэг ихээр үйлдэгддэг цэгийн судалгааг гаргаж, байнгийн хяналт тавьж ажиллана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 72.0 | Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажиллах журам, 2 дугаар хавсралтаар Хороодын нутаг дэвсгэрт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах багийн ажиллах журам, 3 дугаар хавсралтаар Хороодод ажиллах Хэв журмын урамшилтай эргүүлийн ажиллах журам, 4 дүгээр хавсралтаар Чингэлтэй дүүргийн хороодын гудамж, байранд Нийтийн эргүүл, ажиллуулах журмын дагуу 524 иргэнийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллуулж байна. Энэ хүрээнд 1-19 дүгээр хороодод Хэв журмын урамшилтай эргүүл 18, хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх урамшилт эргүүл 3 нийт 21 урамшилт эргүүл ажиллаж байна. | 70 |
| 115 | 5.2.2 Тусгай мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах орчин, нөхцөл, аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай | 1. Тусгай мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах орчин, нөхцөл, аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв | Тусгай мэргэжлийн байгууллагуудын албан хаагчдын ажиллах орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай техник хэрэгслээр хангах ажлын хүрээнд дүүргийн төсвийн 250,0 сая төгрөгийн хөрөнгөөр Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн гадна тохижилт, шаардлагатай техник хэрэгсэл, цагдаагийн 2 дугаар хэлтэст техник тоног төхөөрөмж, Замын | 70 |

| | | | | | | | |
|-----|---|--|----------------------------------|------|--------------------|--|----|
| | техник хэрэгслээр хангана. | техник хэрэгслээр хангана. | | | | цагдаагийн хэлтсийн үүдний хэсгийн засвар, тоног төхөөрөмж, дүүргийн прокурорын газар, эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын албан хэрэгцээнд автомашинаар хангахаар батлагдаж, Замын цагдаагийн хэлтсийн үүдний хэсгийн засварыг 3,8 сая төгрөгөөр “Хүрээ өргөө” ХХК, мөн тус хэлтсийг техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг 36,8 сая төгрөгөөр “Голден прогресс” ХХК, дүүргийн прокурорын газарт автомашин нийлүүлэх ажлыг 60,0 сая төгрөгөөр Монгол Хьондай автоматив” ХХК, эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх ажлыг 49,5 сая төгрөгөөр “Эф Эй Ди” ХХК хийж гүйцэтгэсэн. Цагдаагийн 1 дүгээр хэлтэст гэмт хэрэг, зөрчил гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэрч, хохирогч, насанд хүрээгүй иргэдээс тайлбар мэдүүлэг авах, таньж олуулах ажиллагаа явуулах байцаалтын өрөөг Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын 18.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулсан. | |
| 116 | 5.2.3 Замын хөдөлгөөний зохицуулалтыг оновчтой болгож, зам тээврийн осол, хэргийн гаралтыг бууруулна. | 1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай замуудад замын тэмдэг тэмдэглэгээг хийнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 6.5 | Тайлант хугацаанд зам тээврийн ослын нийт 4715 дуудлага мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн ба урьд оны мөн үетэй харьцуулахад 14.9 хувь өссөн байна. Нийт бүртгэгдсэн гомдол мэдээллээс 139 буюу 2.9 хувь нь эд материалын хохиролтой зам тээврийн осол байна. Зам тээврийн ослын улмаас 80.261.000 төгрөгийн материаллаг хохирол учирсны 59.340.000 төгрөгний хохирлыг хэрэг бүртгэлтийн шатанд нөхөн төлүүлсэн ба нөхөн төлүүлэлт 73.9 хувьтай байна. Замын хөдөлгөөний ачаалал ихэсдэг томоохон худалдааны төв, зах дэлгүүрүүд болох Хүчит Шонхор, Нарантуул-2 зах, орчмоор Хүрэмт-13, Бөмбөгөр, Алтжин, Теди зэрэг томоохон худалдааны төв болон Тэнгисийн урд талын болон Бөмбөгөр худалдааны төвийн | 70 |

| | | | | | | | |
|-----|---|---|-----------------------------------|------|------------------------------|---|----|
| | | | | | | баруун талын автобусны буудлууд дээр Хүрэмт-12, УИД болон Энхтайваны өргөн чөлөө Энхтайван Найрамдлын ордон, Цэцэг төв баруун талын болон Мөнгөн завъяагийн автобусны буудлын орчимд Хүрэмт-11 бүсийн эргүүлийн зохицуулагч нар өглөө ажил цуглах болон орой ажил тарах үед замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар болон замын хөдөлгөөнд соёлтой оролцож байх талаар өдөрт 2 удаа хагас жилд 360 удаа автомашины чанга яригчаар ухуулга яриа хийж ажиллаж байна. | |
| 117 | | 1. Гэр хорооллын айл өрхүүдэд шуурхай албаны автомашин очих боломжгүй мухар гудамжыг чөлөөлж, гарц гаргана. | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 100% | Дүүргийн төсөв 3.0 | Дүүргийн нутаг дэвсгэрт “Нарийн болон мухар гудамжны судалгаа”, “Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хамгаалалтын зурваст суурьшсан иргэн аж ахуйн нэгж байгууллагын судалгаа” явуулахад гэр хорооллын хороодын 179 айл өрх мухар гудамжтай байна. Эдгээр айл өрхүүдээс нүүлгэн шилжүүлэх нэн шаардлагатай 5 өрхөд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл бичиж хүргүүлсэн. | 50 |
| 118 | 5.2.4 Дүүргийн гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ. | 2. Мал амьтныг вакцинжуулалтад хамруулах, дүүргийн нутаг дэвсгэрээс нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | Дүүргийн төсөв, Гүйцэтгэлээр | Дүүргийн онцгой комиссын “Хүн малын гоц халдварт өвчинтэй тэмцэх” Ажлын хэсгийн хурлыг зарлан хуралдуулж дүүргийн Онцгой комиссын даргын 03 тоот тушаалаар 14-р хорооны 11-15 дугаар гудамжинд хязгаарлалтын бүс тогтоон вакцинжуулалт, ариутгал халдваргүйжүүлэлт, хяналт, тандалтын ажлыг зохион байгуулан ажиллалаа. Халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, үхсэн нохой, муур, малын сэг зэмийг устгах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх зардалд дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2.252.170 төгрөгийг Хязгаарлалтын бүсэд дүүргийн Мал эмнэлэг “Содхан” ХХК-аас 14 дүгээр хорооны 358 өрхийн 366 нохойд галзуу өвчнөөс | 70 |

| | | | | | | | |
|-----|--|---|-----------------------------------|------|---|---|----|
| | | | | | | урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийж 1426 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан. Дүүргийн Засаг даргын 2017 оны А/179 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийт 2600 бог, бод малд боом өвчин, ДХХ бактериоз, дуут хавдар, цусан халдвар, галзуу, сахуу антивирусаас сэргийлэх вакцин хийсэн. Бруцеллез өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд хамруулах 283 төл малын судалгааг гаргаж Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Оны эхэнд дүүргийн нутаг дэвсгэрт малтай 41 өрх байснаас 3 өрхийг нүүлгэн шилжүүлж, 38 өрхийн 1146 тоо толгой мал байна. | |
| 119 | 5.2.5 Дүүргийн нутаг дэвсгэрт “Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлнэ. | 1. “Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөрийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулна. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | - | Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх” хөтөлбөрийг Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуульд нийцүүлэн боловсруулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2017 оны 30 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд иргэдийг аюулгүй амьдрах ухаанд сургах, гамшгийн эрсдэлийг бууруулах, төрийн болон мэргэжлийн байгууллагуудаас гадна хувийн хэвшил, төрийн бус байгууллага, сайн дурын олон нийтийн байгууллага иргэдийн оролцоог гамшгаас хамгаалах ажиллагаанд татан оролцуулах зорилготой “Аюулгүй хороо” нэгдсэн сургалт өдөрлөгийг 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулж, Онцгой байдлын хэлтсээс 5 офицер, 58 ахлагч, 4 автомашинтайгаар, дүүргийн Гамшгаас хамгаалал сайн дурын хэсгээс 4 албан хаагч, Эрүүл мэндийн төвийн 3 эмч, УБЦТС ТӨХК Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвөөс 6 ажилтан, 19 дүгээр хорооны ажлын | 70 |

| | | | | | | | |
|-----|--|--|-----------------------------------|------|---------------------|--|----|
| | | | | | | албаны 18 албан хаагч, нийтийн эргүүл 29 ажилтан нийт 125 хүн хамрагдсан. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд дүүргийн Засаг даргын захирамжаар сайн дурын хэсэг байгуулагдаж үйл ажиллагаа тогтмолжсон байна. Одоогийн байдлаар сайн дурын хэсэг нь хэсгийн ахлагч 1, сайн дурын 5 ажилтан нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй үүрэг гүйцэтгэж байна. | |
| 120 | | 2. Дүүргийн хэмжээнд гамшгийн нөөц бүрдүүлнэ. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | Дүүргийн төсөв 40.0 | Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гамшгийн нөөц бүрдүүлэхэд зориулж 40,0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөгдсөнөөс тайлант хугацаанд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах тухай дүүргийн Засаг даргын А/240 дүгээр захирамжаар 25.141.800 төгрөг, Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай А/220 тоот захирамжаар 3.041.380 төгрөг Бэлэн байдлыг хангах тухай А/104 тоот захирамжаар 11.699.00 төгрөг, Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, эргүүл, хяналт шалгалт хийх тухай А/530 тоот захирамжаар 3.198.000 төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргаж нийт 4 захирамжаар 43.179.180 төгрөгийг шийдвэрлэж зарцуулаад байна. | 90 |
| 121 | | 3. Дүүргийн хэмжээнд гамшиг ослын цагийн байдлын тухай мэдээллийг цуглуулж үнэлэх, эрсдэлийн зураглал хийж судалгаа гаргана. | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100% | Дүүргийн төсөв 2.0 | Оны эхний 8 дугаар сарын байдлаар Гал түймэр унтраах, аврах 10 дугаар анги нь 250 удаагийн 5018 цагийн харуул ээлжийн үүрэг гүйцэтгэх явцад гал түймрийн дуудлагаар 524 удаа гарснаас 355 удаа гал түймэр дээр нийт 132 цаг 38 минут ажиллаж 661 тонн ус, шатах тослох материал дизель түлш 16,400,8 литр буюу 33,814,531 төгрөгийг зарцуулан аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 3 тэрбум 627 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, 119 гал түймрийг иргэд унтрааж, 421 иргэн 138 байшин барилгыг гал түймрийн аюулаас авран | 90 |

| | | | | | | |
|--|--|--|--|--|---|--|
| | | | | | хамгаалжээ. Өөрөө унтарсан 16 гал түймэр, худал дуудлага 3 байсан байна. Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгон, Тайл хүдэрийн хоовооцойн ам, Мөнгөлөгийн зоо гэх газарт гарсан ой хээрийн түймэрт 12 албан хаагч пургон автомашинтай 8 хоног үүрэг гүйцэтгэв. Дүүргийн төвийн орон сууцны 5 дугаар хороо, гэр хорооллын 8 дугаар хороог тус тус сонгон гамшгийн эрсдэлийн зураглал гаргах бүх төрлийн судалгааг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гарган зураглалын эхний хувилбарыг Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газраар хэвлүүлэх, хороодын иргэдэд танилцуулах ажлыг хийж эхлүүлсэн. | |
|--|--|--|--|--|---|--|

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

А.ДАМЦАГДОРЖ

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

О.НЯМБАТ

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.НАЦАГДОРЖ

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ж.ОРХОНБАЯР

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.НЯМ-ОЧИР

ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

Д.БУЛГАН

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА

А.ГЭРЭЛТ-ОД

ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА

Ж.ДАВААРАГЧАА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЦЭЦЭГМАА

БОЛОВСРУУЛСАН:
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ХЭЛТСИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР,
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ,
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.УРАНЦЭЦЭГ